



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

БОДЛОГЫН ХУРААМЖ

ТӨРИЙН АЛБАНЫ ЁС ЗҮЙ
АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

Улаанбаатар хот
2019 он

Хянан тохиолдуулсан: Дуламсүрэн

Боловсруулсан: Д.Нармандах
Д.Цэнд-Аюуш
Л.Нарантуяа

Энэхүү бодлогын хураамжийг боловсруулахад дэмжлэг үзүүлсэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад иргэн төвтэй төрийн албыг төгөлдөржүүлэх нь” төслийн нэгжийн удирдлага, хамт олонд талархал илэрхийлье.

Энэхүү эмхэтгэлд орсон шүүхийн шийдвэрүүдийг “Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан”(www.shuukh.mn)-аас түүвэрлэн авав.

Цаасны хэмжээ: А5
Хэвлэлийн хуудас: 6
Хэвлэсэн тоо: 6000

“УРАНГАР ПРЕСС” ХХК-д хэвлэв.

ЁС ЗҮЙН БОДЛОГО БОДОХ АРГАЧЛАЛ

Бодлого бодох нь ямар нэгэн бодит баримтын талаар асуулга тавих, тухай бүрийн тодорхой нөхцөлүүдэд юу чухал болохыг тодорхойлж, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, тохиолдол бүрд эргэцүүлэн бодож байх боломжийг олгодог.

Төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн тохиолдлыг шинжлэхдээ тухайн тохиолдол нь Монгол Улсын Үндсэн хууль болон төрийн албаны суурь зарчимтай хэрхэн нийцэж байгаад дүн шинжилгээ хийж, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль зэрэг бусад хууль, дүрмийн нарийн зохицуулалтаар баталгаажуулахад оршино. Учир нь хууль, дүрэм, журам, тогтоолууд Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байх ёстой.

Ямар салбар эрх зүйн хүрээнд үүссэн харилцаанаас хамаарч бодлого бодох аргачлалын алхам тус бүр өөр өөр байх шаардлагатай мэт боловч эрх зүйн ерөнхий дүгнэлт ижил гарах учиртай.

Төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн бодлого бодох тусгайлсан арга зам, нарийн тогтоосон стандарт, аргачлал байхгүй ч эрх зүйн үнэлэлт, дүгнэлт хийхдээ дараахь алхмаар тодорхойлж байна.

Нэгдүгээр алхам - Товч дүгнэлт

1. Өгөгдөлд нийтийн албан тушаалтан нь төрийн албан тушаалын аль ангилалд хамаарч байна гэдгийг ялгах;
2. Дараа нь төрийн албан хаагч-удирдлагын хооронд, төрийн албан хаагч-иргэний хооронд, төрийн албан хаагч-төрийн албан хаагчийн хооронд харилцаа үүссэнийг тогтоох;
3. Нийтийн албан тушаалтны хуулиар хүлээсэн үүргийг шалгах
4. Нийтийн албан тушаалтанд үүсч буй харилцааг хуулиар хориглосон, ямар харилцаанд хамаарах эсэхийг шалгах;
5. Төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой харилцаа мөн эсэхийг тодорхойлох;
6. Бодлогыг цаашид бодох шаардлага буй эсэхийг тогтоох;
7. Энэ бүхнийг дүгнэх.
8. Хэрэв өгөгдөлд туссан харилцаа төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн асуудалтай холбоогүй бол үндэслэлээ гаргаад дүгнэн, бодолтыг төгсгөнө.

Хоёрдугаар алхам - Асуудал дэвшүүлэх

1. Өгөгдлөөс хууль зүйн факт олох;
2. Үүн дээр тулгуурлаад асуудал дэвшүүлэх;
3. Төрийн байгууллага, болон төрийн өмчийн оролцоотой хуулийн

этгээд, нутгийн захиргааны байгууллагын зүгээс хэрэгжүүлэх арга хэмжээ мөн эсэхийг тогтоох, өөрөөр хэлбэл, төрийн албан хаагч, нийтийн албан тушаалтан үйлдсэн эсэхийг шалгах;

4. Асуудал нь хуулийн хэм хэмжээ ашиглах шалгах шаардлагатай бүхий л асуудлыг хамарсан, логик дэс дараалалтай байх учиртай.

Гуравдугаар алхам - Эрх зүйн зохицуулалтыг олох

1. Дэвшүүлсэн асуудлыг шалгахад шаардагдах хууль, хэм хэмжээний актыг сонгох;
2. Сонгосон хуулиас зайлшгүй хэрэгтэй зүйл, заалтыг сонгох;
3. Холбогдох хуулиуд дахь өрсөлдөх хэм хэмжээг сонгох;
4. Бодит үйлдэл, эс үйлдлийг тодорхойлох.

Дөрөвдүгээр алхам - Дүн шинжилгээ хийх

1. Дэвшүүлсэн асуудлыг сонгосон хэм хэмжээний дагуу бодлогын өгөгдөлд тулгуурлан шалгах;
2. Хуулийн хэм хэмжээг өгөгдөлд нийцүүлэн тайлбарлах;
3. Тухайн фактууд хууль зөрчсөн, үгүй эсэхийг дүгнэх.

Тавдугаар алхам - Эцсийн дүгнэлт хийх

1. Өмнө хийсэн бүх зүйлээ цэгцтэй нэгтгэн дүгнэх;
2. Өгөгдөлд тусгасан харилцаанд төрийн албан хаагч, нийтийн албан тушаалтны зөв, буруу болохыг тогтоох;
3. Холбогдох хууль, зүйл, заалтыг сонгоод төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүй нь тэдгээрт нийцэж буйг шалган тогтоох;
4. Хэрэв хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд гаргасан шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүй байвал зөвтгөх үндэслэлийг гаргах.

-----000-----

САНАМЖ

Төрийн албаны эрхэм зорилго нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэхэд оршино.

Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д зааснаар Төрийн албанд Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчмаас гадна дараахь зарчмыг баримтална:

7.1.1. ард түмэнд үйлчлэх;

7.1.2. мэргэшсэн, тогтвортой байх;

7.1.3. улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх;

7.1.4. Монгол Улсын иргэн төрийн алба хаах адил тэгш боломжоор хангагдах;

7.1.5. төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг баримтлах;

7.1.6. ил тод байх;

7.1.7. ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

7.1.8. захирах, захирагдах ёсыг баримтлах.

Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын иргэн төрийн захиргааны албанд анх орохдоо: *“Эх орон, ард түмнийхээ төлөө эрдэм чадлаа зориулж, Монгол Улсын хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэхээ тангараглая. Тангаргаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ”* хэмээн тангараг өргөж баталгаажуулна.

Төрийн байгууллага Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д заасан авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр дараахь нийтлэг үүргийг хүлээдэг:

- төрийн албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, эрхэлж байгаа ажлын онцлогтой нь холбогдуулж түүнд хориглох зүйлийг Төрийн албаны тухай хууль болон энэ хуульд заасны дагуу тогтоон мөрдүүлэх
- төрийн байгууллага тухайн салбарын албан хаагчийн ёс зүйн дүрмийг батлан гаргахын өмнө Авлигатай тэмцэх газраас санал авах.

Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд дор дурдсан албан тушаалтан хамаардаг. Үүнд:

- ⇒ төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;
- ⇒ төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч;
- ⇒ төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;
- ⇒ олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал;
- ⇒ улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;
- ⇒ Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч;
- ⇒ бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч;
- ⇒ эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан;
- ⇒ Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4.1.7-д заасан Ирээдүйн өв сан корпорацийн эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар нийтийн албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт, ёс зүйн шаардлагын үндэслэл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, албан тушаалтан хувийн ашиг сонирхлын байдлаа мэдүүлэх болон түүнийг шалгах ажиллагаа, хууль тогтоомжийг зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг зохицуулдаг.

Дээрх хуулийн хуулийн үйлчлэлд Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд заасан албан тушаалтан нэгэн адил хамаардаг.

Иймд дээрх нийтийн албан тушаалтанд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас гадна Төрийн албаны тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, эрх бүхий этгээдээс батлан мөрдүүлж буй салбарын албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд мөрдөж, сахин биелүүлэх шаардлага тавигдаж байна.

Тиймээс бодлого бодох явцад нийтийн албан тушаалтанд хамаарч байгаа албан хаагчийн хувьд тухайн байгууллагын ёс зүйн дүрмээр зохицуулагдаагүй хэм хэмжээ байхыг үгүйсгэхгүй боловч цаашид удирдах албан тушаалтны хувьд албан хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг тогтоон хэвшүүлэх, ёс зүйн байдалд хяналт тавих нь зүйтэй.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар нийтийн албан тушаалтан үйл ажиллагааны дараахь зарчмыг баримтална.

6.1. Албан тушаалтан нь хууль дээдлэх зарчимд захирагдан, албан үүргээ иргэдийн итгэл хүлээхүйц, тэгш, шударга, хариуцлагатайгаар гүйцэтгэж, албаны ёс зүйг сахина.

6.2. Албан тушаалтан нь хууль тогтоомжд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хариуцлага хүлээнэ.

6.3. Албан тушаалтан албаны бүрэн эрхээ хувийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн зорилгод ашиглахгүй бөгөөд албан үүрэгт нь нөлөөлөхүйц аливаа харилцаанаас ангид байна.

6.4. Албан тушаалтан иргэний болон хуулийн этгээдийн зүгээс тавьсан албан үүрэгтэй нь зөрчилдөх хувийн ашиг сонирхлын асуудал болон зан байдлыг тэвчиж, албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхлыг хувийн болон тусгай ашиг сонирхлоос илүүд үзнэ.

6.5. Албан тушаалтан ашиг сонирхлын зөрчилд орж болох нөхцөл байдлыг мэдэгдэх, түүнээс татгалзах замаар урьдчилан сэргийлнэ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т заасны дагуу төрийн байгууллагын удирдлага ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараахь арга хэмжээг авах үүрэгтэй:

7.2.1. ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоож, мөрдүүлэх;

7.2.2. хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу авах, бүртгэх, хянан шалгах;

7.2.3. ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах ажлыг зохион байгуулах, мэдээлэл, мэдэгдлийн дагуу шалгах, хариуцлага хүлээлгэх;

7.2.4. ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд хуульд заасан эрх мэдлээ хэрэгжүүлэхийг зөвшөөрөхгүй байх;

7.2.5. ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг арилгах талаар бичгээр зөвлөмж өгөх;

7.2.6. энэ хууль болон Засгийн газраас баталсан журмаар зөвшөөрсөн тохиолдолд өөрийн удирдлагад байгаа албан тушаалтан давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх.

7.3. Энэ хуулийн 7.2.2, 7.2.3-т заасан шалгалтын явцад авлигын шинжтэй зөрчил илэрсэн бол Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулна.

БОДЛОГЫН ХУРААНГУЙ

Бодлого 1

Нийслэлийн нэгэн дүүргийн 10 дугаар хорооны задгайд оршин суух иргэн Эрдэнэчулуун дүүргийн Засаг даргад 2018 оны 1 дүгээр сард өрхийн хэрэгцээний 0.7 га газар эзэмших тухай хүсэлт гаргаснаас хойш 3 сарын хугацаа өнгөрсөн боловч хариу өгөөгүй байна. Тэрээр Дүүргийн газрын албаны дарга Тулгатай уулзахад “иргэдийн өргөдөл ихтэй, хуульд заасан болзол, нөхцөл, шаардлага хангасан эсэхийг судалж, Засаг даргад танилцуулна” гэжээ. Иргэн Эрдэнэчулуун тухайн үед Цэргийн баярыг тохиолдуулан Тулгад үнэтэй цаг бэлэглэсэн байна. Долоо хоногийн дараа иргэн Эрдэнэчулуунд газар эзэмшүүлэх шийдвэр гарсан тухай хариу ирсэн байна.

Асуулт:

Дүүргийн газрын албаны дарга Тулга төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн үү?

Хариулт:

Тийм.

Монгол Улсын Үндсэн хуульд төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй гэж иргэний үндсэн эрхийг баталгаажуулсан.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1-д төрийн байгууллага, албан тушаалтан өргөдлийг хугацаанд нь барагдуулах, дурдсан асуудал бүрийг эрх хэмжээнийхээ хүрээнд хянан үзэж, үндэслэлтэй шийдвэрлэх ёстой.

Мөн төрийн албан хаагч Тулга Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7-д зааснаар “төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх”, 37.1.12-т зааснаар төрийн үйлчилгээг чирэгдэлгүйгээр чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэх, төрийн үйлчилгээг хүргэхдээ аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх үүрэгтэй.

Гэтэл төрийн жинхэнэ албан хаагч Тулга иргэн Эрдэнэчулууны өргөдлийг хүлээн авч дурдсан асуудлыг бүх талаас нь судлан үзэж, хууль тогтоомжид нийцүүлэн хэрхэн шийдвэрлэсэн талаараа хугацаанд нь хариу өгөх үүргээ биелүүлэхгүй иргэнийг 3 сар чирэгдүүлсэн байна.

Төрийн албан хаагч албан үүргийн дагуу хийх ёстой үйлдлийг хийж гүйцэтгэхгүй байгаа, бусдыг чирэгдүүлэн хүнд суртал гаргаж буй үйлдэл төрд итгэх олон нийтийн итгэлийг бууруулж, төрийн албаны нэр

хүндэд сөргөөр нөлөөлөхийн зэрэгцээ төрийн албан хаагч бусдаас хээл хахууль, шан харамж, бэлэг сэлт авсны үндсэн дээр шийдвэр гаргадаг гэх хардлагыг иргэдэд төрүүлэх сөрөг үр дагавартай.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бусдаас бэлэг шууд буюу шууд бусаар авахыг хориглоно” гэж заасан байна. Гэтэл төрийн албан хаагч Тулга албан үүрэгтэй нь холбогдуулан аливаа этгээд бэлэг санал болгосон тохиолдолд саналаас татгалзах¹ арга хэмжээг авах ёстой байтал иргэн Эрдэнэчулуунаас үнэтэй бэлэг хүлээж авсан.

Тэрээр нийтийн албан тушаалтны хувьд албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нөлөөлж буй иргэн Эрдэнэчулууны хууль бус үйлдлийн талаар өөрийн удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий байгууллагад, хуулийн хариуцлага хүлээхээр бол Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх² үүргээ биелүүлээгүй байна.

Учир нь төрийн албан хаагч үг, үйлдлээрээ Үндсэн хууль, бусад хуулиар баталгаажуулсан хууль ёсыг эрхэмлэн дээдлэх зарчмыг илэрхийлэн сахина гэсэн, шударга ёсыг дээдэлж, хувийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна”³ гэсэн ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөж ажиллах ёстой.

Гэтэл төрийн албан хаагч Тулга Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 3.1.1.б-д заасан “хууль бус үйлдэлтэй эвлэршгүй байж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлэх”, мөн дүрмийн 3.1.2.г-д заасан “албан үүргээ гүйцэтгэхдээ ашиг сонирхол нь хөндөгдөх иргэнээс бэлэг авахгүй байх” ёс зүйн биелүүлээгүй зөрчсөн байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл нь сахилгын болон захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хуулийн дагуу хариуцлага ногдуулах үндэстэй.

Иймд нийтийн албан тушаалтан Тулгын албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бусдаас бэлэг авахыг хориглоно⁴ гэсэн хуульд заасан хориглолтыг зөрчсөн хууль бус үйлдэлд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.4-т заасан нийтийн албанаас халах сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэлтэй юм.

Тухайлбал, хууль бусаар хүлээн авсан бэлэгний үнэ хөлсийг төлүүлж, нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нийтийн албанаас

1 НАНБХАСЗАСЗУСТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.2.1

2 НАНБХАСЗАСЗУСТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.1

3 Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм 2.1

4 НАНБХАСЗАСЗУСТХ-16 дугаар зүйлийн 16.1

халах сахилгын шийтгэл шүүгч хүлээлгэхээр дээрх хуулиар зохицуулсан байдаг. Шүүгчээс захиргааны хариуцлага хүлээлгэсэн нь тухайн албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгэхийг хязгаарлах үндэслэл болохгүй юм.

Мөн төрийн албан хаагч Төрийн албаны тухай хуулийн 37, 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн тохиолдолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдснийг нь харгалзан төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах⁵ бөгөөд сахилгын шийтгэлийг заавал дэс дараалан хэрэглэхийг шаардахгүй.

Нэмэлт тайлбар:

Хэрэв Дүүргийн газрын албаны дарга Тулгань иргэн Эрдэнэчулуунтай уулзахдаа хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албаны чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд шууд, эсхүл шууд бусаар хахууль өгөхийг шаардсан бол энэхүү үйлдэл нь Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн 22.4.2-д заасан гэмт хэргийн шинжийг агуулсан үйлдэл болдог.

Бодлого 2

2018 оны 7 сард нэгэн яамны Гадаад харилцааны хэлтэст мэргэжилтний сул орон тоо гарсан байна. Яамны төрийн албан хаагчдаас уг орон тоог нөхөх ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулсан. Гэтэл Төрийн нарийн бичгийн дарга Дорж ажлын хэсгийн ахлагч Дулмааг дуудаж, гадаадад олон жил суралцсан Дондогийг шалгаруулах үүрэг өгсөн байна. Гэвч Дондог монгол хэлний бичгийн чадварын шалгалтыг хангалтгүй өгсөн тул ажлын хэсгийн гишүүд “тэнцэхгүй” гэсэн шийдвэр гаргасан байна.

Асуулт:

Яамны төрийн нарийн бичгийн дарга Доржийн үйлдэл ёс зүйн зөрчилд тооцогдох уу?

Бодолт:

Тийм.

Дорж нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д зааснаар авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах нийтийн албан тушаалтан. Иймд нийтийн албан тушаалтны хувьд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах ёстой.

5 Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1

Төрийн албанд төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг баримталж⁶, хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнг хамгийн сайн хангасан хүнийг шалгаруулах шаардлага тавигдсан.

Төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас⁷ томилох эрх бүхий албан тушаалтан уг орон тоог нөхөх замаар төрийн жинхэнэ албан хаагчийг томилохдоо чадахуйн зарчмыг шалгуур болгоно.

Тиймээс төрийн албан хаагч Дорж албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх үүрэгтэйгээс гадна нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх, шударга бус явдалтай эвлэрэхгүй байх ёстой.

Дорж албаны бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ албан тушаалтанд хуульд нийцээгүй үүрэг, даалгавар өгөх, биелүүлэхийг шаардахыг хориглосон⁸ байтал зөрчиж удирдлагадаа байгаа албан тушаалтанд төрийн жинхэнэ албан хаагчид тавигдах шаардлага хангаагүй Дондогийг төрийн албанд тэнцсэн шийдвэр гаргахыг үүрэг болгосон байна.

Төрийн захиргааны албан хаагч Дорж төрийн албаны чиг үүргийг хэрэгжүүлэхдээ үйл ажиллагаандаа “зан суртахуун, үг, үйлдлээрээ Үндсэн хууль, бусад хуулиар баталгаажуулсан хууль ёсыг эрхэмлэн дээдлэх зарчмыг илэрхийлэн сахина”⁹ гэсэн ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөх журамтай. Гэтэл Дорж нь Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 3.1.1.е-д заасан “бусад албан хаагчийн үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх, хууль бус үйлдэл хийхийг шаардахгүй байх” ёс зүйн шаардлагыг зөрчсөн байна. Төрийн захиргааны албан хаагч нь төрийн албан хаагчийн ёс зүйн шаардлагыг зөрчсөн төрийн албан хаагчид зөрчлийн шинж байдлыг харгалзан уучлал гуйхыг үүрэг болгох, сануулах шийтгэл¹⁰ хүлээлгэх зохицуулалттай.

Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл нь сахилгын болон захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хуулийн дагуу хариуцлага ногдуулна.

Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1-д “албан тушаалтанд хуульд нийцээгүй үүрэг, даалгавар өгөх, биелүүлэхийг шаардах”-ыг хориглохоор тусгасан бөгөөд зөрчсөн тохиолдолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-д

6 Төрийн албаны тухай хуулийн 7.1.5

7 Төрийн албаны тухай хуулийн 27.1.2

8 Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1 дэх хэсэг

9 Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 2.1

10 Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 4.2.

заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулах бөгөөд сахилгын шийтгэлийг заавал дэс дараалан хэрэглэхийг шаардахгүй.

Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д нийтийн албан тушаалтанд албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглосон ба тус хуулийн 7.1-д заасныг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий байгууллага, албан тушаалтан албан тушаал бууруулах, хэрэв албан тушаалыг нь бууруулах боломжгүй албан тушаал бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, авлигын зөрчилтэй нөхцөлд гарсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгох хариуцлагыг хүлээлгэдэг.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “нийтийн албан тушаалтанд өөрийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргахад өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглосон бөгөөд зөрчсөн тохиолдолд нийтийн албанаас халах”¹¹ захиргааны шийтгэлийг шүүгч хүлээлгэнэ гэж заасан.

Дээрх хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасны дагуу сахилгын шийтгэл хүлээсэн албан тушаалтан өөрт ногдуулсан шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх үүрэгтэй. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 7.1-д заасны дагуу томилох эрх бүхий албан тушаалтан төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг тухайн төрийн албан хаагчийн хувийн хэрэгт тэмдэглэж, байгууллагын дотоод сүлжээнд байршуулан мэдээлнэ.

Тухайн тохиолдолд Дулмаа хуулийн дагуу ямар үүрэг хүлээдэг вэ?

Бодлого 3

Нэгэн аймгийн Цагдаагийн газрын дарга Ваанжил амралтын өдрийг найз нартайгаа салхинд гарах, анд явах, загасчлах зэргээр өнгөрүүлэхдээ албаны автомашиныг хэрэглэдэг. Тэрээр хөдөө явах бүртээ ерөнхий нягтлан бодогч Борд автомашинд түлш хангалттай хийх үүрэг өгдөг. Ваанжил дарга амралтын өдрүүдээр хөдөө явахаар Борд ээлжит үүргээ өгөхөд тэрээр байгууллагын албан томилолт, унааны зардал хэтэрсэн тул дахин албаны бус ажилд өөрөөсөө бензинээ гаргахгүй бол боломжгүй талаар учирлахад Ваанжил илт дургүйцэж дээд шатны албан тушаалтны шийдвэр биелүүлээгүй гэсэн үндэслэлээр Борд сахилгын шийтгэл ногдуулсан байна.

11 Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.4

Асуулт:

Байгууллагын дарга Ваанжил төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үү?

Бодолт:

Тийм.

Төрийн жинхэнэ албан хаагч Ваанжил нь Төрийн албаны тухай хуульд зааснаар Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлж, нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүй¹² байх үүрэгтэй. Тиймээс төрийн албан хаагч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд цаг ямагт үг, үйлдлээрээ хууль ёсыг эрхэмлэн дээдлэх зарчмыг чанд мөрдөж байгаагаа илэрхийлэн харуулах ёстой.

Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1-д төрийн жинхэнэ албан хаагч нь албан тушаалтанд хуульд нийцээгүй үүрэг, даалгавар өгөх, биелүүлэхийг шаардахыг хориглосон. Гэтэл Ваанжил хувийн хэрэгцээндээ зориулж долоо хоног бүр автомашины шатахууны зардал гаргах талаар удирдлагадаа байгаа албан тушаалтанд үүрэг өгсөн нь хуульд нийцээгүй үүрэг төдийгүй, албан тушаалтнаас биелүүлэхийг шаардах эрхгүй юм.

Учир нь төрийн албан хаагч албаны бус зорилгод байгууллагын эд хөрөнгийг ашиглан завших¹³-ыг хориглосон байтал төрийн жинхэнэ албан хаагч Ваанжил байгууллагын эд хөрөнгө болох автомашиныг хувийн хэрэгцээнд ашиглах, төсвийг зориулалтын бусаар зарцуулах, батлагдсан төсвийг хэтрүүлэх зэрэг зөрчил гаргасан гэж үзэх үндэслэлтэй.

Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлд зааснаар нийтийн албан тушаалтан Ваанжил албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах¹⁴ зэрэг авлигын зөрчил гаргахыг хориглосон байна.

Гэтэл Ваанжил Борд хувийн хэрэгцээндээ байгууллагын төсвөөс хөрөнгө гаргуулах хуульд нийцээгүй үүрэг, даалгавар байнга өгч, улмаар анхааруулгыг үл тоож төрийн албан хаагчид удирдлагаас өгсөн үүргийг биелүүлээгүй үндэслэлээр сахилгын шийтгэл ногдуулж дарамт шахалт үзүүлсэн гэж үзэх үндэстэй юм.

Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6-д зааснаар Бор дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх бөгөөд улмаар хийсэн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн төлөө өөрөө бүрэн хариуцлага хүлээх үүрэгтэй.

Тиймээс удирдах албан тушаалтан Ваанжилын хууль зөрчсөн үйлдэл байнгын шинжтэй болж батлагдсан төсөв хэтэрсэн тул төрийн албан

12 Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.2,

13 Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.11,

14 Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.4,

хаагч Бор удирдлагын санаа бодолд нийцэх эсэхийг үл харгалзан тэдний гаргах шийдвэрээс үүдэн гарч болзошгүй сөрөг үр дагаврыг урьдчилан анхааруулах¹⁵ хуульд заасан үүргээ биелүүлж мэдэгдсэн байна. Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-д зааснаар төрийн албан хаагч нь хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 37, 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн, тохиолдолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдснийг нь харгалзан төрийн жинхэнэ албан хаагчид дараахь сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулна. Үүнд:

48.1.1.сануулах;

48.1.2.албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;

48.1.3.төрийн албанаас халах;

48.1.4.төрийн албанд гурван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах;

48.1.5.хуульд заасан бусад

Төрийн албан хаагчид хүлээлгэх сахилгын шийтгэлийг заавал дэс дараалан хэрэглэхийг шаардахгүй тул тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдснийг нь харгалзан дээрх шийтгэлийг ногдуулна.

Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах нь түүнийг төрийн албанаас чөлөөлөх, төрийн албанд дахин авахаас татгалзах үндэслэл болох бөгөөд харин түүнийг эрүүгийн болон бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Аймгийн Цагдаагийн газрын дарга Ваанжил нь Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/129 дүгээр тушаалаар баталсан “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 2.3.8-д заасан “байгууллагын өмч хөрөнгө, техник хэрэгслийг албаны бус зориулалтаар ашиглахгүй байх” ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн байна.

Ёс зүйн зөрчил гаргасан цагдаагийн албан хаагчид эрх бүхий албан тушаалтан Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4-т заасан сахилгын шийтгэлийн аль нэгийг тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг харгалзан дэс дараалан хэрэглэхгүйгээр оногдуулна. Сахилгын шийтгэл хүлээсэн алба хаагч Цагдаагийн албаны тухай хуулийн 81.6 дахь хэсэгт заасны дагуу ёс зүйн сургалтад хамрагдах үүрэгтэй гэж заасан байна.

¹⁵ Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.14,

Бодлого 4

Нэгэн аймгийн Засаг даргын Тамгын газрын ерөнхий нягтлан бодогч Ёроо санхүүгийн тайлан гаргахдаа алдаатай, анхан шатны баримтуудыг зөрүүтэй бүрдүүлж, бүртгэлд тусгаагүй зэрэг санхүүгийн зөрчил гаргасан байна. Аймгийн Засаг дарга буюу төсвийн ерөнхийлөн захирагч Сүмбэр байгууллагын санхүүгийн нэгдсэн тайланг үнэн зөв, үндэслэл бүхий гэж үзээд санхүүгийн нэгдүгээр гарын үсэг зурж баталгаажуулсан байна. Гэтэл аймгийн Аудитын газрын шалгалтаар санхүүгийн ноцтой зөрчлүүд илэрч, улмаар “хязгаарлалттай” дүгнэлттэй гарсан байна.

Асуулт:

Төрийн албан хаагч Ёроо ёс зүйн зөрчил гаргасан уу?

Бодолт:

Тийм.

Төрийн албанд төрийн албан хаагчийг сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж, урамшуулах асуудлыг шийдвэрлэхдээ хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлаж байна.

Тиймээс төрийн албан хаагч өөрийн мэдлэг, чадвараа байнга хөгжүүлж хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх¹⁶ үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллах нь төрийн албан хаагчийн хувьд өөрөөс нь хамаарч байна.

Төрийн албаны тухай хуулийн 37 зүйлийн 37.1.13-т зааснаар төрийн жинхэнэ албан хаагч Ёроо албаны үүргээ гүйцэтгэхдээ албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах үүрэгтэй байтал санхүүгийн тайланг алдаатай боловсруулж, анхан шатны баримтуудыг зөрүүтэй бүрдүүлэн, бүртгэлд тусгаагүй байна.

Мөн төрийн албан хаагч Ёроо дээд шатны албан тушаалтныг шийдвэр гаргахад нь хуульд нийцсэн, бодит баримт нотолгоонд тулгуурласан, үндэслэл бүхий үнэн зөв мэдээлэл, мэргэшлийн зөвлөгөөгөөр хангах¹⁷ үүргээ биелүүлээгүй байна.

Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн 3.1 дэх хэсэгт зааснаар Мэргэжлийн нягтлан бодогч нь мэргэжлийн ажил үүргээ хэрэгжүүлэхдээ шударга, мэргэжлийн ур чадвар, хянамгай байх ёс зүйн хэм хэмжээг мөрдөх ёстой. Тухайлбал, мэргэжлийн нягтлан бодогчийн бэлтгэсэн, хянасан буюу баталсан санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдааг агуулаагүй байвал зохих бөгөөд ашигласан бүртгэл, санхүү, бизнесийн үйл ажиллагааны анхны баримт нь бодитой буюу

¹⁶ Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8

¹⁷ Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.15

хуурамч бус байх, дансны бичилт, тооцоо нь арга зүйн болон тооцооллын алдаагүй байх, гаргасан тайлан мэдээ, тодруулга, тайлбар нь хуурамч бус байх шаардлага тавигддаг.

Төрийн захиргааны албан хаагч Ёроо нь Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд зааснаар үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, бусад дүрэм, журмыг чанд баримталж, ёс зүйн хэм хэмжээг мөрдөнө.

Өөрөөр хэлбэл, төрийн захиргааны албан хаагч нь харьяалах дээд шатны албан тушаалтныг хуульд нийцсэн, бодит баримт нотолгоонд тулгуурласан, үндэслэл бүхий үнэн зөв мэдээллээр хангах¹⁸ ёс зүйн шаардлагыг биелүүлж ажиллах байтал санхүүгийн алдаатай тайлангийн талаар удирдлагад үнэн зөв мэдээлэхгүй, нуун дарагдуулснаас зөрчил гарсан гэж үзэх үндэслэлтэй байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл нь сахилгын болон захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хуулийн дагуу хариуцлага ногдуулах зохицуулалттай.

Төрийн албаны тухай хуулийн 37, 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн төрийн албан хаагчид тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдснийг нь харгалзан мөн хуулийн 48 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэл ногдуулна гэж заасан байна.

Бодлого 5.

Яамны газрын дарга Баатар сургуульд анх орох хүүхдээ математикийн гүнзгийрүүлсэн сургалттай нэгэн сургуульд суралцуулах хүсэлтэй. Тэрээр албан үүргийн дагуу тус сургуулийн хичээлийн жилийн бэлтгэл ажиллагаатай танилцаж явахдаа сургуулийн захиралд намар хүүхдээ бүртгэж авахыг даалгасан байна. Гэтэл сургуулийн удирдлага “манай сургууль харъяаллын хүүхдийг бүртгэж авдаг тул туслах боломжгүй” гэдгээ хэлсэн.

Асуулт:

Баатар төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн үү?

Бодолт:

Тийм.

Монгол Улсын Үндсэн хуульд “төрийн жинхэнэ албан хаагч Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж ард түмнийхээ тусын тулд, иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана” гэж заасан.

Төрийн жинхэнэ албан хаагч Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1-д зааснаар Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэхээс гадна ард түмнийхээ

¹⁸ Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 3.1.1.в

тусын тулд иргэний ёсоор үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан өөрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажиллах¹⁹ үүрэгтэй.

Тиймээс төрийн албан хаагчид албаны бүрэн эрхээ хэрэгжүүлж байхдаа албан тушаалтанд хуульд нийцээгүй үүрэг даалгавар өгөхийг²⁰ хориглосон байна.

Мөн Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д нийтийн албан тушаалтан албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт үзүүлэх, хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглосон бөгөөд албан үүргээ иргэдийн итгэл хүлээхүйц, шударга, хариуцлагатайгаар гүйцэтгэх зарчмыг үйл ажиллагаандаа баримтлах ёстой.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т “нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хувийн зорилгод ашиглахгүй, албан үүрэгт нь нөлөөлөхүйц аливаа харилцаанаас ангид байх” зарчмыг баримтална гэж заасан.

Мөн нийтийн албан тушаалтанд өөрийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргахад албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр бусдад хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглосон²¹ байна.

Төрийн албан хаагч үг, үйлдлээрээ Үндсэн хууль, бусад хуулиар баталгаажуулсан хууль ёсыг эрхэмлэн дээдлэх зарчмыг илэрхийлэн сахина²² гэсэн ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөх үүрэгтэй.

Гэтэл төрийн албан хаагч Баатар нь өөрийн хүүхдийг суралцуулахын тулд тус сургуулийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх явцдаа сургуулийн захиралд хүүхдээ бүртгэж авахыг даалгаж буй үйлдэл нь Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 3.1.1.е-д заасан “бусад албан хаагчийн үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх, хууль бус үйлдэл хийхийг шаардахгүй байх” гэсэн ёс зүйн шаардлагыг биелүүлээгүй гэж үзэх үндэстэй.

Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл нь сахилгын болон захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хуулийн дагуу хариуцлага ногдуулна гэж дүрэмд заасан байна.

Хэрвээ төрийн албан хаагч Баатарын саналыг сургуулийн захирал хэрвээ хүлээн авч хууль бус шийдвэр гарсан тохиолдолд төрийн албан хаагчид захиргааны, сахилгын шийтгэл хүлээлгэх, хариуцлага тооцох эрх зүйн үр дагаврууд бий болно.

Тухайлбал, нийтийн албан тушаалтан Баатарын хувьд төрийн албан хаагчид шийдвэр гаргахад нөлөөлөх хориглолтыг зөрчсөн үйлдэлд шүүгч түүнд нийтийн албанаас халах захиргааны хариуцлага хүлээлгэх²³ эрх

19 Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.3 дах хэсэг,

20 Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1 дэх хэсэг

21 НАНБХАСЗАСЗУСТХ - 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалт

22 Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 2.1.1

23 НАНБХАСЗАСЗУСТХ- 29 дүгээр зүйлийн 29.2.4 дэх

зүйн зохицуулалттай. Шүүгчээс нийтийн албан тушаалтанд захиргааны хариуцлага хүлээлгэсэн нь тухайн албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгэхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

Харин сургуулийн захирлын хувьд хууль бус нөлөөллийг холбогдох газарт мэдээлээгүй, хуульд нийцээгүй шийдвэр гаргахыг хориглосон үйлдлийг зөрчсөн үйлдэлд сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэлтэй.

Төрийн албан хаагч нь албаны бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ өөрийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн төрийн албан хаагчийг хууль бус шийдвэр гаргахаар шаардаж үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс нөлөөлж улмаар хууль бус шийдвэр гаргуулсан үйлдэл нь Төрийн албаны тухай хуулийн 37, 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн гэж үзвэл төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулахаар²⁴ заасан байна.

Бодлого 6

Дүүргийн ЗДТГ-ын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн албан хаагчид өөрсдийн хяналт тавих чиг үүрэгт хамаардаг “Ертөнц” ресторанд шинэ жилийн баяраа тэмдэглэжээ. 23 цаг болоход менежер Онон захиалгын цаг хэтэрсэн, мөн үйлчилгээний газрын хаах цаг болсныг мэдэгдсэн байна. Гэтэл хэлтсийн дарга Туул менежерийг дуудаж “бидний захиалсан хоол амт чанар муутай, хүйтэн байсан” гэх зэргээр загнан, цаг сунгахыг шаарджээ. Менежер Онон шаардлагыг нь хүлээж аваагүй тул Туул албан тушаалаараа далайлган сүрдүүлсэн байна.

Асуулт:

Төрийн албан хаагч Туул төрийн албан хаагчийн ёс зүй зөрчсөн үү?

Бодолт:

Тийм.

Төрийн албаны тухай хуульд зааснаар төрийн албан хаагч нь ард түмнийхээ тусын тулд өөрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажиллах²⁵, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх үүрэгтэй тул албан үүргээ гүйцэтгээгүй үед ч бүдүүлэг зан авир гаргахыг цээрлэж, олон нийтийн газарт мөрдөх дэг журмыг сахих²⁶ ёс зүйн шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд зааснаар төрийн албан хаагч нь үйл ажиллагаандаа “зан суртахуун, үг, үйлдлээрээ Үндсэн хууль, бусад хуулиар баталгаажуулсан хууль ёсыг эрхэмлэн дээдлэх зарчмыг илэрхийлэн сахина” гэсэн ёс зүйн хэм хэмжээг мөрдөх үүрэгтэй.

Туул нь “Ертөнц” ресторанаас үнэ төлбөргүй болон хөнгөлөлттэй

24 Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1

25 Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.3, 37.1.7

26 Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 3.1.4

үнээр үйлчилгээ аваагүй боловч олон нийтийн газарт мөрддөг дэг журмыг зөрчин, илүү цагаар ажиллахыг шаардсан нь төрийн албан хаагч албаны нэрийг барьж бусдыг аливаа хэлбэрээр дарамтлах²⁷-ыг хуулиар хориглосон хэм хэмжээг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй.

Дүүргийн ЗДТГ-ын албан хаагчид үйлчилгээний газарт мөрдөгдөж буй цагийн хуваарийг сунгахыг шаардаж улмаар албаны чиг үүрэгт хамаарах хяналтын үйл ажиллагааг явуулах, зүй зохисгүй үйлдэл гаргаж төрийн албаны нэрийг барьж дарамтлах, загнах зэрэг ёс зүйгүй үйлдэл гаргасан байна.

Төрийн албан хаагч нь дээр дурдсан ёс зүйн дүрмийн 3.1.4.б-д “төрийн албаны нэр хүндэд харшлах аливаа үйлдлийг цээрлэх” хэм хэмжээг зөрчин олон нийтийн газарт бусад иргэний адил биеэ авч яваагүй байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн төрийн албан хаагчид зөрчлийн шинж байдлыг харгалзан уучлал гуйхыг үүрэг болгох, сануулах ёс зүйн хариуцлага хүлээлгэх зохицуулалттай. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл нь сахилгын болон захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хуулийн дагуу хариуцлага ногдуулдаг.

Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-д зааснаар төрийн албан хаагч нь хуульд өөрөөр заагаагүй бол уг хуулийн 37 дугаар зүйлд заасныг зөрчсөн тохиолдолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдснийг нь харгалзан төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах бөгөөд сахилгын шийтгэлийг заавал дэс дараалан хэрэглэхийг шаардахгүй тул тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдснийг нь харгалзан шийтгэл ногдуулахаар заасан байна.

Бодлого 7

Сумын Засаг дарга Довчин нь сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудыг хамруулан тамхи худалдан борлуулахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлын хэсэг байгуулах тухай захирамж гаргажээ. Ажлын хэсгийн шалгалтаар “Ундрам” ХХК нь Тамхины хяналтын тухай хуульд заасан зөрчил гаргасан нь тогтоогдсон тул компанийн тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг цуцлах шийдвэр гаргах болсон талаар компанийн захиралд ажлын хэсгийн ахлагч мэдэгдсэн байна. Гэтэл аймгийн Засаг дарга Доёд сумын Засаг дарга Довчинтой уулзан “Ундрам” ХХК-ийн тамхи худалдаалах эрхийг цуцлахгүй байх үүрэг өгчээ. Уг компани нь аймгийн Засаг даргын төрсөн ах Товуугийн үүсгэн байгуулж, хувь эзэмшдэг компани байсан байна.

27 Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4

Асуулт:

Дүгнэлт хийнэ үү, Аймгийн Засаг дарга Доёдод хариуцлага хүлээлгэх үндэслэл бий юу?

Бодолт:

Засаг дарга Доёдод хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй.

Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д нийтийн албан тушаалтанд албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглосон ба эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий байгууллага, албан тушаалтан тус хуулийн 7.1-д заасныг зөрчсөн этгээдэд албан тушаал бууруулах, хэрэв албан тушаалыг нь бууруулах боломжгүй албан тушаал бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, авлигын зөрчилтэй нөхцөлд гарсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгох хариуцлагыг хүлээлгэдэг.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д нийтийн албан тушаалтанд өөрийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргахад өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглосон бөгөөд зөрчсөн тохиолдолд тухайн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол нийтийн албанаас халах²⁸ захиргааны шийтгэлийг шүүгч хүлээлгэнэ гэж заасан.

Дээрх хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасны дагуу сахилгын шийтгэл хүлээсэн албан тушаалтан өөрт ногдуулсан шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх үүрэгтэй.

Төрийн улс төрийн албан тушаалтны ёс зүйн хэм хэмжээг одоогоор тогтоон мөрдүүлээгүй хэдий ч аймаг, нийслэлийн Засаг дарга нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д зааснаар нийтийн албан тушаалтан мөн. Иймд Засаг дарга нийтийн албан тушаалтныхаа хувьд дээрх хуульд заасан албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалтыг мөрдөн ажиллана.

Сумын Засаг дарга Довчин ямар хариу үйлдэл үзүүлэх үүрэгтэй вэ?

28 Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.4

Бодлого 8

Дүүргийн Татварын хэлтсийн улсын байцаагч Ванданг “Эрдэм” ХХК 15 жилийн ойн баяртаа урьсан байна. Тэрээр албан үүргийн дагуу тус компанийн татварын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг бөгөөд тухайн компанийн татварын тайлан гаргах ажилд байнга тусалдаг, “Эрдэм” компаниас түүнд санхүүгийн дэмжлэг, хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлдэг байжээ. Вандан удахгүй тус компани дээр татварын хяналт шалгалтаар ажиллах гэж байгааг мэдэж байсан боловч урилгыг хүлээн авч ойн арга хэмжээнд оролцсон байна.

Асуулт:

Татварын улсын байцаагч Вандан төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үү.

Бодолт:

Тийм.

Төрийн албаны тухай хуульд зааснаар татварын байцаагч Вандан нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүй байж, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллах, үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх²⁹ үүрэгтэй.

Гэтэл төрийн албан хаагч Вандангийн албан үүргийн хувьд хяналт тавьж буй аж ахуйн нэгжийн татвартай холбоотой асуудалд оролцож туслах, зөвлөгөө өгч байгаа үйлдэл нь татварын байцаагчийн ажлын байрны тодорхойлолтод заасан зорилгод нийцэхгүй юм.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд зааснаар төрийн захиргааны албан хаагч нь өөрт олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй аливаа нөхцөл байдлаас татгалзах³⁰ ёс зүйн шаардлагыг биелүүлэх үүрэгтэй төрийн албан хаагч Вандан татвар төлөгчийн эрх ашигт нийцүүлэн татварын үйлчилгээ үзүүлсэн байна.

Татварын байцаагч нь аж ахуйн нэгжид татварын хяналт шалгалт хийх явцад бусдын нөлөөнд автах, эрхшээлд нь орж болзошгүй нөхцөл байдал бий болох аливаа харилцаанаас зайлсхийж, автахгүй байх³¹ ёс зүйн хэм хэмжээг сахих үүрэгтэй.

Төрийн албан хаагч нь ажил үүргийн хуваарийн дагуу өөрийн хариуцсан татвар төлөгчөөс мөнгө зээлдэх³², албан үүргээ хэрэгжүүлсний төлөө аль нэгэн этгээдийн өмнө хууль тогтоомжид заагдаагүй үүрэг хүлээх, албан үүргээ гүйцэтгэхдээ ашиг сонирхол нь хөндөгдөх хуулийн

29 Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2, 37.1.13, 37.1.17.

30 Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 3.1.2.а

31 Монгол Улсын Татварын улсын байцаагчийн ёс зүйн дүрмийн 2.2, 2.2.2,

32 Монгол Улсын Татварын улсын байцаагчийн ёс зүйн дүрмийн 2.4.2

этгээдээс зээл авах, бусад хангамж эдлэх³³-ийг хориглосон байтал төрийн албан хаагч Вандан “Эрдэм” ХХК-ийн татварын асуудалд байнга тусалж, шаардлагатай үед санхүүгийн дэмжлэг авдаг аж.

Татварын улсын байцаагчийн ёс зүйн дүрэм зааснаар татварын хяналт шалгалт хийх үйл ажиллагааны өмнө, явцад болон дараа нь өөрийн санаачилга ба татвар төлөгчийн урилгаар зоог, дайллагад оролцохыг хориглосон байтал төрийн албан хаагч Вандан татвар төлөгчийн ойн арга хэмжээнд оролцсон үйлдэл нь төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн гэж үзэх үндэстэй.

Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлд заасныг зөрчсөн төрийн албан хаагч тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан сахилгын шийтгэл ногдуулах зохицуулалттай.

Вандан нийтийн албан тушаалтны албан үүргийн дагуу хяналт тавьдаг аж ахуйн нэгжийн татварын тайлан гаргах асуудлыг хариуцан гүйцэтгэж, улмаар санхүүгийн дэмжлэг, хөнгөлөлттэй үйлчилгээ авч байгаа нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.17-т заасан “үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх” нийтлэг үүргээ биелүүлээгүй, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан хориглолтыг зөрчиж төрийн албан хаагч хуулиар зөвшөөрөөгүй давхар ажил эрхэлж санхүүгийн эх үүсвэрийг бий болгож буй шинжийг илэрхийлж байна.

Нөгөө талаас Вандангийн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасан бэлэг авахтай холбоотой хязгаарлалтыг зөрчсөн үйлдэлд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй юм.

Дээрх хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасны дагуу сахилгын шийтгэл хүлээсэн албан тушаалтан өөрт ногдуулсан шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх үүрэгтэй. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 7.1-д заасны дагуу томилох эрх бүхий албан тушаалтан төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг тухайн төрийн албан хаагчийн хувийн хэрэгт тэмдэглэж, байгууллагын дотоод сүлжээнд байршуулан мэдээлнэ.

33 Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 3.1.2.г

Бодлого 9

Гаалийн ерөнхий газрын албаны дарга Сүрэн ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг хангалтгүй биелүүлсэн тул Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар албан тушаалыг нь бууруулсан. Тэрээр үүрэгт ажлаа хүлээлгэн өгөхдөө компьютер дээрх гаалийн бүртгэлийн системд хадгалагдаж байсан файлуудыг устгаж, улмаар цаасан бичиг баримтуудыг хувьдаа авч явсан байна.

Асуулт:

Төрийн албан хаагч Сүрэн төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үү?

Бодолт:

Тийм.

Төрийн албан хаагч нь хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх тул өөрийн албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй.

Төрийн албан хаагч Сүрэн тухайн албан тушаалыг эрхэлж байх хугацаанд олж авсан албаны мэдээлэл, бичиг баримтыг хүлээлгэж өгөхгүй, хувьдаа авч явсан үйлдэл нь Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.11-д заасан “...албаны бус зорилгод мэдээллийн хангамж болон албаны мэдээллийг ашиглан завших...”, мөн зүйлийн 39.1.16-д заасан “...хуульд заасан үндэслэлээр албан тушаал бууруулсан тохиолдолд албан тушаал, ажлын байр, тамга, тэмдэг, холбогдох баримт бичгийг хүлээлгэн өгөхөөс татгалзахыг хориглоно...” гэсэн заалтуудыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д зааснаар нийтийн албан тушаалтан “албаны бүрэн эрхийг хэрэгжүүлэх явцдаа олж мэдсэн мэдээллийг хууль бусаар хувьдаа буюу ажил үүрэгт нь хамааралгүй байдлаар ашиглахыг хориглосон” тул түүнд мөн хуулийн 29 дүгээр зүйлд заасан хариуцлага хүлээлгэх зохицуулалт үйлчилнэ.

Төрийн тусгай албан тушаалтан Сүрэн нийтийн албан тушаалтан бөгөөд албаны үйл ажиллагаандаа “хууль дээдлэх зарчимд захирагдан, албан үүргээ иргэдийн итгэл хүлээхүйц, тэгш, шударга, хариуцлагатайгаар гүйцэтгэж, албаны ёс зүйг сахих” зарчмыг баримтан ажиллах үүрэгтэй.

Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрмийн 2.1.2-т зааснаар гаалийн улсын байцаагч нь төв, шударга ёсыг сахих, зохисгүй харьцаа, үйлдэл /эс үйлдэхүй/ гаргахгүй байх ёс зүйн хэм хэмжээг сахихаас гадна байгууллагын эд хөрөнгийг хувийн зорилгоор ашиглахыг хориглосон

байна.

Бодлого 10

“Мандал” ХХК нь 2018 онд ажилтнуудын тоог дарагдуулсан, ажилтнуудын төлсөн шимтгэлийг нийгмийн даатгалын санд оруулаагүй зөрчил гаргасныг дүүргийн нийгмийн даатгалын байцаагч Сандаг илрүүлж, хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлэх талаар мэдэгдсэн байна.

Гэтэл байгууллагын дарга Хайдав улсын байцаагч Сандаг “таны ажлаас хоцрох, ямар ч шалтгаангүй ажил таслах зэрэг зөрчил олон удаа давтагдаж байгаа, гэхдээ миний хувьд чамайг итгэл дааж ажиллаж чадна гэж үзэж байна” гэж хэлээд “Мандал” компанийн захирал миний ах тул асуудал үүсгэхгүй шийдвэрлэх үүрэг өгчээ. Байцаагч Сандаг “Мандал” ХХК-тай холбоотой асуудлыг шалгуулахаар хуулийн байгууллагад шилжүүлэхээ зогсоосон байна.

Асуулт:

Төрийн удирдах албан тушаалтан Хайдавын үйлдэл төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчил мөн үү?

Сандаг энэ тохиолдолд ямар үүрэг хүлээх вэ?

Бодолт:

Тийм.

Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2-т зааснаар төрийн албан хаагч нь нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх, хууль бус, шударга бус явдалтай эвлэрэхгүй байх үүрэгтэй. Төрийн удирдах албан тушаалтан удирдлагадаа байгаа албан тушаалтанд хуульд нийцээгүй үүрэг, даалгавар өгөхийг³⁴ хориглосон байтал өөрийн хамаарал бүхий этгээдийн ажиллладаг “Мандал” ХХК-ийн хууль зөрчсөн үйлдлийг хуулийн байгууллагад шалгуулахгүй байх, хяналт шалгалтыг зогсоох, хууль зөрчсөн үйлдлийг өнгөрөөхийг үүрэг болгосон байна.

Мөн Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.14-т заасан “удирдлагын санаа бодолд нийцэх эсэхийг үл харгалзан тэдний гаргах шийдвэрээс үүдэн гарч болзошгүй сөрөг үр дагаврыг урьдчилан анхааруулж байх” үүргийг зөрчиж, “Мандал” ХХК-ийн хууль зөрчсөн үйлдэлд хариуцлага тооцуулах, төрд учирсан хохирлыг тогтоолгох, нөхөн төлүүлэх талаар арга хэмжээ авахгүйгээр хуульд нийцээгүй шийдвэр гаргасан гэж үзэх үндэслэлтэй байна.

Төрийн албан хаагч Сандаг удирдах албан тушаалтны хууль бус үүрэг даалгаврыг биелүүлж, дээд шатны албан тушаалтны эрх ашигт нийцүүлж, хуульд нийцээгүй шийдвэр гаргасны төлөө бүрэн хариуцлагыг

34 Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1

өөрөө хүлээх³⁵ үүрэгтэй.

Мөн Төрийн удирдах албан тушаалтан Баатар Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 3.1.1.б-д “хууль зөрчсөн, авлига авсан, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан аливаа үйлдэлтэй эвлэршгүй байж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлэх;” 3.1.1.е-д “бусад албан хаагчийн үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх, саад болох, хууль бус үйлдэл хийхийг шаардахгүй байх” шаардлагыг биелүүлээгүй байх тул хариуцлага хүлээлгэх үндэстэй байна.

Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д зааснаар нийтийн албан тушаалтан албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх зэрэг авлигын зөрчил гаргахыг хориглосон байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно” гэж заасан байна.

Гэтэл нийтийн албан тушаалтан Хайдав албан тушаалын байдлаа ашиглан байцаагч Сандагийн шийдвэр гаргахад хууль бусаар нөлөөлж өөрийн хамаарал бүхий этгээдийн ашиг сонирхолд нийцүүлж шийдвэр гаргуулсан. Уг зөрчилд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.4-т зааснаар нийтийн албанаас халах захиргааны хариуцлагыг шүүгч хүлээлгэх үндэстэй байна.

Нийтийн албан тушаалтан Сандаг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан “Албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар өөрийн удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий байгууллагад, хуулийн хариуцлага хүлээхээр бол Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх” үүргээ биелүүлээгүй байна.

Төрийн албаны тухай хуулийн 37, 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн тохиолдолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдснийг нь харгалзан төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэлийг ногдуулна³⁶. Сахилгын шийтгэлийг заавал дэс дараалан хэрэглэхийг шаардахгүй юм.

Нийгмийн даатгалын байцаагч нь шимтгэл ногдох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг ажил олгогч үнэн зөв тодорхойлж,

³⁵ Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8

³⁶ Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1

ногдсон шимтгэлээ төлсөн эсэхийг шалгаж шимтгэлийг хугацаанд нь даатгалын сан тус бүрт оруулах, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд хууль дээдлэх, бусдын нөлөөнд үл автах зарчмыг гажуудуулах, акт, дүгнэлт, бусад баримт бичгийн биелэлтийг хангуулах ажлыг орхигдуулах, түүнд тавих хяналтыг сулруулахыг хориглосон байна.³⁷

Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл нь сахилгын болон захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хуулийн дагуу хариуцлага ногдуулна.

Бодлого 11

Нийслэлийн нэгэн дүүргийн ЗДТГ-аас нийт 5 албан хаагчийг Энэтхэг улсад сургалтад оролцуулах шийдвэр гарсан. Сонгон шалгаруулалтад оролцох ажилтанд төрийн албанд 5-аас доошгүй жил ажилласан, сахилгын шийтгэлгүй байх шаардлагыг ажлын хэсэг тавьжээ. Ажлын хэсгийн ахлагч Гарваа өөрийн дүү Батыг ажлын хэсгийн гишүүдэд хэлж шалгаруулсан байна. Хэдийгээр ажлын хэсгийн гишүүд Бат төрийн байгууллагад 2 жил ажиллаж байгааг мэдсэн ч татгалзаагүй байна.

Асуулт:

Төрийн албан хаагч Гарваа төрийн албан хаагч хууль зөрчсөн үү?

Бодолт:

Тийм.

Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1-д зааснаар төрийн жинхэнэ албан хаагч хууль бус, шударга бус явдалтай эвлэрэхгүй байж, харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх³⁸ үүрэгтэй.

Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3-т төрийн жинхэнэ албан хаагч хуульд нийцээгүй шийдвэр гаргахыг хориглосон байтал Гарваа гадаадад суралцах төрийн албан хаагчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн ахлагчаар ажиллахдаа сонгон шалгаруулалтыг шударгаар явуулах үүргээ биелүүлэлгүй, өөрийн хамаарал бүхий этгээдийн ашиг сонирхолд нийцүүлсэн хууль бус шийдвэр гаргасан байна.

Түүнийг Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д заасан “нийтийн албан тушаалтан албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэстэй юм.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах,

37 Нийгмийн даатгалын байцаагчийн дүрмийн 2.1.2, 2.4.5, 2.4.9

38 Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6

ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно” гэж заасан.

Гарваа Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд зааснаар төрийн албан хаагч ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй аливаа нөхцөл байдлаас татгалзах; албан үүргээ гүйцэтгэхдээ ашиг сонирхол нь хөндөгдөх иргэнд хууль бусаар давуу байдал олгохгүй³⁹ байх; бусад албан хаагчийн үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх, саад болох, хууль бус үйлдэл хийхийг шаардахгүй байх, хамаарал бүхий этгээдийн ажиллаж байгаа байгууллага, тэдний ашиг сонирхолтой холбоотой асуудлаар шийдвэр гаргах, албаны нэр барих зэргээр албан тушаал, эрх мэдлээ хууль бусаар ашиглахыг цээрлэх⁴⁰ зэрэг ёс зүйн шаардлагыг биелүүлээгүй байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл нь сахилгын болон захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хуулийн дагуу хариуцлага ногдуулна.

Төрийн албаны тухай хуулийн 37, 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн төрийн албан хаагчид тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдснийг нь харгалзан сахилгын шийтгэл ногдуулах⁴¹ бөгөөд сахилгын шийтгэлийг заавал дэс дараалан хэрэглэхийг шаардахгүй.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийг зөрчсөн нийтийн албан тушаалтанд шүүгч нийтийн албанаас халах⁴² захиргааны хариуцлага хүлээлгэх бөгөөд шүүгчээс захиргааны хариуцлага хүлээлгэсэн нь тухайн албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгэхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

Мөн түүнчлэн Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7-д зааснаар тус хуулийн 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах нь түүнийг төрийн албанаас чөлөөлөх, төрийн албанд дахин авахаас татгалзах үндэслэл болох бөгөөд харин түүнийг эрүүгийн болон бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

39 Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 2.1.3

40 Мөн дүрмийн 3.1.2.д. 3.1.1.е.

41 Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1

42 Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.4

Бодлого 12

Төрийн албан хаагчид байгууллагын албан хэрэгцээнд зориулагдах бичгийн цаас болон бусад хэрэгслийг хувийн хэрэгцээнд ашиглах, гэрлүүгээ авч явах тохиолдол байдаг. Гэвч энэ үйлдлийг төрийн албан хаагчид таслан зогсоох талаар биеэ биедээ шаардлага тавьдаггүй.

Асуулт:

Дээрх үйлдэл байгууллагын эд хөрөнгийг хувьдаа ашиглаж байгаа үйлдэлд хамаарах уу?

Бодолт:

Хамаарна.

Төрийн жинхэнэ албан хаагч нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэхдээ төрийн албанд хууль бус, шударга бус явдалтай эвлэрэхгүй байх⁴³ үүрэгтэй.

Төрийн жинхэнэ албан хаагчид “албаны бус зорилгод байгууллагын эд хөрөнгийг ашиглан завших”-ыг⁴⁴ хориглосон байтал төрийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан энэхүү хууль бус үйлдлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх талаар арга хэмжээ аваагүй байна.

Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.2-т зааснаар төрийн албан хаагч нь албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөл баталгаагаар хангуулж, байгууллагын эд хөрөнгийг албан хэрэгцээнд зориулан хэрэглэх байтал хувийн зорилгоор ашиглаж байгаа үйлдэл нь төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил болно.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 3.1.2-т зааснаар төрийн албан хаагч үйл ажиллагаандаа хувийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх ёс зүйн шаардлагыг биелүүлж, төрийн байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгслийг хувийн зорилгоор ашиглахгүй байх, эд хөрөнгийг зөв, гамтай, цэвэр нямбай ашиглах⁴⁵ үүргийг хэрэгжүүлэх ёстой.

Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл нь сахилгын болон захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хуулийн дагуу хариуцлага ногдуулна.

Тиймээс Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-т зааснаар тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдснийг нь харгалзан төрийн жинхэнэ албан хаагчид хуульд заасан сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулах үндэстэй.

Мөн Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7-д энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн төрийн жинхэнэ албан хаагчид

43 Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.

44 Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.11

45 Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм 3.1.2в

сахилгын шийтгэл ногдуулах нь түүнийг төрийн албанаас чөлөөлөх, төрийн албанд дахин авахаас татгалзах үндэслэл болох бөгөөд харин түүнийг эрүүгийн болон бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй гэж заасан.

Бодлого 13

Нэгэн яамны газрын дарга Анар нь тус яамнаас зарласан тендер сонгон шалгаруулалтад өөрийн төрсөн эгч Маргадын компани оролцож байгаа талаар тендерийн үнэлгээний хорооны гишүүдэд хэлж, улмаар эгчийнхээ компанийг дэмжиж санал өгөх талаар чиглэл өгсөн байна. Тендер сонгон шалгаруулалтад газрын дарга Анарын төрсөн эгчийн компани нь хамгийн бага үнийн санал ирүүлсэн үндэслэлээр шалгарсан төдийгүй тэрээр албан тушаалын байдлаа ашиглан хамт ажилладаг үнэлгээний хорооны гишүүдийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлж оролцсон байна.

Асуулт:

Дүгнэлт хийнэ үү, Анарт хариуцлага хүлээлгэх үндэслэл бий юу?

Бодолт:

Анарт хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д зааснаар яамны дарга Анарын төрсөн эгч Маргад нь түүний хамаарал бүхий этгээд мөн.

Тэрээр үнэлгээний хорооны гишүүдэд нөлөөлж, төрсөн эгчийн компанийг сонгон шалгаруулсан нь хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан “Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.” гэснийг зөрчсөн.

Мөн Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.14-т заасан “удирдлагын санаа бодолд нийцэх эсэхийг үл харгалзан тэдний гаргах шийдвэрээс үүдэн гарч болзошгүй сөрөг үр дагаврыг урьдчилан анхааруулж байх” үүргийг зөрчиж шийдвэр гаргасан гэж үзэх үндэстэй.

“Анар нь Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 3.1.1.д-д заасан бусад албан хаагчийн үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх, саад болох, хууль бус үйлдэл хийхийг шаардахгүй байх ёс зүйн шаардлагыг биелүүлээгүй байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг

зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий албан тушаалтан сахилгын шийтгэл хүлээлгэдэг. Газрын дарга Анарт дээрх хуулийн 29.2.4-т заасны дагуу эрх бүхий албан тушаалтан нийтийн албанаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэлтэй.

Нийтийн албан тушаалтан Анар Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан “Албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар өөрийн удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий байгууллагад, хуулийн хариуцлага хүлээхээр бол Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх” үүргээ биелүүлээгүй байна.

Бодлого 14

Нэгэн дүүргийн Татварын хэлтсийн тухайн онд хэрэгжүүлэх төлөвлөгөөт хяналт шалгалтын хуваарь батлагджээ. Тус дүүргийн татварын улсын ахлах байцаагч Ёндонгийн төрсөн дүүгийн үүсгэн байгуулсан компани нь уг шалгалтад хамрагдахаар төлөвлөгөөнд тусгагдсан байв. Татварын улсын байцаагч Ёндон нь хяналт шалгалт хийх хуваарийг өөрийн төрсөн дүүд хэлж бэлтгэл хангахыг захисан.

Асуулт:

Дүгнэлт хийнэ үү, Ёндон хууль зөрчсөн үү?

Бодолт:

Ёндон албаны мэдээллийг бусдад задруулсан байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан албаны мэдээлэл ашиглахтай холбогдсон хориглолтыг зөрчжээ. Тус хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Албан тушаалтан бүрэн эрхийнхээ дагуу олж авсан мэдээллийг хууль бусаар задруулах, албан үүрэгт нь хамааралгүй байдлаар ашиглахыг хориглоно.” гэж заасан байдаг.

Дээрх тохиолдолд мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.3-т зааснаар Ёндонд эрх бүхий албан тушаалтан албан тушаал бууруулах сахилгын шийтгэлийг ногдуулах үндэслэлтэй бөгөөд сахилгын шийтгэл хүлээсэн албан тушаалтан өөрт ногдуулсан шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх журам үйлчилнэ.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 3.1.2.в-д заасан албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглахгүй байх ёс зүйн шаардлагыг биелүүлээгүй байна.

Татварын улсын байцаагчийн ёс зүйн дүрмийн 2.4.8-д “хяналт шалгалтын ажлын явцад олж мэдсэн шимтгэл төлөгчийн нууцад хамаарах

мэдээллийг өөр этгээдэд өгөх, хувийн зорилгоор ашиглах”, 2.4.9-д “акт, дүгнэлт, бусад баримт бичгийн биелэлтийг хангуулах ажлыг орхигдуулах, түүнд тавих хяналтыг сулруулах”-аар заасныг зөрчсөн гэж үзэх үндэстэй.

Бодлого 15

Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн туслах Цацрал олон нийдийн цахим сүлжээг идэвхтэй ашиглаж, өөрийн хаягаар тогмол нийтлэл оруулдаг. Тэрээр өөрийн өдөр тутмын үйл явдал, ажлын болон ажлын бус цагаар авахуулсан этгээд хэв маягын хувцаслалттай зургийг цахим хуудасдаа байнга нийтэлж, бусдын нийтлэлд байнга сэтгэгдэл бичдэг. Шүүхийн Тамгын газрын дарга Цацралын дээрх үйлдэл нь ёс зүйн хэм хэмжээ зөрчиж байна гэж үзээд түүнд ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн байна.

Асуулт:

Шүүгчийн туслах Цацрал ёс зүйн зөрчил гаргасан уу?

Бодолт:

Тийм.

Шүүгчийн туслах Цацрал нь Шүүхийн захиргааны тухай хуулийн 29 дүгээр зүйлд зааснаар төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг дүрэм, хэм хэмжээг мөрдөхөөс гадна ёс зүйн ерөнхий шаардлагыг биелүүлж ажиллах үүрэгтэй. Тухайлбал, шүүхийн захиргааны албан хаагч нь ажлын бус цагаар шүүхийн нэр хүндэд харшлах аливаа зохисгүй байдлыг гаргахгүй байх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа байгууллагад ажиллаж байгаадаа хүндэтгэлтэй хандаж, ажлын байр, олон нийтийн дунд биеэ зөв авч явах⁴⁶ ёстой.

Мөн Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7-д зааснаар төрийн жинхэнэ албан хаагч Цацрал нь төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх үүрэгтэй бөгөөд үйл ажиллагаандаа “төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх” ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөхдөө түүнд харшлах аливаа үйлдлийг цээрлэх⁴⁷-ээс гадна албан үүргээ гүйцэтгэж байхдаа буюу ажлын байрандаа этгээд байдлаар хувцаслахыг хориглосон байна.

Цацрал иргэний хувьд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй боловч төрийн албан хаагчийн хувьд үг, үйлдлээрээ төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж байгааг илэрхийлэх үүрэгтэй.

Төрийн албан хаагч Цацрал төрийн албан хаагчийн ёс зүйн

46 Шүүхийн захиргааны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4, 29.1.5

47 Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм 3.1.4.6

болон Шүүхийн захиргааны ажилтны ёс зүйн дүрэм зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

Цацрал нь Шүүхийн захиргааны тухай хуулийн 29 дүгээр зүйлд зааснаар төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг дүрэм, хэм хэмжээг мөрдөхөөс гадна ёс зүйн ерөнхий шаардлагыг биелүүлж ажиллах үүрэгтэйгээс гадна Шүүхийн захиргааны ажилтны ёс зүйн дүрмийг чанд мөрдөж ажиллах ёстой. Тухайлбал, уг дүрмийн 3.1.3-т заасан “Шүүх гагцхүү хуульд захирагдан, шударга, алагчлалгүй ажиллаж чадна” гэсэн итгэлийг өөрийн үйл ажиллагаа, үг яриагаар төрүүлж чадахүйц харилцааны соёл, мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байх; 5.1.4-т заасан “Ажлын бус цагаар шүүхийн нэр хүндэд харшлах аливаа зохисгүй байдлыг гаргахгүй байх” зэрэг ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн байна.

Иймд Цацралд Шүүхийн захиргааны ажилтны ёс зүйн дүрмийн 6.1-д зааснаар сахилгын шийтгэл ногдуулах үндэслэлтэй.

Бодлого 16

Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын улсын бүртгэгч Долгор иргэдэд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэхээр нийслэлийн нэгдсэн үйлчилгээний төвд ажилладаг. Тэрээр албан үүргийг гүйцэтгэхдээ иргэдээс илүү бичиг баримт шаардах, цайны завсарлагааны цагийг хэтрүүлэх, ажлын цагт цөөхөн хүнд үйлчилж иргэдийг хүлээлгэх зэргээр байнга чирэгдүүлдэг. Гэвч улсын бүртгэгч Долгор зарим үйлчлүүлэгчид дараалалгүй үйлчил, үүнийхээ төлөө бэлэг, шан харамж, мөнгө авдаг болохыг иргэн Халтар мэдээлсэн байна.

Асуулт:

Улсын байцаагч Долгор төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан уу?

Бодолт:

Тийм.

Төрийн захиргааны албан хаагч Долгор нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2-т зааснаар нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх, хууль бус, шударга бус явдалтай эвлэрэхгүй байх үүргийг хүлээсэн.

Тиймээс төрийн албан хаагч Долгор төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүйгээр хүртээмжтэй, шуурхай хүргэхдээ аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байж⁴⁸, албаны чиг үүргийг хэрэгжүүлэх ёстой.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд зааснаар төрийн захиргааны албан хаагч Долгор үйл ажиллагаандаа “ард түмэндээ чин сэтгэлээс үйлчилж, төрийн

48 Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.12 дахь заалт

албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх” ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөхдөө иргэдтэй адил тэгш харьцаж, төрийн үйлчилгээг чирэгдэл, ялгаварлалгүйгээр хөнгөн шуурхай хүргэх үүрэгтэй.

Гэтэл төрийн албан хаагч Долгор Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах үүргээ үл биелүүлж бусдаас бэлэг, шан харамж авахын тулд иргэдэд түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэхгүй, ажлын цагт цөөн иргэдэд үйлчлэх, журамд заагаагүй бичиг баримтыг нэмж шаардсан байна.

Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5-д нийтийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхтай холбогдуулан бусдаас шан харамж шаардахыг хориглодог. Мөн зүйлийн 7.1.7-д зааснаар нийтийн албан тушаалтанд албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах авлигын зөрчил гаргахыг хориглосон. Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасныг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албан тушаал бууруулах, хэрэв албан тушаалыг нь бууруулах боломжгүй албан тушаал бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, авлигын зөрчилтэй нөхцөлд гарсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгох, 7.1-д заасныг удаа дараа зөрчсөн бол төрийн албанаас халах, авлигын зөрчилтэй нөхцөлд гарсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгох хариуцлагыг хүлээлгэнэ⁴⁹ гэсэн зохицуулалттай.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бусдаас бэлэг шууд буюу шууд бусаар авахыг хориглосон байна. Энэ тохиолдолд уг хуулийн 29 дүгээр зүйлд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй.

Сахилгын шийтгэл хүлээсэн нийтийн албан тушаалтан өөрт ногдуулсан шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх үүргийг хүлээсэн байна.

Харин төрийн албан хаагч Долгорын албан тушаалын байдлаа ашиглаж олсон эд хөрөнгө, орлогыг хурааж шийдвэрлэх⁵⁰ үндэслэлтэй байна.

Хэрэв гэмт хэргийн шинжтэй үйлдэл болох нь тогтоодвол Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн дагуу авч үзнэ.

49 Авлигын эсрэг хуулийн 33 дугаар зүйлийн 33.1

50 Авлигын эсрэг хуулийн 33 дугаар зүйлийн 33.2

Бодлого 17

Дүүргийн нэгэн цэцэрлэгийн багш Цэцгээ хаврын хичээлийн анги төгсөлтийн хуралд эцэг, эхчүүдэд хандаж ангийг засч тохижуулах төсөв энэ онд тусгагдаагүй талаар танилцуулаад эцэг, эхчүүд өөрсдийн боломжоор ангийн эд хогшлийг будах зардал, хүүхдүүдийн сургалтад зориулж нэг ширхэг зурагт, хүүхэд бүрт хувцасны шүүгээ авах шаардлагатай байна гэхэд эцэг, эхчүүд ярилцаад ангийн засвар болон эд хогшил, тоног төхөөрөмжинд зориулж хүүхэд тус бүр 40000 төгрөг цуглуулан өгчээ. Намар хичээлийн шинэ жил эхлэхэд ангийн эд хогшил буюу ширээ, сандал шүүгээг будсанаас өөр эд хөрөнгө шинээр худалдаж аваагүй төдийгүй анги засварт өгсөн байсан байна.

Асуулт:

Цэцэрлэгийн багш Цэцгээ төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан уу?

Бодолт:

Тийм.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд зааснаар төрийн үйлчилгээний албан хаагч үйл ажиллагаандаа төрийн албаны нэр хүндийг ямагт дээдэлж, түүнд харшлах аливаа үйлдлийг цээрлэх ёс зүйн шаардлагагы чанд сахих, авлигын орчин үүсэхээс урьдчилан сэргийлэх⁵¹ журамтай.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрмийг Монгол Улсын нутаг дэвсгэрт сургалтын үйл ажиллагаа эрхэлж буй өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэгийн багш, туслах багш, удирдах болон бусад ажилтан дагаж мөрдөхдөө үйл ажиллагаандаа “ёс суртахууны үлгэр дуурайлалтай ажиллах”, “хуулийг чанд сахих, хариуцлагатай байх” зарчмыг тус тус баримтлах үүрэгтэй.

Энэхүү зарчмын хүрээнд цэцэрлэгийн багш нь хичээл, сургалтын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотойгоор хүүхэд, эцэг эх, олон нийт болон хамтран ажиллагчидтай хууль бус санхүү, эд хөрөнгийн харилцааг тэвчих⁵², хүүхэд болон эцэг, эх, асран хамгаалагчаас тоног төхөөрөмж, эд материал зэргийг худалдан авахыг ятгах, хууль бус орлого олохоос татгалзах⁵³ ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөж, аливаа ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүрэгтэй.

51 Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм 3.1.4.б, 3.1.4.г

52 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтаны ёс зүйн дүрмийн 4.1.1

53 Мөн дүрмийн 4.1.5

9 Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйл

Бодлого 18

Нэгэн агентлагийн ажилтан Төгсөө, Болд нар хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд шинээр үйл ажиллагаа эхэлсэн “Солонго” нэртэй караоке үйлчилгээний газартай танилцжээ. Өдрийн цайны завсарлага таарсан тул Төгсөө, Болд нар тус газраар үйлчлүүлсэн байна. Шинэ нээгдсэн газар ихэд таалагдсан тул Болд ээлжийн амралт маргааш эхэлж байгааг тохиолдуулан найз нарыгаа караокед урьж, үргэлжлүүлэн үйлчлүүлсэн байна. Менежер Цогт нь Болдын хүсэлтийн дагуу үйлчилгээний газрын хаах цагийн хуваарийг сунган үйлчилж, улмаар төлбөрт зохих хөнгөлөлтийг үзүүлсэн байна.

Асуулт:

Төрийн албан хаагч Болд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үү?

Бодолт:

Тийм.

Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7-д зааснаар төрийн жинхэнэ албан хаагч Болд нь төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх үүрэгтэй.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд зааснаар төрийн захиргааны албан хаагч нь төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх үүргийг хэрэгжүүлэхдээ төрийн албаны нэр хүндэд харшлах аливаа үйлдлийг цээрлэх үүрэгтэй.

Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.16-д зааснаар төрийн албан хаагч нь ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах үүрэгтэйгээс гадна албан үүргээ гүйцэтгэж байхдаа согтууруулах ундаа хэрэглэх, олон нийтийн газарт мөрдөх дэг журмыг сахиж⁵⁴ ёс зүйн шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

Гэтэл төрийн захиргааны албан хаагч Төгсөө, Болд нар ажлын цагаар албан үүргээ гүйцэтгэж байхдаа согтууруулах ундаа хэрэглэж, олон нийтийн газарт мөрдөгдөх дэг журмыг зөрчиж улмаар хөнгөлөлттэй үнээр үйлчлүүлсэн үйлдлийг төрийн албаны нэр хүндэд харшлах ёс зүйн зөрчил гэж үзэх үндэстэй байна.

Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлд заасныг зөрчсөн тохиолдолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдснийг нь харгалзан төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах⁵⁵ бөгөөд сахилгын шийтгэлийг заавал дэс дараалан хэрэглэхийг шаардахгүй.

Төрийн албан хаагч үг, үйлдлээрээ Үндсэн хууль, бусад хуулиар

⁵⁴ Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 3.1.4-д

⁵⁵ Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1

баталгаажуулсан хууль ёсыг эрхэмлэн дээдлэх зарчмыг илэрхийлэн сахина гэсэн, шударга ёсыг дээдэлж, хувийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна”⁵⁶ гэсэн ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөж ажиллах ёстой.

Гэтэл төрийн албан хаагчид Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 3.1.2.г-д заасан “албан үүргээ гүйцэтгэхдээ ашиг сонирхол нь хөндөгдөх иргэнээс бэлэг авахгүй байх” ёс зүйн шаардлагыг биелүүлээгүй байна.

Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7-д зааснаар нийтийн албан тушаалтанд албан тушаалын байдлаа ашиглан давуу байдал эдлэх авлигын зөрчил гаргахыг хориглосон байтал Болд албаны чиг үүргийн хүрээнд хяналт тавих байгууллагаар үйлчлүүлэхдээ хуваарьт цагийг сунгах, хөнгөлттэй үнээр үйлчлүүлэх зэрэг давуу эрхийг эдэлсэн гэж үзэх үндэстэй байна.

Энэхүү зөрчил гаргасан нийтийн албан тушаалтанд эрх бүхий байгууллага, албан тушаалтан хариуцлага хүлээлгэх бөгөөд албан тушаал бууруулах, хэрэв албан тушаалыг нь бууруулах боломжгүй албан тушаал бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, авлигын зөрчилтэй нөхцөлд гарсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгох хариуцлага хүлээлгэх зохицуулалттай.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бусдаас бэлэг шууд буюу шууд бусаар авахыг хориглоно” гэж заасан. Гэтэл Төгсөө, Болд нар албан үүрэгтэй нь холбогдуулан аливаа этгээд бэлэг санал болгосон тохиолдолд саналаас татгалзах⁵⁷ арга хэмжээг авах ёстой байтал хөнгөлөлттэй үнээр үйлчлүүлсэн байна.

Иймд нийтийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бусдаас бэлэг авахыг хориглоно⁵⁸ гэсэн хуульд заасан хориглолтыг зөрчсөн хууль бус үйлдэлд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.4-т заасан нийтийн албанаас халах сахилгын шийтгэл хүлээлгэх үндэстэй.

56 Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм 2.1

57 Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалт

58 Мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалт

Бодлого 19

Бүртгэлийн газрын дарга Билгүүн албан хаагчдын гаргасан саналын дагуу ажлын нэг өдрийг дотоод ажлын өдөр болгосон байна. Энэ өдөр зарим албан хаагчид хувийн ажлаа хөөцөлдөх, ажлаа хийхгүй хийдүүлэх болсон байна. Иргэн Эрдэнэ орон нутгаас төрийн үйлчилгээ авахаар ирсэн боловч байгууллагын “дотоод ажилтай өдөр” байж таарчээ. Тэрээр байгууллагын даргатай уулзах гэтэл “иргэд хүлээн авч уулзах өдөр биш” гэсэн хариу өгсөн байна.

Асуулт:

Төрийн албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үү?

Бодолт:

Тийм.

Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.12-т зааснаар төрийн албан хаагч нь төрийн үйлчилгээг чирэгдэлгүйгээр чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэх, төрийн үйлчилгээг хүргэхдээ аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх үүрэгтэй.

Тиймээс төрийн албан хаагч албан тушаалын бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ иргэдэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй хүргэх үүргээ биелүүлэхгүй байгууллагын “дотоод ажлын өдөр” гэсэн нэрээр иргэдэд хүнд суртал гаргаж, төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулж болохгүй.

Дээрх тохиолдлыг төрийн удирдах албан тушаалтан Билгүүний Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3-т заасан албаны үйл ажиллагаандаа хуульд нийцээгүй шийдвэр гаргахыг хориглосон заалтыг зөрчсөнтэй холбон тайлбарлаж болох юм.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд зааснаар төрийн албан хаагч нь үйл ажиллагаандаа “ард түмэндээ чин сэтгэлээс үйлчилж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдэлнэ” гэсэн ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөх бөгөөд энэхүү ёс зүйн хэм хэмжээний хүрээнд албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ иргэд, үйлчлүүлэгчтэй эелдэг, адил тэгш, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцаж, төрийн үйлчилгээг чирэгдэл, ялгаварлалгүйгээр хөнгөн шуурхай хүргэх⁵⁹, төрийн албаны нэр хүндийг ямагт дээдэлж, түүнд харшлах аливаа үйлдлийг цээрлэх учиртай.

Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй, иргэдэд чирэгдүүлэхгүй төрийн үйлчилгээг үзүүлэх нь төрийн албан хаагчийн үүрэг. Гэтэл төрийн байгууллагын ажлын цаг ашиглалтад тавих хяналт сул, техникийн дэвшилтэд төхөөрөмжийг ашигладаггүй, албан

59 Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 3.1.4.а заалт

хаагчдад тавих хяналт тэгш бус, ялгавартай байдал нь төрийн албаны нэр хүндэд харшилж байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл нь сахилгын болон захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хуулийн дагуу хариуцлага ногдуулна.

Бодлого 20

Нэг цонхны үйлчилгээнд нийгмийн даатгалын байцаагч Цацрал иргэдэд даатгалтай холбоотой мэдээлэл, өргөдөл бичих зааврыг танилцуулдаг. Тэрээр өдөрт дунджаар 20 гаруй хүнд үйлчилдэг, ихэнхи нь өндөр настан тул ачаалалтай байдаг байна. 30 орчим насны залуу иргэн Мөнхбаяр өргөдлийн маягт бөглөх зааврыг дахин дахин асуусанд Цацрал ихэд цухалдаж “иймхэн зүйл бичиж чадахгүй, яаж сургууль төгссөн юм” хэмээн уурлажээ. Мөнхбаяр иргэдэд зөвлөгөө өгөх үүрэгт ажлаа хийхийг шаардаад үйлчилгээгээ авч чадалгүй явсан байна.

Асуулт:

Төрийн албан хаагч Цацрал төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан уу?

Бодолт:

Тийм.

Цацрал нь төрийн жинхэнэ албан хаагчийн хувьд Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7, 37.1.12-т зааснаар төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэхдээ хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх үүргийг хүлээдэг.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 3.1.3, 3.1.4-т заасан хэм хэмжээг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй. Төрийн албан хаагч нь албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ иргэд, үйлчлүүлэгчтэй эелдэг, адил тэгш, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцаж, төрийн үйлчилгээг чирэгдэл, ялгаварлалгүйгээр хөнгөн шуурхай хүргэх⁶⁰, төрийн албаны нэр хүндийг ямагт дээдэлж, түүнд харшлах аливаа үйлдлийг цээрлэх учиртай. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл нь сахилгын болон захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хуулийн дагуу хариуцлага ногдуулна.

Мөн Нийгмийн даатгалын байцаагчийн дүрэмд заасны дагуу нийгмийн даатгалын байцаагч нийгмийн даатгалын ажилтны нэр хүндийг өндөрт өргөж, албан үүргээ гүйцэтгэхдээ хуулийн этгээд, хувь хүнтэй

60 Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 3.1.4. а заалт

адил тэгш, соёлч боловсон харьцах үүргийг хүлээсэн байна⁶¹.

Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-д зааснаар төрийн албан хаагч албан үүргээ биелүүлээгүй тохиолдолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан сахилгын шийтгэл ногдуулах үндэслэлтэй.

Энэхүү сахилгын шийтгэлийг заавал дэс дараалан хэрэглэхийг шаардахгүй бөгөөд сахилгын шийтгэлийг давхардуулан ногдуулахыг хориглоно.

Бодлого 21

Нэгэн аймгийн нэг сумын 90 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан сумын Засаг даргын захирамжаар Тамгын газрын даргаар ахлуулсан ажлын хэсгийг байгуулжээ. Сумын Засаг даргын Тамгын газрын дарга Бат нь ажлын хэсгийн ахлагчийн хувьд суманд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд “сумын 90 жилийн ой тохиож байгаа тул сумын нутагт дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж 500.000 төгрөг өгнө үү” гэсэн утга бүхий албан бичиг, малчин иргэдэд 5 бог, 6 бодын хандив өргөх албан захидлыг хүргүүлсэн байна. Энэ хүрээнд сумын Мал эмнэлэг, үржлийн хэлтсийн даргад малчдаас мал цуглуулах ажлыг, сумын татварын улсын байцаагчид аж ахуйн нэгжүүдээс мөнгө хураан авах ажлыг тус тус хариуцуулан, биелэлтийг илтгэхийг даалгасан байна.

Асуулт:

Сумын Засаг даргын Тамгын газрын дарга Батын хийсэн үйлдэл хуульд нийцсэн үү? Хууль тогтоомж зөрчсөн гэж та үзэж байна уу?

Бодолт:

Бат Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17.1-д “Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно” гэж заасныг зөрчсөн. Уг хуулийн 17 дугаар зүйлийн 17.3-т “Албан тушаалтан хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байх” учиртай.

Мөн тус хуулийн 17.4-т “Энэ хуулийн 17.2-т заасан хандив⁶², санхүүгийн туслалцаа авсан албан тушаалтан, төрийн болон нутгийн

61 Нийгмийн даатгалын байцаагчийн дүрмийн 2.1.9

62 3.1.8. “хандив” гэж нийтийн албан тушаалтанд тодорхой зориулалтаар, үнэ төлбөргүй, эсхүл нийтэд санал болгож байгаа хөнгөлөлтөөс илүү хөнгөлөлттэй үнээр санхүүгийн эх үүсвэр, эд хөрөнгө шилжүүлэх болон үйлчилгээ үзүүлэхийг;

захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага хоёр жилийн хугацаанд хандивлагчтай холбоотой аливаа шийдвэр гаргахыг хориглоно” гэж заасан байдаг бөгөөд хандив өгсөн тухайн аж ахуйн нэгжүүдтэй цаашид 2 жил хамтран ажиллах нөхцөл байдал үүснэ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.3-т зааснаар уг хуулийн 17 дугаар зүйлд заасныг зөрчсөн тул албан тушаалыг нь бууруулах сахилгын шийтгэл ногдуулна. Сахилгын шийтгэл хүлээсэн Бат өөрт ногдуулсан шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх үүрэгтэй.

Төрийн албан хаагч нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6-д зааснаар харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх мөн зүйлийн 37.1.14-т зааснаар удирдлагын санаа бодолд нийцэх эсэхийг үл харгалзан тэдний гаргах шийдвэрээс үүдэн гарч болзошгүй сөрөг үр дагаврыг урьдчилан анхааруулж байх үүрэгтэй.

Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37 дугаар зүйлийн 37.1.8-д зааснаар төрийн албан хаагч нь хэдийгээр удирдах албан тушаалтын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж байгаа боловч хуульд нийцээгүй шийдвэрийг биелүүлсний төлөө хариуцлагаас чөлөөлөгдөхгүй бөгөөд гарсан үр дүнгийн төлөө өөрөө бүрэн хариуцлага хүлээнэ.

Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1-д “албан тушаалтанд хуульд нийцээгүй үүрэг, даалгавар өгөх, биелүүлэхийг шаардах”-ыг хориглохоор заасныг мөн зөрчиж, Мал эмнэлэг, үржлийн хэлтсийн дарга, сумын татварын улсын байцаагчид хандивыг бүртгэх, хураан авах ажлыг хариуцуулсан байна.

Иймд Засаг даргын Тамгын газрын дарга Батад түүнийг томилсон эрх бүхий албан тушаалтан Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэл оногдуулах зохицуулалтыг хамтад нь судлан үзэж хариуцлага хүлээлгэх үндэстэй.

Бодлого 22

Яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн Долингор нь БНХАУ-ын хөрөнгө оруулалттай компанид 7 хоногт 20 цаг зөвлөх, орчуулагчийн ажил хийхээр харилцан тохиролцон гэрээгээр ажиллаж байв. Долингортой хамт ажилладаг Сурмаа түүнд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуульд заасны дагуу зөвшөөрөл авах ёстой гэдгийг сануулсан байна. Тэрээр яамны удирдах албан тушаалтнаас давхар ажил эрхлэх зөвшөөрлийг бичгээр хүссэн боловч удирдлагын зүгээс илтэд ашиг сонирхлын зөрчил үүснэ гэж үзэн зөвшөөрөөгүй байна. Гэвч Долингор гэрээний хугацаа дуусахад 3 сар дутуу байсан тул гэрээт ажлаа үргэлжлүүлэн хийж дуусгасан байна.

Асуулт:

Долингорын үйлдэл хуульд нийцсэн үү? Түүний үйлдэл хууль зөрчсөн бол ямар хариуцлага хүлээлгэх вэ?

Бодолт:

Долингор нь удирдлагаас зөвшөөрөл өгөөгүй байхад дээрх компанид ажиллаж, цалин хөлс авч хууль зөрчсөн байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлд давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг тогтоосон байдаг. Хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Албан тушаалтан энэ хуулиар зөвшөөрснөөс өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно.” гэж заасан. Харин хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-18.5-д заасан албан албан тушаалтанд зарим ажил, албан тушаалыг давхар эрхэлж болохоор тусгасан. Мэргэжилтэн Долингор нь дээрх хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д заасан бусад албан тушаалтанд хамаарах тул ашиг сонирхлын зөрчил үүсэхээргүй бол өөрийн удирдах албан тушаалтны бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр бусад алба, гэрээний ажлыг давхар эрхэлж болно.

Өөрөөр хэлбэл, мэргэжилтэн Долингор өөрийн удирдах албан тушаалтнаас зөвшөөрөл авалгүй давхар ажил эрхэлсэн, мөн дараа нь байгууллагын удирдлага илтэд ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэж түүнд давхар ажил эрхлэхийг зөвшөөрөөгүй байхад гэрээгээ цуцлалгүй ажиллаж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасныг зөрчсөн байна.

Иймд мэргэжилтэн Долингорт хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.3-т заасан албан тушаалыг нь бууруулах сахилгын шийтгэлийг ногдуулах,

Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.17-д “үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх” нийтлэг үүргээ биелүүлээгүй гэж үзэн мөн хуулийн 48 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэл ногдуулах үндэслэлтэй юм.

Мөн удирдах албан тушаалтнаас зөвшөөрөл олгоогүй байхад дур мэдэн гэрээ байгуулж ажилласнаар Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 2.1.7-д заасан захирах, захирагдах ёсыг сахин биелүүлэх ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн төдийгүй уг дүрмийн 3.1.1.г-д “үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил үүрэг эрхлэхгүй байх” гэсэн шаардлагыг биелүүлээгүй гэж үзэх үндэстэй бөгөөд ёс зүйн шаардлагыг биелүүлээгүй үйлдэл нь сахилгын болон захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хуулийн дагуу хариуцлага ногдуулна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасны дагуу сахилгын шийтгэл хүлээсэн албан тушаалтан өөрт ногдуулсан шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх үүрэгтэй. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 7.1-д заасны дагуу томилох эрх бүхий албан тушаалтан төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг тухайн төрийн албан хаагчийн хувийн хэрэгт тэмдэглэж, байгууллагын дотоод сүлжээнд байршуулан мэдээлнэ.

Бодлого 23

Дүүргийн нэгэн дунд сургуулийн сурагч Болд ээжтэйгээ хамт амьдардаг бөгөөд тэрээр ар гэрийн амьдрал хэцүү, хааяа хичээлдээ хоцорч, даалгавар дутуу хийдэг байна. Багш Хонгорзул өдөр бүр сурагч Болдыг хүүхдүүдийн өмнө загнаж, элдэв үгээр доромжилдог боловч хүү ээждээ энэ талаар ярьдаггүй байна. Багшийн энэ хандлага хүүхдүүдэд нөлөөлж, ангийн хүүхдүүд Болдтой найзлахаа больсон байна. Болд энэ байдал цохилт болж маш их сэтгэлээр унан сургуулиас гарсан. Ангийн багш Хонгорзул Болдын гаргасан шийдвэрт өөрийгөө буруутгаагүй байна.

Асуулт:

Төрийн албан хаагч Хонгорзул төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан уу?

Бодолт:

Төрийн албан хаагч багш Хонгорзул төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан.

Монгол Улсын иргэн Үндсэн хуульд зааснаар сурч боловсрох

эрхтэй⁶³ тул бүх шатны боловсролыг хуульд заасан нөхцөл, журмын дагуу сурч эзэмших эрхтэйгээс гадна суурь боловсролыг заавал эзэмших үүрэгтэй.

Тиймээс Боловсролын тухай хуулийн 44 дүгээр зүйлд зааснаар багш нь багшийн ёс зүй, нэр төрийг эрхэмлэн сахих, суралцагчдыг ялгаварлан гадуурхахгүй байх, нэр төрийг нь хүндэтгэн хамгаалах, суралцагч бүрийн онцлог байдлыг хүлээн зөвшөөрч хүнлэг харьцах, өөрөө өөрийгөө хөгжүүлэх, бие хүн болж төлөвшихөд дэмжлэг үзүүлэх, суралцагчийн бие даасан байр суурь, үзэл бодолд хүндэтгэлтэй хандах үүргийг хүлээдэг байна.

Төрийн үйлчилгээний албан хаагч буюу багш нь суралцагчийн бие махбодид халдах, тэдэнд сэтгэл санааны дарамт үзүүлэх, хувийн нууцыг нь задруулахыг хориглосон.

Төрийн үйлчилгээний албан хаагч Хонгорзул төрийн үйлчилгээг адил тэгш, чанартай, хүртээмжтэй хүргэж, төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах чиг үүргийг хүлээсэн.

Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2-т зааснаар “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсныг төрийн үйлчилгээний албан хаагчид чанд мөрдөх ёстой.

Мөн боловсролын салбарын үйлчилгээний албан хаагч нарт баримтлах Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм батлагдсан.

2.1. Сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтан үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална.

- 2.1.1. Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх;
- 2.1.2. Хүнлэг энэрэнгүй, шударга ёсыг дээдлэх;
- 2.1.3. Мэргэжлийн нэр хүнд, үнэ цэнийг хамгаалах;
- 2.1.4. Ёс суртахууны үлгэр дуурайлалтай ажиллах;
- 2.1.5. Чанартай, хүртээмжтэй боловсролыг эрхэмлэх;
- 2.1.6. Хуулийг чанд сахих, хариуцлагатай байх;
- 2.1.7. Аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх/тэгш байдлыг хангах.

хангах.

Төрийн үйлчилгээний албан хаагч багш “Суралцагчид туслах, үлгэрлэх, баримт нотолгоонд тулгуурласан, үнэн зөв мэдээлэл, мэргэшлийн үйлчилгээ, зөвлөгөө үзүүлэх” үүрэгтэй байтал Хонгорзул сурагч Болдыг байнга сэтгэл санааны дарамтад байлгаж хүүхдүүдийн өмнө загнаж, элдэв үгээр доромжилсон байна.

Гэтэл багш үйл ажиллагаандаа хүүхдийг гэр бүлийн байдал, хөгжил,

63 Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 7

суралцах чадвараар нь ялгаварлахгүй байх, сурлагын амжилтыг бодитой үнэлэх, сургууль, цэцэрлэгийн орчинд үе тэнгийнхэн болон гадаад орчин, цахим орчны сөрөг нөлөөнд автахыг анхаараагүйгээс тэдний эрх, эрх ашиг хохирох байдалд хүргэхээс сэргийлэх⁶⁴-ээс гадна хүүхдийн бие махбод, сэтгэл санааны шийтгэл үзүүлэхгүй байх үүрэгтэй байна.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд зааснаар төрийн үйлчилгээний албан хаагч Хонгорзул албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн төлөө хариуцлага хүлээдэг байх ёс зүйн хэм хэмжээний хүрээнд албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд бүрэн хариуцах ёстой.

Багш Хонгорзулын ялгавартай хандлага, сэтгэл зүйн дарамт, ёс зүйгүй үйлдлийн улмаас сурагч Болд цаашид суралцах боломжгүй болж сургуулиас гарсан байх тул төрийн албан хаагч өөрийн ёс зүй зөрчсөн үйлдэлдээ дүгнэлт хийж, албан тушаалаасаа өөрийн хүсэлтээр татгалзах хүртэл хариуцлага хүлээх чадвартай байх шаардлага тавигдаж байна.

Гэтэл багш Хонгорзул сурагч Болдын сурах чадварыг хөгжүүлэн дэмжихгүй, үе тэнгийн найз нөхдийн өмнө нэр хүндийг нь гутааж байнгын сэтгэл санааны дарамтад байлгаснаар сургуулиа орхих шийдвэр гаргах нөхцөл байдалд хүргэсэн байтал ёс зүйн хариуцлага хүлээгээгүй байна.

Төрийн албан хаагч үг хэл, үйл хөдлөлөөрөө шударга бус хандах, ялгаварлан гадуурхах, хүүхдийн сурч боловсрох үндсэн эрхэд халдах эрхгүй юм.

Төрийн албан хаагчийн ёс зүй зөрчсөн үйлдлийн талаар иргэн, албан тушаалтан гомдол гаргасан эсэхээс хамаарахгүйгээр төрийн албан хаагчийн өөрийн ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн үйлдэлд дүгнэлт гаргах чадвартай байх ёстой.

64 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтаны ёс зүйн дүрэм 4.2.3, 4.2.4

Бодлого 24

Иргэн Цэцэгсүрэн Баянгол дүүргийн 3 хороонд оршин суудаг. Тэрээр “хөгжлийн бэрхшээлтэй нөхөртөө тэргэнцэр авах” хүсэлт, холбогдох баримтуудыг хорооны халамж үйлчилгээ хариуцсан нийгмийн ажилтан Анужинд өгсөн байна. Нийгмийн ажилтан бүрдүүлэх бичиг баримтыг хэд дахин дутуу бүрдүүлж дээд шатны байгууллага руу хүргүүлэх, хугацаа хожимдуулах зэргээс шалтгаалж, Цэцэгсүрэнд тэргэнцэр өгөх боломжгүй болсон байна. Төрийн албан хаагчийн энэхүү үйлдэлд бухимдсан Цэцэгсүрэн нийгмийн ажилтанд ажилдаа хариуцлагатай хандаж, намайг олон сар явуулсан боловч тэргэнцэр олгох асуудлыг шийдвэрлэж өгсөнгүй гэж уурласан байна. Гэтэл нийгмийн ажилтан “та гомдлоо гаргаад явахгүй юу, харин ч би таньд туслаад олгохоор хөөцөлдлөө, Танд заавал тэргэнцэр олгох албагүй” гэж хариулсан байна.

Асуулт:

Нийгмийн ажилтан Анужин төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн үү?

Бодолт:

Тийм.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын иргэн хөдөлмөрийн чадвар алдсан тохиолдолд хуульд зааснаар эд, мөнгөний тусламж авах, эрүүл мэндээ хамгаалуулах эрх⁶⁵-ийг эрхийг баталгаатай эдэлнэ.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8.3-т зааснаар нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээнд хамрагдах өрх, иргэнийг тодорхойлж, шийдвэрлүүлэх нь нийгмийн ажилтаны үндсэн үүрэг байтал нийгмийн ажилтан Анужин албан үүрэгтээ хариуцлагагүй хандсанаас нийгмийн халамж үйлчилгээ авах иргэний асуудлыг шийдвэрлээгүй байна.

Түүнчлэн нийгмийн ажилтан иргэнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээний талаар бүрэн мэдээлэл өгч, төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, шуурхай, хүртээмжтэй хүргэх үүргийг биелүүлээгүй байна. Өөрөөр хэлбэл, төрийн жинхэнэ албан хаагч Анужин Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.12-т заасан төрийн үйлчилгээг чирэгдэлгүйгээр чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэх, төрийн үйлчилгээг хүргэхдээ аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх үүргийг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд зааснаар төрийн захиргааны албан хаагч албан үүргээ зохих

65 Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 5, 6

ёсоор биелүүлээгүйн төлөө хариуцлага хүлээдэг байх ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөх ёстой.

Энэхүү ёс зүйн хэм хэмжээний хүрээнд төрийн захиргааны албан хаагч албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд бүрэн хариуцах, ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд үйлдэлдээ дүгнэлт хийж, албан тушаалаасаа өөрийн хүсэлтээр татгалзах хүртэл хариуцлага хүлээх чадвартай байх⁶⁶ шаардлага тавигддаг.

Төрийн захиргааны албан хаагч Анужин мэргэшил, ур чадвараа байнга хөгжүүлэх, үндсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж төрийн албаны хаагчид тавигдаж буй чадахуйн зарчмыг хангаж ажиллах шаардлагатай.

Төрийн албан хаагч мэргэжлийн үйл ажиллагаагаа төрийн албаны чиг үүргийг гүйцэтгэх, шийдвэр гаргах болон тэдгээртэй холбоотой бусад асуудалд анхаарал хандуулж гүйцэтгэхэд зориулах ёстой.

Төрийн албан хаагч албан үүргийг хэрэгжүүлэх мэргэжлийн ур чадвартай байхын тулд эрх зүйн мэдлэг, туршлага, нарийн мэргэшсэн байдал, бэлтгэл шаардлагатай. Төрийн албан хаагчийн мэргэжлийн ур чадвар нь албан үүргээ хэр гүйцэтгэж буй байдлаар тодорхойлогдоно.

Төрийн албан хаагчийн ур чадваргүй байдал нь сайн мэдлэггүй, хангалттай туршлагагүй, хувь хүний зан авирын хувьд асуудалтай, төрийн албанд үнэнчээр зүтгэх итгэл үнэмшилгүй этгээдээс илэрдэг.

Тиймээс төрийн захиргааны албан тушаалд чадахуйн зарчмыг үндсэн шалгуур болгож, түүнийг хамгийн сайн хангасан хүнийг томилох шаардлага тавигдаж байна.

Төрийн албан хаагч нь иргэдийн уур хилэн, өдөөн хатгалгыг үл харгалзан үйл ажиллагаандаа төрийн албан хаагчийн ёс зүйн зарчмыг баримталж хариу үйлдэл нь ухаалаг, эелдэг, хүлээцтэй байх учиртай.

Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл нь сахилгын болон захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хуулийн дагуу хариуцлага ногдуулдаг.

66 Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм 3.1.5.а, 3.1.5.б

Бодлого 25

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэгэн төрийн захиргааны байгууллагын газрын дарга Тамирыг “бусдаас мөнгө авч тусгай зөвшөөрөл олгодог” талаар мэдээлэл нийтлэгдсэн байна. Мөн хамт олны дотор Тамирыг бусдад хууль бусаар тусгай зөвшөөрөл олгодог талаар ярьдаг ч холбогдох байгууллагад мэдээлж, шалгуулж байгаагүй. Байгууллагын дарга Бат мэдээллийг шалгаж, холбогдох арга хэмжээ авахыг Дотоод хяналтын хэлтэст үүрэг өгсөн байна. Дотоод хяналтын хэлтсийн дарга Сүрэн “эрх нь зөрчигдсөн үндэслэлээр манайд албан ёсоор гомдол гаргасан этгээд байхгүй тул Тамирыг төрийн албан хаагчийн ёс зүй зөрчсөн гэх үйлдлийг шалгах боломжгүй” гэсэн хариу өгсөн байна.

Асуулт

Төрийн албан хаагч Сүрэн төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан уу?

Бодолт:

Төрийн албан хаагч Сүрэн төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан.

Төрийн захиргааны албан хаагч Сүрэн Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6-д зааснаар харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй.

Гэтэл Дотоод хяналтын хэлтсийн дарга Сүрэн “эрх нь зөрчигдсөн үндэслэлээр манайд албан ёсоор гомдол гаргасан этгээд байхгүй тул Тамирыг төрийн албан хаагчийн ёс зүй зөрчсөн гэх үйлдлийг шалгах боломжгүй” гэсэн хариу нь хууль бус шийдвэр гэж үзэх үндэстэй байна.

Учир нь Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 5.1-д Төрийн албан хаагч ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн тухай иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн гомдол, мэдээлэл, эсхүл хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд нийтлэгдсэн болон тухайн байгууллагын дотоод хяналтаар илэрсэн мэдээ, баримт нь шалгалт явуулах үндэслэл болно.” гэж заасан байна.

Тухайн албан хаагчийн дээд шатны албан тушаалтан мэдээллийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор уг байгууллагын дотоод хяналт, шалгалт хариуцсан нэгж, албан тушаалтанд шилжүүлэн зохих журмын дагуу шалгалтыг явуулах байтал төрийн удирдах албан тушаалтан хуульд нийцээгүй шийдвэр гаргасан байна.

Гэтэл Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3-т төрийн жинхэнэ албан хаагчид хуульд нийцээгүй шийдвэр гаргахыг хориглосон.

Төрийн байгууллага нь Авлигын эсрэг хуулийн 3.1.6-д зааснаар “авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа”-г цогцоор нь авч

хэрэгжүүлэхдээ авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаварыг нь арилгах арга хэмжээ авах⁶⁷ ёстой байна.

Түүнчлэн албан тушаалтан албан үүрэг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх үүрэгтэй байтал төрийн албан хаагч Сүрэн үүргээ биелүүлэхгүй, төрийн албан хаагчийн ёс зүй болон хууль зөрчсөн үйлдлийг шалгаж тогтоох, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцож эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгээгүй байна.

Төрийн захиргааны удирдах албан тушаалтан Бат удирдлагадаа байгаа төрийн албан хаагчийн авлигын шинжтэй мэдээллийг байгууллагын Дотоод хяналтын нэгжид шалгуулахаар шийдвэрлэсэн боловч Авлигын эсрэг хуульд зааснаар төрийн удирдах албан тушаалтны хувьд авлигын талаархи мэдээллийг Авилгатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх үүргийг биелүүлээгүй байна.

Төрийн албаны тухай хуулийн 37, 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн, албан үүргээ биелүүлээгүй төрийн албан хаагч Сүрэнд сахилгын шийтгэлийг эрх бүхий албан тушаалтан ногдуулна.⁶⁸

Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах нь түүнийг төрийн албанаас чөлөөлөх, төрийн албанд дахин авахаас татгалзах үндэслэл болох бөгөөд харин түүнийг эрүүгийн болон бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Бодлого 26

Нэгэн яамны Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсийн дарга Саруул яамны харъяа нэгэн байгууллагын үйл ажиллагаанд мониторинг хийсэн байна. Хяналт шинжилгээ, үнэлгээний шалгалтаар хангалтгүй үнэлэгдсэн, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулж ноцтой зөрчил гарсан тухай дүгнэлтийг үндэслэн байгууллагын дарга Сөрөлтийг үүрэгт ажлаас чөлөөлөх шийдвэр гарсан. Гэтэл хууль хяналтын байгууллагын шалгалтаар санхүүгийн зөрчил тогтоогдоогүй төдийгүй ХШҮХ-ийн дарга Саруул шүүхэд “надад удирдлагаас байгууллагын дарга Сөрөлтийг зөрчилтэй гаргахыг даалгасан” гэсэн тайлбар өгсөн байна.

Асуулт:

ХШҮХ-ийн дарга Саруул төрийн албан хаагчийн ёс зүй зөрчил гаргасан уу?

67 Авлигын эсрэг хуулийн 6.1.12

68 Төрийн албаны тухай хуулийн 48 дүгээр зүйлийн 48.1

Бодолт:

Тийм.

Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1-д зааснаар төрийн жинхэнэ албан хаагч Саруул нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх, хууль бус, шударга бус явдалтай эвлэрэхгүй байх үүрэгтэй байтал энэхүү үүргээ зөрчиж хууль бус дүгнэлт гаргасан гэж үзэх үндэслэлтэй байна.

Төрийн албан хаагч нь харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй тул хууль бус дарамт, шахалт, шаардлага хүлээж авахгүйгээр удирдлагын санаа бодолд нийцэх эсэхийг үл харгалзан тэдний гаргах шийдвэрээс үүдэн гарч болзошгүй сөрөг үр дагаврыг урьдчилан анхааруулж байх⁶⁹ үүрэгтэй.

Түүнчлэн төрийн байгууллагын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн удирдах албан тушаалтан Саруул албаны чиг үүргийг хэрэгжүүлэхдээ харьяа дээд шатны албан тушаалтныг асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргахад нь хуульд нийцсэн, бодит баримт нотолгоонд тулгуурласан, үндэслэл бүхий үнэн зөв мэдээллээр хангах үүргийг биелүүлэх ёстой.

Гэтэл төрийн албан хаагч нь албан үүргийг гүйцэтгэхдээ дээд шатны албан тушаалтны ашиг сонирхолд нийцүүлэн хууль бус дүгнэлт гаргаж, улмаар эрх бүхий албан тушаалтны хуульд нийцээгүй шийдвэр⁷⁰-ээс гарах үр дагаврыг мэдэгдээгүй байна.

Төрийн захиргааны албан хаагч Саруул нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8-д зааснаар төрийн албан хаагч хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд заасан төрийн албан хаагч албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн төлөө хариуцлага хүлээдэг байх хэм хэмжээг мөрдөх журамтай.

Тиймээс төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд үйлдэлдээ дүгнэлт хийж, албан тушаалаасаа өөрийн хүсэлтээр татгалзах хүртэл хариуцлага хүлээх чадвартай байх ёс зүйн хэм хэмжээг биелүүлэх үүрэгтэй.

Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-д зааснаар энэ хуулийн 37, 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн, албан үүргээ биелүүлээгүй болон энэ хуульд заасан бусад тохиолдолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан төрийн жинхэнэ албан хаагч Саруулд сахилгын шийтгэл ногдуулах үндэслэлтэй.

Төрийн жинхэнэ албан хаагчид түүнийг томилсон эрх бүхий албан тушаалтан, хамтын удирдлага бүхий байгууллага томилсон бол тухайн байгууллагын даргын шийдвэрээр сахилгын шийтгэл ногдуулна.

69 Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.14

70 Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3

Сахилгын шийтгэлийг давхардуулан ногдуулахыг хориглоно.

Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах нь түүнийг төрийн албанаас чөлөөлөх, төрийн албанд дахин авахаас татгалзах үндэслэл болох бөгөөд харин түүнийг эрүүгийн болон бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д зааснаар нийтийн албан тушаалтанд албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх авлигын зөрчлийг хориглосон.

Тиймээс удирдлагадаа байгаа төрийн албан хаагчид нөлөөлж хууль бус шийдвэр гаргуулсан удирдах албан тушаалтанд Авлигын эсрэг хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэдэг.

Тухайлбал, Авлигын эсрэг хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т зааснаар энэ хуулийн 7.1-д заасныг зөрчсөн этгээдэд албан тушаал бууруулах, хэрэв албан тушаалыг нь бууруулах боломжгүй албан тушаал бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, авлигын зөрчилтэй нөхцөлд гарсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгох эрх зүйн зохицуулалттай.

Бодлого 27

Нэгэн дүүргийн Прокурорын газрын прокурор Мандуул нь олны танил улс төрч Ононгийн хэрэгт хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа болно. Мандуулын төрсөн өдрөөр хуульч найзууд цугларах үеэрээ олны танил улс төрч Ононгийн хувийн амьдралын талаар сонирхсон байна. Тэрээр Ононгийн хувийн амьдрал, эд хөрөнгө, хэргийн талаар ярьж, гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон шүүхээс ял шийтгүүлнэ гэх зэргээр ярьсан байна.

Асуулт

Прокурор Мандуул төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан уу?

Бодолт

Тийм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын иргэн гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно.

Төрийн жинхэнэ албан хаагч Мандуул нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг сахин биелүүлж, хүний нэр төр, алдар хүнд,

эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дээдлэн хүндэтгэж⁷¹, албан үүргээ гүйцэтгэж байхдаа хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг чандлан хадгалах, албан ёсны аливаа мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр тараахгүй байх⁷² үүрэгтэй.

Мөн прокурор Мандуул нь Прокурорын ёс зүйн дүрмийн 3.11-д зааснаар “Өөрийн хяналтанд байгаа хэргийн талаар бусдад ярих, мэдээлэхгүй байх”, 3.13-т зааснаар “Хэрэг, материал хянах явцдаа олж мэдсэн хувь хүн, байгууллагын нууцтай холбоотой асуудлыг бусдад задруулахгүй байх” үүрэгтэй байтал хяналтын чиг үүргийн хүрээнд шалгаж байгаа хэргийн талаар болон бүрэн эрхийн дагуу олж авсан мэдээлэл, хувийн нууцыг бусдад задруулсан гэж үзэх үндэслэлтэй байна.

Төрийн жинхэнэ албан хаагч Мандуул нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан үүргээ зөрчсөн тул тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан сахилгын шийтгэл ногдуулна.

Бодлого 28

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагуудын ирэх жилийн төсөв хэлэлцэх хуралдаанд агентлагийн дарга Тулга ажлын тайлан тавьсан бөгөөд Захиргаа, хүний нөөцийн газрын дарга Сарнай тайланг бэлтгэсэн байна. Гэтэл тайлан үндэслэл бүхий статистик тоон үзүүлэлт, баримт нотолгоонд тулгуурлаагүй, алдаатай байсан тул агентлагийн даргын үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг “хангалтгүй” гэж үнэлсэн байна.

Асуулт:

Төрийн албан хаагч Сарнай төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үү?

Бодолт:

Тийм.

Төрийн захиргааны албан хаагч Сарнай Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.15-д зааснаар харьяа дээд шатны албан тушаалтныг бодит баримт нотолгоонд тулгуурласан, үндэслэл бүхий үнэн зөв мэдээлэл, мэргэшлийн зөвлөгөөгөөр хангах үүрэгтэй.

Учир нь агентлагийн Захиргаа, хүний нөөцийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, чиг үүргийн дагуу Сарнай тайлан мэдээг үнэн зөв, баримт нотолгоонд тулгуурлан боловсруулж бэлтгэх үйл ажиллагааг хангаж ажиллах ёстой.

Тиймээс төрийн албан хаагч хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх үүрэг хүлээдэг тул өөрийн

⁷¹ Төрийн албаны тухай хуулийн 37.1.3

⁷² Төрийн албаны тухай хуулийн 37.1.9

мэдлэг, чадвараа байнга хөгжүүлэх шаардлагатай байна. Тэрээр удирдах дээд албан тушаалтныг хуульд нийцсэн, бодит баримт нотолгоонд тулгуурласан, үндэслэл бүхий үнэн зөв мэдээллээр хангах үүргээ биелүүлээгүй байна.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд зааснаар төрийн албан хаагч Сарнай үйл ажиллагаандаа албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд бүрэн хариуцаагүй, зохих ёсоор биелүүлээгүйн төлөө хариуцлага хүлээдэг байх ёс зүйн хэм хэмжээг мөрдөөгүй байна.

Иймд төрийн албан хаагч Сарнай төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан үйлдэлдээ дүгнэлт хийж, албан тушаалаасаа өөрийн хүсэлтээр татгалзах хүртэл хариуцлага хүлээх чадвартай байна.

Төрийн албаны тухай хуулийн 37 зүйлд заасныг зөрчсөн, албан үүргээ биелүүлээгүй тохиолдолд төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах⁷³ бөгөөд төрийн жинхэнэ албан хаагчид түүнийг томилсон эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр сахилгын шийтгэл ногдуулдаг.

Бодлого 29

УИХ-ын чуулганаар Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, даатгуулагчийн сар бүр төлөх нийгмийн даатгалын хувь хэмжээг нэмэгдүүлэн тогтоосон нь иргэдийг ихэд бухимдуулсан байна. Нэгэн дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн хэсэг албан хаагчид Улаанбаатар хотод зохион байгуулагдах энэхүү шийдвэрийг эсэргүүцсэн цуглаанд нэгдэж өөрсдийн дуу хоолойг илэрхийлэх нь зүйтэй гэж шийдээд оролцох болсон байна. Жагсаал, цуглаанд оролцох тухайгаа тэдгээр албан хаагчид удирдах албан тушаалтанд албан ёсоор мэдэгджээ. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга Мөнхчулуун Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар иргэн бүр “үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, жагсаал, цуглаанд оролцох эрхтэй” гэж үзээд албан хаагч нарт нэг өдрийн ажлын цалинтай чөлөө өгсөн байна.

Асуулт:

1. Төрийн албан хаагч нар төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үү?
2. Байгууллагын дарга Мөнхчулууны үйлдэл хууль зүйн үндэслэлтэй юу?

Бодолт:

1. Төрийн албан хаагчид ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн.
Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 16 дах

73 Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1

хэсэгт зааснаар Монгол Улсын иргэн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй.

Мөн Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд хууль тогтоомжийн дагуу жагсаал, цуглаан зохион байгуулсан буюу түүнд оролцсоны төлөө хэнийг ч мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлах, аливаа хэлбэрээр гадуурхахыг хориглоно гэж заасан байна.

Төрийн албаны тухай хуульд зааснаар төрийн жинхэнэ албан хаагч нь нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх, улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч төрийн албан тушаал эрхлэх хугацаандаа улс төрийн аливаа нам, эвсэл, хөдөлгөөний үйл ажиллагаанд ямар нэг хэлбэрээр оролцохгүй байх, албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахих, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр төр, засгийн бодлоготой холбогдсон асуудлаар зөвхөн албан ёсны байр суурийг илэрхийлэх үүргийг хүлээдэг. Төрийн жинхэнэ албан хаагчид дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглодог. Тухайлбал:

- ажил хаялт болон төрийн албаны хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн бусад арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцох;
- төрийн бодлого, үйл ажиллагааг эсэргүүцсэн аливаа жагсаал, цуглаанд оролцох, мэдээ, мэдээлэл тараах⁷⁴

Тиймээс төрийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ улс төрийн хувьд төвийг сахиж, улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөний аливаа нөлөөллөөс ангид байна.⁷⁵

Тэрээр төрийн алба хаах хугацаанд улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөнөөс аливаа үүрэг хүлээхгүй, нөлөөлөлд автахгүй байх, төрийн бодлого, үйл ажиллагааг эсэргүүцсэн аливаа жагсаал, цуглаанд оролцох, мэдээ, мэдээлэл тараахгүй байх, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр төр, засгийн бодлоготой холбогдсон асуудлаар зөвхөн албан ёсны байр суурийг илэрхийлэх зарчмыг баримтална.

Гэтэл төрийн захиргааны албан хаагч нар төрийн бодлого, шийдвэрийн хүрээнд батлагдсан хууль тогтоомжийг эсэргүүцсэн нам, эвслийн зохион байгуулж буй жагсаал цуглааныг дэмжиж оролцон, төрийн албаны чиг үүргийн дагуу хэрэгжүүлэх хууль тогтоомжийг эсэргүүцэж байгаа үйлдэл нь төрийн албан хаагчийн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй.

Төрийн албан хаагч иргэнийхээ хувьд жагсаал, цуглаанд оролцож, нэгдэж, үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй боловч төрийн албан хаагчийн хувьд төрийн албаны эрхэм зорилго нь ард түмэнд үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэхэд оршдог.

⁷⁴ Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.7, 39.1.14

⁷⁵ Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, 2.1.6.

Төрийн албан хаагч нарын хуулир хүлээсэн үүргийг зөрчсөн үйлдэлд сахилгын шийтгэл хүлээлгэнэ.

2. Төрийн захиргааны албан тушаалтан Мөнхчулуун Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2-т зааснаар төрийн албан хаагч нарын хууль бус явдалтай эвлэрэхгүй байж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдэлж төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих үүрэгтэй.

Гэтэл төрийн удирдах албан тушаалтан Мөнхчулуун хуульд нийцээгүй шийдвэр гаргаж⁷⁶ удирдлагадаа байгаа албан хаагчдыг төрийн бодлого, шийдвэрийг эсэргүүцэж байгаа жагсаал цуглаанд нэгдэн оролцохыг дэмжиж, улмаар цалинтай чөлөө олгожээ.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд зааснаар төрийн захиргааны албан хаагч нь албан үүргээ гүйцэтгэхдээ улс төрийн хувьд төвийг сахиж, улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөний аливаа нөлөөллөөс ангид байна.

Төрийн удирдах албан тушаалтан төрийн албаны чиг үүргийг хэрэгжүүлэхдээ төрийн албан хаагчид хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, ард түмэнд үйлчлэх, төрд үнэнчээр зүтгэх, төрийн албан хаагч нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх зарчмуудыг баримтлан ажиллах үүрэгтэй.

Гэтэл төрийн албан хаагч төрийн бодлого, шийдвэрийг эсэргүүцсэн цуглаанд оролцох тухай хүсэлтийг дэмжиж, төрийн байгууллагын хэвийн ажиллагааг алдагдуулан төрийн албан хаагч нарт ажлын чөлөө олгож оролцуулж байгаа үйлдэл нь төрийн удирдах албан албан тушаалтны хувьд ёс зүйгүй үйлдэл болно.

Төрийн удирдах албан хаагч Мөнхчулуун нь хамт олны дотор ажил хэрэгч уур амьсгалыг бүрдүүлж, удирдлагадаа байгаа ажилтнуудад төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлж хууль тогтоомж, дүрэм, журмыг танилцуулах, сургалт зохион байгуулж байх үүрэгтэй.

Төрийн албан хаагч нь Төрийн албаны тухай хуулийн 37, 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн, албан үүргээ биелүүлээгүй тохиолдолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан сахилгын шийтгэл ногдуулна.

Энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах нь түүнийг төрийн албанаас чөлөөлөх, төрийн албанд дахин авахаас татгалзах үндэслэл болох бөгөөд харин түүнийг эрүүгийн болон бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

76 Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3

Бодлого 30

Дипломат төлөөлөгчийн газрын ажилтан Солонго хэвлэл, мэдээллийн хэрэгслээр төрийн гадаад бодлогын талаар ярилцага өгөх үеэрээ “Монгол Улсын иргэдийн визгүй зорчих улсын тоог хязгаарлах нь Монгол Улсын гадаад дахь нэр хүндийг унагахаас сэргийлэх юм” гэж өөрийн хувийн үзэл бодлыг төр, засгийн бодлого, байр суурь мэтээр ярьсан байна. Энэхүү мэдээлэл нь иргэдийн бухимдлыг ихэд төрүүлсэн байна.

Асуулт:

Төрийн албан хаагч Солонго төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үү?

Бодолт:

Тийм.

Төрийн жинхэнэ албан хаагч Солонго Төрийн албаны тухай хуульд зааснаар Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх үүрэгтэй.

Төрийн албан хаагч нь албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахих, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр төр, засгийн бодлоготой холбогдсон асуудлаар зөвхөн албан ёсны байр суурийг илэрхийлэх үүргийг хүлээсэн байна.

Гэтэл төрийн жинхэнэ албан хаагчид хэвлэл, мэдээллийн хэрэгслээр болон цахим хуудас, нийгмийн сүлжээний хэрэгслээр төрийн бодлоготой холбоотой асуудлаар албан бус байр суурь, улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх⁷⁷-ийг хориглосон байтал Солонго нь төрийн гадаад бодлого шийдвэрт нөлөөлөхүйц мэдэгдлийг хийж, өөрийн байр суурийг илэрхийлсэн байна.

Дипломат албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3-т зааснаар дипломат ажилтан нь хэвлэл, мэдээллийн хэрэгслээр Монгол Улсын төр, засгийн бодлоготой холбогдсон асуудлаар зөвхөн албан ёсны дүгнэлт, байр суурийг илэрхийлэх үүргээ биелүүлээгүй.

Гэтэл дипломатч хүний үндсэн үүрэг бол өөрийн орон, түүний иргэдийн эрх ашгийг төлөөлөх, хамгаалах, өөрийн орны улс төр, эдийн засгийн болон бусад салбарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, хөгжил дэвшлийг хурдасгах замаар суугаа оронтой найрсаг байж, байр сууриа бэхжүүлэх, улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататгах явдал юм.

Төрийн жинхэнэ албан хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ улс төрийн хувьд төвийг сахиж, улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөний аливаа

77 Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.13

нөлөөллөөс ангид байх⁷⁸ ёс зүйн хэм хэмжээний хүрээнд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр төр, засгийн бодлоготой холбогдсон асуудлаар зөвхөн албан ёсны байр суурийг илэрхийлэх үүргийг биелүүлээгүй байна.

Төрийн албаны тухай хуулийн 37, 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн, албан үүргээ биелүүлээгүй тохиолдолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан төрийн жинхэнэ албан хаагчид дараахь сахилгын шийтгэл ногдуулна.⁷⁹

-сануулах;

-албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;

-төрийн албанаас халах;

-төрийн албанд гурван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах;

-хуульд заасан бусад.

Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах нь түүнийг төрийн албанаас чөлөөлөх, төрийн албанд дахин авахаас татгалзах үндэслэл болох бөгөөд харин түүнийг эрүүгийн болон бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Түүнчлэн Засгийн газрын 2019 оны 272 дугаар тогтоолоор баталсан “Дипломат ажилтны сахилгын тусгай дүрэм”-ийн 3.8.4-т заасан “хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон цахим хуудас, хувийн facebook, twitter зэрэг олон нийтийн сүлжээний хэрэгслээр төрийн бодлоготой холбоотой асуудлаар хувийн байр суурь, улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх, улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөн, нэр дэвшигчийн талаар эерэг, сөрөг мэдээ, мэдээлэл түгээхгүй байх” гэснийг зөрчсөн гэж үндэстэй байна.

Бодлого 31

Иргэн Дорж 2017 оны 8 дугаар сард аймгаас Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 10 дугаар хороонд гэр бүлийн хамт шилжиж ирсэн. Дорж 6 настай хүүхдээ сургуульд бүртгүүлэхээр харъяаллын дагуу Чингэлтэй дүүргийн сургуулийн захиралтай уулзсан байна. Тус сургуулийн захирал Цэцэгмаа “шинээр хүүхэд хүлээж авах боломжгүй хүүхдийн тоо гүйцсэн тул хандивын ангид хүүхдээ бүртгүүлэх боломжтой гэж хэлсэн байна. Дорж хууль бус үйлдлийг хуулийн байгууллагад хандаж шалгуулна гэж хэлсэнд сургуулийн захирал Цэцэгмаа “манай харъяаллын хүүхэд гэдгээ хэлээгүйгээс буруу ойлголцсон байна” гээд уучлал гуйж, хүүхдийг бүртгэж авсан байна.

78 Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 2.1.6

79 Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1

Асуулт

Төрийн албан хаагч Цэцэгмаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үү?

Бодолт

Тийм.

Төрийн үйлчилгээний албан хаагч Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх үүрэгтэй.

Энэхүү дүрмийн 4.1.1-д зааснаар сургуулийн удирдах албан тушаалтан хичээл, сургалтын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотойгоор хүүхэд, эцэг эхтэй хууль бус санхүү, эд хөрөнгийн харилцааг тэвчиж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүрэгтэй.

Сургуулийн удирдах албан тушаалтан Цэцэгмаа төрийн байгууллагын нэр хүндэд хохирол учруулахгүй байх⁸⁰ үүрэгтэй.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд зааснаар төрийн албан хаагч нь үйл ажиллагаандаа албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд бүрэн хариуцаж, зохих ёсоор биелүүлээгүйн төлөө хариуцлага хүлээдэг.

Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтан Цэцэгмаа сургуулийн үйл ажиллагаанд хууль бусаар хандивын анги нэрээр иргэдээс төлбөр авах шийдвэр гаргасан байна.

Гэтэл Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д зааснаар албан тушаалтан төрийн байгууллагын нийтийн хэрэгцээнд зориулан иргэнээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглосон.

Өөрөөр хэлбэл, төрийн өмчийн сургуулийн үйл ажиллагаанд зориулах нэрээр нийтийн албан тушаалтан Цэцэгмаа нь хууль бус шийдвэр гаргасан.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасныг зөрчсөн бол албан тушаалыг нь бууруулах сахилгын шийтгэлийг эрх бүхий албан тушаалтан хүлээлгэх үндэслэлтэй.

⁸⁰ Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтаны ёс зүйн дүрмийн 4.3.4

Бодлого 32

Нэгэн яамны хэлтсийн дарга Анхбаяр төрийн албанд ажиллаж байгаад УИХ-ын сонгуульд нэр дэвшихээр албан тушаалаа хүлээлгэн өгсөн байна. Тэрээр хамт ажиллаж байсан яамны Санхүүгийн хэлтсийн дарга Сүхээгээс сонгуулийн үйл ажиллагаа дуустал албаны нэг автомашин хэрэглэхийг гуйсан тул зөвшөөрсөн байна.

Асуулт:

Төрийн албан хаагч Сүхээ төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан уу?

Бодолт:

Тийм.

Төрийн албаны эрхэм зорилго нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэхэд оршино.

Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т “улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх” зарчмыг төрийн албанд баримтална.

Төрийн жинхэнэ албан хаагч Сүхээ Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.4-т зааснаар улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч төрийн албан тушаал эрхлэх хугацаандаа улс төрийн аливаа нам, эвсэл, хөдөлгөөний үйл ажиллагаанд ямар нэг хэлбэрээр оролцохгүй байх үүрэгтэй.

Төрийн албан хаагч албаны бус зорилгод байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгслийг ашиглан завших⁸¹-ыг хориглосон. Сонгуулийн сурталчилгаанд аливаа хэлбэрээр оролцох, түүнд зориулалтын бус төсвийн хөрөнгө зарцуулах, төрийн өмч хөрөнгө, албаны унаа ашиглах⁸²-ыг хориглосон.

Гэтэл төрийн жинхэнэ албан хаагч Сүхээ нь төрийн албанд хамт ажиллаж байсан Анхбаярын сонгуулийн үйл ажиллагааг дэмжиж төрийн албаны унааг ашиглахыг зөвшөөрсөн нь хууль зөрчсөн үйлдэл байна.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд зааснаар төрийн захиргааны албан хаагч нь албан үүргээ гүйцэтгэхдээ улс төрийн хувьд төвийг сахиж, улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөний аливаа нөлөөллөөс ангид байна.

Тиймээс энэхүү ёс зүйн хэм хэмжээний хүрээнд төрийн алба хаах хугацаанд улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөнөөс аливаа үүрэг хүлээхгүй, нөлөөлөлд автахгүй байж, төрийн албаны нэр хүндийг ямагт дээдэлж, түүнд харшлах аливаа үйлдлийг цээрлэх ёс зүйн хэм хэмжээг мөрдөх

81 Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.11

82 Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.6

үүрэгтэй байна.

Төрийн албаны тухай хуулийн 37, 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн, албан үүргээ биелүүлээгүй тохиолдолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан төрийн жинхэнэ албан хаагчид дараахь сахилгын шийтгэл ногдуулна.⁸³

Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах нь түүнийг төрийн албанаас чөлөөлөх, төрийн албанд дахин авахаас татгалзах үндэслэл болох бөгөөд харин түүнийг эрүүгийн болон бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Бодлого 33

Дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн боловсролын хяналтын улсын ахлах байцаагчаар Дэрэм ажилладаг бөгөөд улсад нийт 25 жил ажиллаж байгаа. Тэрээр 6 сарын дараа өндөр насны тэтгэвэр авах эрх үүсч байгаа тул байгууллагадаа хүсэлтээ гаргасан байна. Энэ хугацаанд Дэрэм албан тушаалын тодорхойлолтод заасан хуваарьт ажлаа хийхгүй, бусдад даатгах зэргээр өдрийг өнгөрөөх болсон байна. Гэтэл хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч Цэцгээ энэ байдалд дургүйцэж хэлтсийн дарга Батад “албан хаагч нарт харилцан адилгүй шаардлага тавьж, шударга бус хандаж байна” гэсэн гомдол гаргасан. Бат “Дэрэм насаараа төрд ажилласан, удахгүй тэтгэвэрт гарах тул ажлын ачааллыг нэмэх шаардлагагүй” гэж тайлбарлаад “чи залуу хүн настай хүнтэй барьцаж байхаар өглөө 09.00 цагт шалгалт хийсэн ажлын тайлангаа танилцуул” гэж хэлсэн байна.

Асуулт:

1. Дэрэм төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан уу?
2. Хэлтсийн дарга Бат төрийн албан хаагчийн ёс зүй зөрчсөн үү?

Бодолт:

1. Дэрэм төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн.

Төрийн захиргааны албан тушаалтан Дэрэм Төрийн албаны тухай хуульд зааснаар Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлж, өргөсөн тангарагтаа үнэнч байж, нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх, хууль бус, шударга бус явдалтай эвлэрэхгүй байж, ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах үүрэгтэй.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд зааснаар төрийн албан хаагч Дэрэм нь ард түмэндээ чин сэтгэлээс үйлчилж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх үүргийг

83 Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1

хэрэгжүүлэхдээ төрийн үйлчилгээг чирэгдэл, ялгаварлалгүйгээр хөнгөн шуурхай хүргэх ёс зүйн хэм хэмжээг сахих үүргээ биелүүлээгүй байна.

Төрийн албан хаагч Дэрэм нь хуульд зааснаар өндөр насны тэтгэвэр тогтоолгож төрийн албанаас чөлөөлөгдөх хүртэл хуулиар хүлээсэн төрийн албан хаагчийн үүргийг биелүүлж, төрийн албаны чиг үүргийг тасралтгүй хэвийн үргэлжлүүлэн явуулах ёстой байна.

2. Хэлтсийн дарга Бат төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн.

Төрийн захиргааны албан тушаалтан Бат нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2 дах хэсэгт зааснаар шударга бус явдалтай эвлэрэхгүй байж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх үүрэгтэй байна.

Мөн төрийн удирдах албан тушаалтан нь албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангахын⁸⁴ тулд удирдлагадаа байгаа албан хаагч нарт ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах, ажлын шаардлагыг тавихдаа ялгаварлахгүй хандах үүрэгтэй.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 1.1.7-д зааснаар төрийн захиргааны удирдах албан хаагч нь захирах, захирагдах ёсыг сахин биелүүлэх ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллана.

Энэхүү ёс зүйн хэм хэмжээний хүрээнд төрийн удирдах албан тушаалтан Бат нь удирдлагадаа байгаа албан хаагчдын өмнө нэр хүнд, ажил хэргийн үлгэр жишээг үзүүлэх, хамт олны дотор ажил хэрэгч сэтгэл зүйн уур амьсгалыг бүрдүүлэх, удирдлагадаа байгаа албан хаагчийг айлган сүрдүүлэх, доромжлох, хясан боогдуулах зэргээр албаны хэвийн харилцааг алдагдуулах, хууль бус үүрэг даалгавар өгөхгүй байх үүргийг хэрэгжүүлнэ.

Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т хөдөлмөрийн харилцаанд насаар нь давуу байдал тогтоохыг хориглосон байтал төрийн удирдах албан тушаалтан Бат удирдлагадаа байгаа төрийн албан хаагч Дэрэмд хууль ёсны шаардлагыг тэгш, шударга тавьж ажиллах чиг үүргийг хэрэгжүүлэхгүй, хамт олны дунд ялгавартай хандаж буй сэтгэгдлийг бий болгож, хамт олны ажил хэрэгч уур амьсгалыг эвдсэн байна.

Түүнчлэн албан үүргээ гүйцэтгэхдээ төрийн албаны нэр хүндийг дээдлэхгүй, ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн үйлдлийг таслан зогсоогоогүй байна. Иймд төрийн албан хаагч Батын үйлдлийг төрийн албан хаагчийн ёс зүй зөрчсөн гэж дүгнэж байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл нь сахилгын болон захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хуулийн дагуу хариуцлага ногдуулна.

84 Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13

Бодлого 34

2018 оны 6 дугаар сард аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын албан тушаалд Билгүүн томилогдсон. Сарын дараа Билгүүний найз Мягмар аялан тоглолт зохион байгуулахаар Өмнөговь аймагт ирсэн байна. Тэрээр Билгүүнд 50 ширхэг тоглолтын тасалбар зарж өгөхийг гуйсан байна. Гэвч тэрээр шинэ ажилд томилогдоод удаагүй, хүмүүсийн ээлжийн амралтын улирал эхэлсэн байсан тул өгсөн тасалбарыг зарж чадаагүй байна. Тиймээс эрүүл ахуйн байцаагч Саранг дуудаж, 20 000 төгрөгийн үнэ бүхий 50 ширхэг тоглолтын тасалбар яаралтай зарахыг даалгасан байна. Саран шинэ дарга үүрэг өгч байгаа тул татгалзаагүй байна. Тэрээр Аймгийн нэгдсэн эмнэлэгт төлөвлөгөөт хяналт шалгалт хийж байсан тул эмнэлэгийн даргад тоглолтын тасалбар өгч борлуулсан байна.

Асуулт:

1. Мэргэжлийн хяналтын газрын дарга төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан уу?
2. Эрүүл ахуйн байцаагч Саран ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн үү?

Бодолт:

1. Мэргэжлийн хяналтын газрын дарга Билгүүн төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан байна.

Төрийн жинхэнэ албан хаагч Билгүүн нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2-т зааснаар нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх, хууль бус, шударга бус явдалтай эвлэрэхгүй байх үүрэгтэй.

Тиймээс төрийн албан хаагч албан тушаалтанд хуульд нийцээгүй үүрэг, даалгавар өгөх, биелүүлэхийг шаардах⁸⁵-ыг хориглосон байтал төрийн удирдах албан тушаалтан удирдлагадаа байгаа албан хаагчид тоглолтын тасалбар худалдан борлуулах үүргийг өгсөн байна.

Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-т зааснаар нийтийн албан тушаалтан нь албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх авлигын зөрчил гаргахыг хориглосон байна.

Иймд нийтийн албан тушаалтан Билгүүнд Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасныг зөрчсөн тохиолдолд албан тушаал бууруулах, хэрэв албан тушаалыг нь бууруулах боломжгүй албан тушаал бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, авлигын зөрчилтэй нөхцөлд гарсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгох хариуцлага хүлээлгэдэг.

Төрийн захиргааны удирдах албан тушаалтан Билгүүн нь Төрийн

85 Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1

захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 2.1.7-д зааснаар үйл ажиллагаандаа захирах, захирагдах ёсыг сахин биелүүлэх зарчмыг баримталж, удирдлагадаа байгаа албан хаагчдын өмнө нэр хүнд, ажил хэргийн үлгэр жишээг үзүүлэх, авлигын орчин үүсэхээс урьдчилан сэргийлэх, удирдлагадаа байгаа албан хаагчид хууль бус үүрэг даалгавар өгөхгүй байх ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй.

2. Төрийн захиргааны албан хаагч Саран төрийн албан хаагчийн ёс зүй зөрчил гаргасан байна.

Төрийн жинхэнэ албан хаагч Саран нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6-д зааснаар харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх мөн зүйлийн 37.1.14-т зааснаар удирдлагын санаа бодолд нийцэх эсэхийг үл харгалзан тэдний гаргах шийдвэрээс үүдэн гарч болзошгүй сөрөг үр дагаврыг урьдчилан анхааруулж байх үүрэгтэй.

Тиймээс төрийн албан хаагч Саран нь удирдах дээд шатны албан тушаалтны хуульд нийцээгүй үүрэг даалгавараас татгалзах байтал хүлээн авч, өөрийн албаны чиг үүргийн хувьд хяналтыг хэрэгжүүлж буй байгууллагын даргад тоглолтын тасалбарыг худалдсан байна.

Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37 дугаар зүйлийн 37.1.8-д зааснаар төрийн албан хаагч нь хэдийгээр удирдах албан тушаалтын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж байгаа боловч хуульд нийцээгүй шийдвэрийг биелүүлсний төлөө хариуцлагаас чөлөөлөгдөхгүй бөгөөд гарсан үр дүнгийн төлөө өөрөө бүрэн хариуцлага хүлээнэ.

Тиймээс Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд зааснаар төрийн захиргааны албан хаагч нь төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэхдээ дараахь ёс зүйн хэм хэмжээг мөрдөнө. Үүнд:

- удирдлагын санаа бодолд нийцэх эсэхийг үл харгалзан тэдний гаргах шийдвэрээс үүдэн гарч болзошгүй үр дагавар, сөрөг талыг урьдчилан анхааруулж байх;
- албан тушаалын бүрэн эрхээ ашиглан бусдыг дарамтлах, эрхшээлдээ байлгах, хавчин гадуурхахгүй байх;
- төрийн албаны нэр хүндийг ямагт дээдэлж, түүнд харшлах аливаа үйлдлийг цээрлэх.

Түүнчлэн төрийн албан хаагч албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн төлөө хариуцлага хүлээдэг байх ёс зүйн зарчмын хүрээнд албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд бүрэн хариуцах ёстой.

Хэрэв төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд үйлдэлдээ дүгнэлт хийж, албан тушаалаасаа өөрийн хүсэлтээр татгалзах хүртэл хариуцлага хүлээх чадвартай байх шаардлагатай.

Төрийн албан хаагч Саран нь албан үүргийн хувьд хяналтын чиг

үүргийг хэрэгжүүлэн шалгаж буй байгууллагын удирдлагад тоглолтын тасалбар худалдаж байгаа үйлдэл нь төрийн албаны нэр хүндийг унагасан, албан тушаалтанд шахалт, дарамт үзүүлсэн байна.

Төрийн албан хаагч нь удирдах албан тушаалтны хууль бус үүрэг даалгаврыг албан үүрэгтэй нь зөрчилдөж байгааг илэрхийлэх үүрэгтэй байтал татгалзаагүй. Ингэснээр Саран өөрийн хийсэн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн төлөө хариуцлага хүлээх эрх зүйн үр дагавар бий болж байна.

Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолын 1.10-т “ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах”-аар заасан байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл нь сахилгын болон захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хуулийн дагуу хариуцлага ногдуулна.

Бодлого 35

Ашигт малтмал, газрын тосны газрын бичиг хэргийн ажилтны сонгон шалгаруулалтад Соёл-Эрдэнэ шалгалт өгч, тэнцсэн байна. Газрын дарга Соёл-Эрдэнийг томилсон тушаал гармагц түүнд “бичиг хэргийн ажилтан ажил, үүргийн хуваарийн дагуу бичиг баримт бүртгэхээс гадна миний шууд удирдлагад туслах чиг үүрэгтэй” ажиллахыг хэлсэн байна. Соёл-Эрдэнэ ажилд орсноос хойш дарга Чулуунбаатарын өгсөн үүрэг даалгаврын дагуу ажлын цагаар хүүхдийг нь сургуульд хүргэх, авах, хувийн ажлыг нь хөөцөлдөж, оройн цагаар бичиг баримтаа цэгцлэх үндсэн ажлаа хийх болсон байна.

Асуулт:

Газрын дарга Чулуун төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан уу?

Бодолт:

Төрийн удирдах албан хаагч Чулуун төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан.

Төрийн жинхэнэ албан хаагч Чулуун нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2-д зааснаар нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх, хууль бус, шударга бус явдалтай эвлэрэхгүй байх үүрэгтэй.

Гэтэл Чулуун нь удирдлагадаа байгаа төрийн албан хаагчаар хувийн ажлыг хийж гүйцэтгэх үүрэг даалгавар өгдөг байна.

Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1-д зааснаар төрийн жинхэнэ албан хаагч албан тушаалтанд хуульд нийцээгүй үүрэг, даалгавар өгөх, биелүүлэхийг шаардах, мөн зүйлийн 39.1.4.албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, бусдыг бэлгийн болон хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн аливаа хэлбэрээр дарамтлах, хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгахыг хориглосон байна.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд зааснаар төрийн захиргааны удирдах албан тушаалтан захирах, захирагдах ёсыг сахин биелүүлэх зарчмыг баримтлахдаа хамт олны дотор ажил хэрэгч сэтгэл зүйн уур амьсгалыг бүрдүүлэх, удирдлагадаа байгаа албан хаагчийг айлган сүрдүүлэх, доромжлох, хясан боогдуулах зэргээр албаны хэвийн харилцааг алдагдуулах, хууль бус үүрэг даалгавар өгөхгүй байх⁸⁶ ёс зүйн шаардлагыг биелүүлэх үүрэгтэй байна.

Гэтэл төрийн захиргааны удирдах албан тушаалтан Чулуун өөрийн шууд удирдлагад хамаарах ажилтанд үүрэг даалгавар өгөх бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ өөрийн хувийн ажлыг хийлгэх, хууль бус үүрэг даалгавар өгөх зэргээр төрийн албан хаагчид ажлын байрны дарамт үзүүлж байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл нь сахилгын болон захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хуулийн дагуу хариуцлага ногдуулна.

Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн, албан үүргээ биелүүлээгүй төрийн албан хаагч Чулуунд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдснийг нь харгалзан сахилгын шийтгэл ногдуулна.⁸⁷

Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах нь түүнийг төрийн албанаас чөлөөлөх, төрийн албанд дахин авахаас татгалзах үндэслэл болох бөгөөд харин түүнийг эрүүгийн болон бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

86 Төрийн захиргааны бололн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 3.1.7.6, 3.1.7.ө

87 Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1

Бодлого 36

Нийслэлийн Баянгол дүүргийн иргэн Самбуу өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн тул тэтгэвэр тогтоолгохоор дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн нэг цонхны үйлчилгээний ажилтанд баримт бичгээ өгсөн байна. Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Жандаг ажил дээрээ иргэн Самбуутай таарсны дараа хороо хариуцсан даатгалын байцаагч Нансалмааг дуудаж “Самбуугийн тэтгэвэр тогтоолгох асуудлыг хойшлуулах үүрэг даалгавар өгч, өнгөрсөн жил сонгуульд нэр дэвшсэн нөхрийг маань эсэргүүцэж хурал зохион байгуулж байсан” гэж хэлжээ. Байцаагч Нансалмаа даргын хэлснээр Самбуугийн бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг нэмж, хүлээж авах боломжгүй” гэсэн хариу өгсөн байна.

Асуулт:

1. Нийгмийн даатгалын байцаагч Нансалмаа ёс зүйн зөрчил гаргасан уу ?
2. Жандаг төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан уу?

Бодолт:

1. Нансалмаа төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар Монгол Улсын иргэн нь өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар иргэн төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлоо шийдвэрлүүлэх эрхтэй бөгөөд төрийн байгууллага, албан тушаалтан иргэний өргөдөл, гомдолд дурдсан асуудал бүрийг эрх хэмжээнийхээ хүрээнд хянан үзэж, үндэслэлтэй шийдвэрлэх үүрэгтэй.

Нийгмийн даатгалын байцаагчийн дүрмийн 2.1.8-д зааснаар нийгмийн даатгалын байцаагч нь “албан үүрэг гүйцэтгэх явцдаа ...хувийн болон бусдын ашиг сонирхлын төлөө ашиглахгүй байх...”, мөн дүрмийн 2.1.9-д зааснаар “нийгмийн даатгалын ажилтны нэр хүндийг өндөрт өргөж, эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд шударгаар гүйцэтгэх, албан үүргээ гүйцэтгэхдээ хувь хүнтэй адил тэгш, соёлч боловсон харьцах” үүргийг хүлээсэн байна.

Төрийн захиргааны албан хаагч Нансалмаа Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6-д зааснаар харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй бөгөөд удирдлагаас өгсөн хуульд нийцээгүй шийдвэрийг биелүүлэхээс

татгалзаж, удирдлагын санаа бодолд нийцэх эсэхийг үл харгалзан тэдний гаргах шийдвэрээс үүдэн гарч болзошгүй сөрөг үр дагаврыг урьдчилан анхааруулж байх⁸⁸ үүргийг биелүүлээгүй байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаар нийтийн албан тушаалтан албан үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн албан хаагчид хууль бусаар нөлөөлөх, дарамт шахалт үзүүлэхийг хориглосон.

Иймд нийтийн тушаалтан иргэний болон хуулийн этгээдийн зүгээс тавьсан албан үүрэгтэй нь зөрчилдөх хувийн ашиг сонирхлын асуудал болон зан байдлыг тэвчиж, албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхлыг хувийн болон тусгай ашиг сонирхлоос илүүд үзнэ.

Нийтийн албан тушаалтан Нансалмаа иргэн Жандагийн өндөр настны тэтгэвэр тогтоолгох баримт бичиг бүрдсэн байтал удирдах албн тушаалтны хуульд нийцээгүй шийдвэрийг биелүүлж үндэслэлгүйгээр татгалзсан байна.

Хэдийгээр төрийн албан захиргааны албан хаагч Нансалмаа удирдах албан тушаалтны өгсөн үүрэг даалгавар биелүүлж байгаа боловч гарах үр дүнгийн төлөө бүрэн хариуцлагыг өөрөө хүлээнэ⁸⁹.

Төрийн албан хаагч Нансалмаа нь төрийн албаны чиг үүргийг хэрэгжүүлэхдээ үйл ажиллагаандаа Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх үүрэгтэй.

Төрийн албан хаагч Нансалмаа албан үүргээ хэрэгжүүлэхдээ дээд шатны удирдлагын хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлж, хууль бус үүрэг, даалгавар өгсөн тохиолдолд удирдлагын санаа бодолд нийцэх эсэхийг үл харгалзан тэдний гаргах шийдвэрээс үүдэн гарч болзошгүй үр дагаварыг урьдчилан анхааруулж татгалзах ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй.

2. Төрийн удирдах албан тушаалтан Жандаг төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан гэж үзэх үндэслэлтэй.

Төрийн жинхэнэ албан хаагч нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2-т зааснаар нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх, хууль бус, шударга бус явдалтай эвлэрэхгүй байх үүргийг хүлээдэг.

Төрийн захиргааны удирдах албан тушаалтан удирдлагадаа байгаа албан тушаалтанд хуульд нийцээгүй үүрэг, даалгавар өгөх, биелүүлэхийг шаардах⁹⁰-ыг хуулиар хориглосон байна.

Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-т зааснаар нийтийн албан тушаалтан албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглосон бөгөөд мөн албан үүргээ гүйцэтгэхдээ бусдын эрхийг хязгаарлахыг хориглосон байна.

88 Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.14

89 Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8

90 Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1

Гэтэл төрийн захиргааны удирдах албан тушаалтан Жандаг иргэн Самбуугийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох хугацааг шалтгаангүйгээр сунгаж бусдын эрхийг зөрчсөн байна.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд зааснаар төрийн албан хаагч нь үйл ажиллагаандаа “захирах, захирагдах ёс”-ыг сахин биелүүлэх ёс зүйн хэм хэмжээг мөрдөх үүрэгтэй. Энэхүү ёс зүйн хэм хэмжээний хүрээнд төрийн удирдах албан тушаалтан удирдлагадаа байгаа албан хаагчийг айлган сүрдүүлэх, доромжлох, хясан боогдуулах зэргээр албаны хэвийн харилцааг алдагдуулах, хууль бус үүрэг даалгавар өгөхгүй байх үүргээ биелүүлээгүй байна.

Төрийн албан хаагч Жандаг нь Төрийн албаны тухай хуулийн 37, 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн, албан үүргээ биелүүлээгүй байх тул сахилгын шийтгэл ногдуулахдаа заавал дэс дараалан хэрэглэхийг шаардахгүй.

Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах нь түүнийг төрийн албанаас чөлөөлөх, төрийн албанд дахин авахаас татгалзах үндэслэл болох бөгөөд харин түүнийг эрүүгийн болон бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Бодлого 37

Гаалийн байцаагч Нарандэлгэр ажил, үүргийн хуваарийн дагуу Монгол Улсын хилээр нэвтрүүлэх барааны гаалийн бичиг баримтыг шалгаж, ногдуулсан татвар төлсний дараа барааг олгох зөвшөөрөл олгодог. 2018 оны 2 дугаар сард БНХАУ-аас “Алтан гүүр” ХХК-ийн барилгын материал хилээр орж иржээ. Тэрээр тус компанийн гаалийн баримт бичгийн бүрдүүлэлтийг шалгахад барааны худалдааны бичиг баримтууд нь шаардлага хангахгүй, татвар тогтоосон хэмжээгээр төлөөгүй байсан тул зөвшөөрөл олгохоос татгалзсан байна. Гэтэл Гаалийн ерөнхий газрын Хяналт, шалгалтын хэлтсийн дарга Лутбэх гаалийн байцаагч Нарандэлгэрт “Алтан гүүр” ХХК-ийн “гаалийн бүрдүүлэлт хийгдсэн, зөрчилгүй” гэж бүртгэх үүрэг, даалгавар өгсөн тул удирдах дээд албан тушаалтны шийдвэрийг биелүүлсэн байна.

Асуулт:

1. Гаалийн байцаагч Нарандэлгэр төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан уу?
2. Удирдах албан тушаалтан Лутбэх ёс зүйн зөрчил гаргасан уу?

Бодолт:

1. Гаалийн байцаагч Нарандэлгэр төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн.

Монгол Улсын Үндсэн хуулийн арвандолдугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын иргэн хуулиар ногдуулсан албан татвар төлөх үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ.

Төрийн жинхэнэ албан хаагч Нарандэлгэр нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2-т зааснаар өргөсөн тангарагтаа үнэнч байж, нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх, хууль бус, шударга бус явдалтай эвлэрэхгүй байх үүрэгтэй.

Мөн төрийн жинхэнэ албан хаагч нь өөрийн харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлж, харин хууль бус үүрэг, даалгаврыг биелүүлэхээс татгалзаж удирдлагын санаа бодолд нийцэх эсэхийг үл харгалзан тэдний гаргах шийдвэрээс үүдэн гарч болзошгүй сөрөг үр дагаврыг урьдчилан анхааруулж байх⁹¹ үүргийг хүлээнэ.

Учир нь төрийн албан хаагч хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээдэг тул өөрийн мэдлэг, чадвараа байнга хөгжүүлж аливаа үүрэг, даалгавар, шийдвэр хуульд нийцэж буй эсэхэд дүгнэлт хийх ёстой.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд зааснаар төрийн захиргааны албан хаагч Нарандэлгэр албан үүргээ хэрэгжүүлэхдээ төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдэлж, түүнд харшлах аливаа үйлдлийг цээрлэх⁹² ёс зүйн хэм хэмжээг сахих үүрэгтэй байна.

Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3-д зааснаар төрийн жинхэнэ албан хаагч хуульд нийцээгүй шийдвэр гаргахыг хориглосон байтал төрийн албан хаагч Нарандэлгэр нь удирдах албан тушаалтны өгсөн хууль бус үүрэг даалгаврыг биелүүлж хуульд нийцээгүй шийдвэр гаргасан гэж үзэх үндэслэлтэй.

Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл нь сахилгын болон захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хуулийн дагуу хариуцлага ногдуулна.

Мөн Гаалийн тухай хуулийн 275 дугаар зүйлийн 275.1.3-д зааснаар гаалийн улсын байцаагч нь бусдад давуу байдал олгох зэргээр ялгаварлахыг хориглосон заалтыг төрийн албан хаагч Нарандэлгэр зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй.

Нийтийн албан тушаалтан Нарандэлгэр нь Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т зааснаар албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар хуулийн этгээдэд давуу байдал олгох авлигын зөрчил гаргахыг хориглосон заалтыг зөрчиж, “Алтан гүүр” ХХК гаалийн бүрдүүлэлт дутуу, ногдох татвар гүйцэд төлөгдөөгүй хууль зөрчсөн үйлдлийг илрүүлсэн боловч гаалийн хяналт шалгалтаар тэнцсэн, бараа олгох шийдвэрийг гаргаж бусдад давуу байдал олгосон байна. Авлигын эсрэг хуулийн

91 Төрийн албаны тухай хуулийн 37.1.6, 37.1.14

92 Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс дүрмийн 3.1.4.6

7.1-д заасныг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий байгууллага, албан тушаалтан албан тушаал бууруулах, хэрэв албан тушаалыг нь бууруулах боломжгүй албан тушаал бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, авлигын зөрчилтэй нөхцөлд гарсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгох хариуцлага хүлээлгэнэ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д зааснаар албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар өөрийн удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий байгууллагад, хуулийн хариуцлага хүлээхээр бол Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх үүргээ Нарандэлгэр хэрэгжүүлээгүй байна. Нийтийн албан тушаалтан иргэний болон хуулийн этгээдийн зүгээс тавьсан албан үүрэгтэй нь зөрчилдөх хувийн ашиг сонирхлын асуудал болон зан байдлыг тэвчиж, албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхлыг хувийн болон тусгай ашиг сонирхлоос илүүд үзнэ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2-т уг хуулийн 9.1-д заасан үүргээ биелүүлээгүй бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах; 29.2.3-т мөн хуулийн 9.2-т заасан арга хэмжээг аваагүй бол албан тушаалыг нь бууруулах сахилгын шийтгэл ногдуулахаар хуульчилсан.

2. Төрийн удирдах албан тушаалтан Лутбэх төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан гэж үзэх үндэслэлтэй.

Төрийн жинхэнэ албан хаагч Лутбэх нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2-д зааснаар өргөсөн тангарагтаа үнэнч байж, нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх, хууль бус, шударга бус явдалтай эвлэрэхгүй байх, мөн зүйлийн 37.1.7-д зааснаар төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх үүрэгтэй байна.

Төрийн жинхэнэ албан хаагч нь Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1-д зааснаар албан тушаалтанд хуульд нийцээгүй үүрэг, даалгавар өгөх, биелүүлэхийг шаардахыг хориглоно.

Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д зааснаар нийтийн албан тушаалтан албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх, мөн зүйлийн 7.1.3-т зааснаар албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах авлигын зөрчил гаргахыг хориглосон.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд зааснаар төрийн захиргааны удирдах албан тушаалтан захирах, захирагдах ёсыг сахих ёс зүйн хэм хэмжээний хүрээнд авлигын орчин үүсэхээс урьдчилан сэргийлэх, удирдлагадаа байгаа албан хаагчийг айлган сүрдүүлэх, доромжлох, хясан боогдуулах зэргээр албаны хэвийн харилцааг алдагдуулах, хууль бус үүрэг даалгавар өгөхгүй байх үүргийг биелүүлнэ.

Мөн тэрээр “Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрэм”-ийг сахин мөрдөх үүрэгтэй.

Төрийн албаны тухай хуулийн 37, 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн, албан үүргээ биелүүлээгүй төрийн жинхэнэ албан хаагчид тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан сахилгын шийтгэл ногдуулна.

Мөн Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7-д “Энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах нь түүнийг төрийн албанаас чөлөөлөх, төрийн албанд дахин авахаас татгалзах үндэслэл болох бөгөөд харин түүнийг эрүүгийн болон бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэж заасан байна.

Бодлого 38

Нийслэлийн нэгэн дүүргийн хүүхдийн цэцэрлэгт багш сонгон шалгаруулах зар гарсан байна. Дүүргийн боловсролын газрын сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтэн Туяа цэцэрлэгийн эрхлэгч Туулаас “өөрийн дүү Тунгалагийг багшаар ажилд авахыг гуйж, шагналыг нь өгнө” гэжээ. Туул Тунгалагийг сонгон шалгаруултад тэнцүүлэн цэцэрлэгийн багшаар ажилд томилсон байна. Гэтэл хэсэг хугацааны дараа цэцэрлэгийн эцэг, эхчүүдээс багш Тунгалагийн мэргэжлийн ур чадвар, хичээлийн чанарын талаар Мэргэжлийн хяналтын газарт гомдол гаргажээ. Шалгалтын явцад багш Тунгалаг багшлах эрхгүй байсан нь тогтоогдсон байна.

Асуулт:

Цэцэрлэгийн эрхлэгч Туул төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан уу?

Бодолт:

Төрийн албан хаагч Туул ёс зүйн зөрчил гаргасан байна.

Төрийн үйлчилгээний албан тушаалтан Туул төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэхдээ хуулийг дээдлэн хүндэтгэн сахин биелүүлж, хууль бус, шударга бус явдалтай эвлэрэхгүй байх үүрэгтэй.

Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн

12.1-д “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад сургуулийн өмнөх боловсролын чиглэлээр бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй багш ажиллана” гэж, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Багш нь багшлах эрхтэй байна.” гэж тус тус заасан байна.

Гэтэл цэцэрлэгийн эрхлэгч Тунгалаг нь сургуулийн өмнөх боловсрол, заах арга, мэргэжлийн ур чадвар өндөртэй, багшлах эрхтэй багшийг төрийн байгууллагад томилох үүрэгтэй байтал дээд шатны албан тушаалтны хуульд нийцээгүй үүргийг биелүүлж, хууль бус шийдвэр гаргасан байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл нь сахилгын болон захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хуулийн дагуу хариуцлага ногдуулна.

Төрийн албаны тухай хуулийн 37, 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн, албан үүргээ биелүүлээгүй төрийн жинхэнэ албан хаагчид тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан сахилгын шийтгэл ногдуулна.

Мөн Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7-д “Энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах нь түүнийг төрийн албанаас чөлөөлөх, төрийн албанд дахин авахаас татгалзах үндэслэл болох бөгөөд харин түүнийг эрүүгийн болон бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэж заасан байна.

Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т зааснаар албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох авлигын зөрчил гаргахыг хориглосон.

Гэтэл нийтийн албан тушаалтан Тунгалаг албаны бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ хуульд заасан цэцэрлэгийн багшид тавигдах шаардлага хангахгүй хүнийг албан тушаалд томилсон байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д зааснаар албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар өөрийн удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий байгууллагад, хуулийн хариуцлага хүлээхээр бол Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

Гэтэл нийтийн албан тушаалтан Туул удирдах дээд шатны албан тушаалтны хуульд нийцээгүй үүрэг даалгавар биелүүлж, хуульд зааснаар албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг мэдэгдэх үүргээ биелүүлээгүй байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2-т уг хуулийн 9.1-д заасан үүргээ биелүүлээгүй бол албан

тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах; 29.2.3-т мөн хуулийн 9.2-т заасан арга хэмжээг аваагүй бол албан тушаалыг нь бууруулах сахилгын шийтгэл ногдуулахаар хуульчилсан.

Бодлого 39

Дорж 2019 оны 04 дүгээр сард Шинжлэх ухааны академийн захирлын албан тушаалд томилогдсон. Түүний төрсөн хүү Бат нь тус академд 2017 оноос хойш ажиллаж байгаа аж. Захирал Дорж нь 2019 оны 12 дугаар сард нийт ажилтнуудад үр дүнгийн урамшуулал, зэргийн нэмэгдэл зэргийг олгох тушаал гаргасан байна. Ингэхдээ өөрийн төрсөн хүү болох Батад докторын /Ph.D/ зэргийн нэмэгдлийг цалингийн 15 хувиар бодож олгох тухай тушаал гаргасан байна.

Асуулт:

Бат хууль зөрчсөн үү? Хэрэв зөрчсөн гэж үзэж байвал ямар хуулийг зөрчсөн бэ?

Бодолт:

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.5-д зааснаар Бат нь Доржийн хамаарал бүхий этгээд мөн.

Дээрх хуулийн 11 дүгээр зүйлд нийтийн албан тушаалтны албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалтыг тусгасан бөгөөд 11.1-д “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.

Мөн хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргах, албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх үүргээ биелүүлээгүй байна. Иймд энэ үйлдэлд нь мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2-т заасны дагуу Доржид албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулах, харин мөн хуулийн 11 дүгээр зүйлд заасныг зөрчсөн тул 29.2.4-т зааснаар нийтийн албанаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэлтэй байна.

Бодлого 40

Нийслэлийн ЗДТГ-ын хот төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Дорж, Баатар нар нэг өрөөнд суудаг бөгөөд ажлын хажуугаар өөрсдийн хувийн компанийг нээж, захиалга авч ажил гүйцэтгэх болжээ. Тэд зар сурталчилгаандаа өөрсдийн одоогийн ажлыг бичээгүй боловч ажлын туршлагад төрийн байгууллагад ажиллаж байснаа бичиж, ажлынхаа утас, хаягийг тавьсан байна.

Асуулт:

Дорж, Баатар нар төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан уу?

Бодолт:

Төрийн албан хаагч Дорж, Баатар нар төрийн албан хаагчийн ёс зүйн болон авлига, ашиг сонирхлын зөрчил гаргасан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн арванзургадугаар зүйлийн 4-т зааснаар Монгол Улсын иргэн “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй”.

Гэвч төрийн жинхэнэ албан хаагчийн хувьд Баатар, Дорж нар Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.17-д зааснаар “үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх” үүрэг хүлээдэг.

Төрийн албаны тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.6, 38.1.7-д төрийн жинхэнэ албан хаагч нь “багшлах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх, хууль тогтоомжоор хориглоогүй, албан тушаалын ашиг сонирхолд харшлахгүй арга хэлбэрээр хувийн аж ахуй эрхлэх, ахуйн нэгжийнхээ үйл ажиллагааг өөрийн итгэмжлэгдсэн хүнээр хөтлүүлэх зэргээр орлого олох” эрхтэй гэж заасан байна.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 2.1.1-д төрийн албан хаагч нь үйл ажиллагаандаа “үзэл бодол, зан суртахуун, үг, үйлдлээрээ Үндсэн хууль, бусад хуулиар баталгаажуулсан хууль ёсыг эрхэмлэн дээдлэх зарчмыг илэрхийлэн сахина” гэсэн ёс зүйн хэм хэмжээг мөрдөхдөө “үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил үүрэг эрхлэхгүй байх” ёс зүйн шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

Түүнчлэн төрийн захиргааны албан хаагч нь “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 3.1.2.а-д заасан “эх орон, ард түмнийхээ эрх ашгийг хувийн ашиг сонирхлоос ямагт дээгүүр тавьж, өөрт олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй аливаа нөхцөл байдлаас татгалзах”, 3.1.2.в-д заасан “төрийн байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгслийг хувийн

зорилгоор ашиглахгүй байх” ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй.

Төрийн захиргааны албан хаагч Дорж, Баатар нар албан үүргээ хэрэгжүүлэхдээ хуулиар зөвшөөрөөгүй давхар ажлыг эрхлэн гүйцэтгэж, хувийн ажлыг эрхэлж, албан хэрэгцээнд зориулагдсан байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгслийг хувьдаа ашигласан байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт зааснаар төрийн захиргааны албан тушаалтан нь нийтийн албан тушаалтанд хамаардаг тул нийтийн албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт, ёс зүйн шаардлагыг мөрдөх үүрэгтэй.

Мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д зааснаар “нийтийн албан тушаалтанд энэ хуулиар зөвшөөрснөөс өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглож, 18.5-д дараахь ажлыг давхар эрхлэхийг зөвшөөрсөн” байна. Үүнд:

-хууль тогтоомж, олон улсын гэрээгээр болон Засгийн газраас баталсан журмаар зөвшөөрсөн ажил,

- багшлах, эрдэм шинжилгээний болон бүтээлч ажил,

- ашиг сонирхлын зөрчил үүсэхээргүй бол өөрийн удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагын бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр бусад алба, гэрээний ажил, үүрэг.

Мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол албан тушаалтан энэ хуулийн 18.6-д зааснаас бусад аж ахуйн үйл ажиллагаа гардан эрхлэх болон аж ахуйн нэгжийн удирдах бүтцэд ажиллахыг хориглох” бөгөөд 18.6-д “татварын албанд ажил, үйлчилгээ хувиараа эрхэлж байгаа гэж бүртгүүлсэн, жилийн орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 80 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс илүүгүй, эсхүл төмс, хүнсний ногооны тариалан болон ойн аж ахуй, зөгий, загас, амьтан үржүүлэг, сургалт-аялал, сургалтын бусад үйл ажиллагаанаас орлого олдог бол албан тушаалтан үүнийгээ давхар эрхэлж болох”-оор тусгасан байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.3-т уг хуулийн 18 дугаар зүйлийг зөрчсөн бол албан тушаалыг нь бууруулах сахилгын шийтгэл ногдуулахаар заасан.

Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7-д зааснаар нийтийн албан тушаалтанд албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах авлигын зөрчил гаргахыг хориглосон байтал нийтийн албан тушаалтан Дорж, Баатар нар хот төлөвлөлтийн хэлтсийн утас, хаягийг тавьж холбогдон ажил гүйцэтгэсэн байна.

Хэдийгээр Дорж, Баатар нар компанийн зар сурталчилгаанд өөрсдийн эрхэлж буй ажил, албан тушаалыг дурдаагүй ч үйл ажиллагаа

явуулахдаа төрийн байгууллагын утас, хаягийг ашиглажээ.

Нийтийн албан тушаалтан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д зааснаар албан тушаалтан албан үүрэгт нь хамаарахаас бусад тохиолдолд аливаа зар сурталчилгаанд албаны нэр хүнд, албан тушаалын байдлаа ашиглан оролцохыг хориглодог.

Иймд энэхүү зөрчилд нь Авлигын эсрэг хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2.-т заасан хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй байна.

Бодлого 41

Нэгэн аймгийн нэгэн сумын иргэн Дондог нь сумынхаа иргэдийн Төлөөлөгч буюу нийтийн албан тушаалтнаар ажиллаж байхдаа Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байжээ. 2017 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн хуралдаанд Дондог оролцсон бөгөөд хуралдаанаар зөвлөлийн гишүүн Дондогийн төрсөн хүү Самдангийн 120 сая төгрөгийг хүссэн “Бүтээлч сум” төсөл, иргэн Балдангийн 10 сая төгрөг хүссэн “Бетон блокны цехийн өргөжүүлэх төсөл”, иргэн Довдонгийн “Талх нарийн боовны цех өргөжүүлэх” 40 сая төгрөгийн зээл хүссэн төслүүдийг хэлэлцжээ. Зөвлөлийн гишүүд зөвлөлдөн Самдангийн “Бүтээлч сум” төсөлд нь 80 сая төгрөгийн зээлийг 1 жилийн хугацаатай 3 хувийн хүүтэйгээр олгохоор дэмжиж шийдвэрлэсэн байна. Самдан зөвлөлийн шийдвэрээр 80 сая төгрөгийн зээл авсан бөгөөд зээлээ огт төлөөгүй байна.

Асуулт:

Дондогт хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй эсэх, хэрэв тийм бол түүнд ямар хариуцлага оногдуулах вэ?

Бодолт:

Төрийн жинхэнэ албан хаагч Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д зааснаар албаны эрх мэдлээ хэтрүүлэх; албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглахыг хориглодог бөгөөд зөрчсөн тохиолдолд мөн хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-д заасан хариуцлага хүлээлгэдэг.

Дондог нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д зааснаар авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах нийтийн

албан тушаалтан. Иймд нийтийн албан тушаалтны хувьд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах ёстой.

Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлахыг; 7.1.6-д албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэхийг хориглосон ба эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий байгууллага, албан тушаалтан тус хуулийн 7.1-д заасныг зөрчсөн этгээдэд албан тушаал бууруулах, хэрэв албан тушаалыг нь бууруулах боломжгүй албан тушаал бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, авлигын зөрчилтэй нөхцөлд гарсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгох хариуцлагыг хүлээлгэдэг.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлд нийтийн албан тушаалтны албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалтыг тусгасан бөгөөд 11.1-д “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна. Нийтийн албан тушаалтан Дондог нь дээрх заалтыг зөрчиж, Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн хуралдаанд оролцож, албан үүрэг, албан тушаалын байдлаа ашиглан өөрийн хамаарал бүхий этгээд болох төрсөн хүү Самдангийн төслийг дэмжиж 80.000.000 төгрөгийн зээлийг олгуулан өөртөө болон бусдад давуу байдал бий болгож их хэмжээний хохирол учруулсан байна.

Дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргах, албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх үүрэгтэй. Албан тушаалтан дээрх мэдэгдлийг ашиг сонирхлын зөрчилтэй буюу зөрчил үүсэж болзошгүй гэж үзвэл Засгийн газар, Засгийн газрын гишүүн, яам, агентлаг, бүх шатны Засаг даргын түвшинд гарах шийдвэрийн төслийг боловсруулах болон шийдвэр гаргахад оролцох тохиолдолд гаргана. Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал” үүсвэл тухайн албан тушаалтан уг нөхцөл байдалд бичгээр тайлбар хийж, эрх

бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх үүргээ биелүүлээгүй байна. Иймд энэ үйлдэлд нь мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2-т заасны дагуу Самданд албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулах, харин 29.2.4-т зааснаар мөн хуулийн 11 дүгээр зүйлд заасныг зөрчсөн тул нийтийн албанаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэлтэй байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл нь сахилгын болон захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хуулийн дагуу хариуцлага ногдуулна.

Гэвч тухайн тохиолдолд албан тушаалын эрх мэдлээ ашиглаж, төрсөн хүүдээ давуу байдал олгож, хохирол учруулсан Самдангийн үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй байх тул Эрүүгийн хуульд заасан хариуцлагыг хүлээлгэх үндэслэлтэй.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Нийтийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, эсхүл зориуд хэрэгжүүлэхгүй байж өөртөө, бусдад давуу байдал бий болгосон бол нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”, 2 дахь хэсэгт “Нийтийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж их хэмжээний хохирол учруулсан бол нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж заасан байна.

Самданд олгосон зээлийн дүн нь 80 сая төгрөг ба энэ нь Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 4.1 дэх заалтад зааснаар 50000 нэгжээс дээш хэмжээ тул /1 нэгж нь Эрүүгийн хуулийн 5.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар нэг мянган төгрөгтэй тэнцүү/ их хэмжээний хохирол болно. Иймд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 2-т заасан гэмт хэрэг байх тул нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулна. Мөн хохирол барагдуулах асуудлыг шийдвэрлэнэ.

Бодлого 42

Нэгэн аймгийн ерөнхий боловсролын сургуулийн захирал Гэрэл нь сургуулийнхаа багш нарт зориулсан нэг өдрийн сургалтыг зохион байгуулсан байна. Тэрээр сургалтад хамрагдсан хүмүүсийн сургалтын өдрийн хоолны үнэ болох нэг сая төгрөгийг 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр сургуулийн нэмэлт санхүүжилтийн данснаас “Нутгийн бараа” ХХК-д шилжүүлж, улмаар 895000 төгрөгийг бэлнээр гаргуулан авч, хувийн хэрэгцээндээ зарцуулсан нь илэрч, хуулийн байгууллагад шалгагдсан байна.

Асуулт:

Захирал Гэрэл ямар хууль зөрчсөн бэ?

Бодолт:

Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-т “төсвийн болон хандив, тусламжийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах”, мөн зүйлийн 7.1.7-д “албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх”-ийг хориглосон заалтыг тус тус зөрчсөн байна.

Авлигын эсрэг хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т зааснаар уг хуулийн 7.1-д заасныг зөрчсөн этгээд буюу Гэрэл захиралд албан тушаал бууруулах хариуцлага хүлээлгэх бөгөөд Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7-д заасныг зөрчсөн этгээдийн тухайн олсон эд хөрөнгө, орлогыг хураах буюу давуу эрхийг хүчингүй болгох шийдвэрийг шүүгч гаргана.

Бодлого 43

Анхбаяр нь 2019 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр аймгийн нэгэн сумын Засаг даргын орлогчийн албан тушаалд томилогдсон байна. Тэрээр энэхүү албанд тушаалд томилогдохдоо “Үнэт нөхөрлөл” хоршооны гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан. Түүнийг ажил үүргээ гүйцэтгэж байхад сумын иргэн түүний талаар гомдол гаргаж, гомдлын дагуу хуулийн байгууллага шалган, түүнд цалинг 3 сар хүртэлх хугацаагаар 30 хувиар бууруулж тооцох арга хэмжээг авахуулсан байна.

Асуулт:

Албан тушаалтан Анхбаярыг ямар хууль зөрчсөн гэж үзэж хариуцлага тооцсон бэ?

Бодолт:

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.1-т заасан “Албан тушаалтан нийтийн албанд орох үед хуулиар

зөвшөөрөөгүй өөр ажил, үүрэг, гэрээ гүйцэтгэж, эрх эдэлж байгаа бол энэ тухай дээд шатны албан тушаалтанд бичгээр танилцуулах үүрэгтэй” гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Бодлого 44

Нэгэн аймгийн нэг сумын 90 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан сумын Засаг даргын захирамжаар Тамгын газрын даргаар ахлуулсан ажлын хэсгийг байгуулжээ. Сумын Засаг даргын Тамгын газрын дарга Бат нь ажлын хэсгийн ахлагчийн хувьд суманд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд “сумын 90 жилийн ой тохиож байгаа тул сумын нутагт дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж 500.000 төгрөг өгнө үү” гэсэн утга бүхий албан бичиг, малчин иргэдэд 5 бог, 6 бодын хандив өргөх албан захидлыг хүргүүлсэн байна. Энэ хүрээнд сумын Мал эмнэлэг, үржлийн хэлтсийн даргад малчдаас мал цуглуулах ажлыг, сумын татварын улсын байцаагчид аж ахуйн нэгжүүдээс мөнгө хураан авах ажлыг тус тус хариуцуулан, биелэлтийг илтгэхийг даалгасан байна.

Асуулт:

Сумын Засаг даргын Тамгын газрын дарга Батын хийсэн үйлдэл хуульд нийцсэн үү? Хууль тогтоомж зөрчсөн гэж та үзэж байна уу?

Бодолт:

Бат Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17.1-д “Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно” гэж, 17.2-т “Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага албан үүрэгтэй нь холбогдолгүй гуравдагч этгээдээс үзүүлж байгаа нийтийн албаны хэрэгцээнд, ажилтны сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт, техникийн дэмжлэг зэрэг албан тушаалтныг ашиг сонирхлын зөрчилд оруулахгүй хандив, бусад санхүүгийн туслалцааг энэ хуулийн 17.1-д заасан хязгаарлалтад хамаарахгүй бол авч болно.” гэж заасан. Гэхдээ албан тушаалтан хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байхыг 17.3 дахь хэсгээр зохицуулсан байна.

Мөн тус хуулийн 17.4-т “Энэ хуулийн 17.2-т заасан хандив, санхүүгийн туслалцаа авсан албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага хоёр жилийн хугацаанд хандивлагчтай холбоотой аливаа шийдвэр гаргахыг

хориглоно” гэж заасан байдаг бөгөөд хандив өгсөн тухайн аж ахуйн нэгжүүдтэй цаашид 2 жил хамтран ажиллах боломжгүй юм.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.3-т заааснаар уг хуулийн 17 дугаар зүйлд заасныг зөрчсөн тул албан тушаалыг нь бууруулах сахилгын шийтгэл ногдуулна. Сахилгын шийтгэл хүлээсэн Бат өөрт ногдуулсан шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх үүрэгтэй.

Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1-д “албан тушаалтанд хуульд нийцээгүй үүрэг, даалгавар өгөх, биелүүлэхийг шаардах”-ыг хориглохоор заасныг мөн зөрчиж, Мал эмнэлэг, үржлийн хэлтсийн дарга, сумын татварын улсын байцаагчид хандивыг бүртгэх, хураан авах ажлыг хариуцуулсан байна.

Иймд Засаг даргын Тамгын газрын дарга Батад түүнийг томилсон эрх бүхий албан тушаалтан Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэл оногдуулах зохицуулалтыг хамтад нь судлан үзэж хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй.

Бодлого 45

Нэгэн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн Долингор нь БНХАУ-ын хөрөнгө оруулалттай компанид 7 хоногт 20 цаг зөвлөх, орчуулагчийн ажил хийхээр харилцан тохиролцон гэрээгээр ажиллаж байв. Долингортой хамт ажилладаг Сурмаа түүнд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуульд заасны дагуу зөвшөөрөл авах ёстой гэдгийг сануулсан байна. Тэрээр яамны удирдах албан тушаалтнаас давхар ажил эрхлэх зөвшөөрлийг бичгээр хүссэн боловч удирдлагын зүгээс илтэд ашиг сонирхлын зөрчил үүснэ гэж үзэн зөвшөөрөөгүй байна. Гэвч Долингор гэрээний хугацаа дуусахад 3 сар дутуу байсан тул гэрээт ажлаа үргэлжлүүлэн хийж дуусгасан байна.

Асуулт:

Долингорын үйлдэл хуульд нийцсэн үү? Хэрэв хууль зөрчсөн бол ямар хариуцлага хүлээлгэх вэ?

Бодолт:

Долингор нь удирдлагаас зөвшөөрөл өгөөгүй байхад дээрх компанид ажиллаж, цалин хөлс авч хууль зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлд давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг тогтоосон

байдаг. Хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Албан тушаалтан энэ хуулиар зөвшөөрснөөс өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно.” гэж заасан. Харин хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-18.5-д заасан албан албан тушаалтанд зарим ажил, албан тушаалыг давхар эрхэлж болохоор тусгасан. Мэргэжилтэн Долингор нь дээрх хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д заасан бусад албан тушаалтанд хамаарах тул ашиг сонирхлын зөрчил үүсэхээргүй бол өөрийн удирдах албан тушаалтны бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр бусад алба, гэрээний ажлыг давхар эрхэлж болно.

Өөрөөр хэлбэл, мэргэжилтэн Долингор өөрийн удирдах албан тушаалтнаас зөвшөөрөл авалгүй давхар ажил эрхэлсэн, мөн дараа нь байгууллагын удирдлага илтэд ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэж түүнд давхар ажил эрхлэхийг зөвшөөрөөгүй байхад гэрээгээ цуцлалгүй ажиллаж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй.

Мөн удирдах албан тушаалтнаас зөвшөөрөл олгоогүй байхад дур мэдэн гэрээ байгуулж ажилласнаар Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 2.1.7-д заасан захирах, захирагдах ёсыг сахин биелүүлэх ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн төдийгүй уг дүрмийн 3.1.1.г-д “үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил үүрэг эрхлэхгүй байх” гэсэн шаардлагыг биелүүлээгүй байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл нь сахилгын болон захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хуулийн дагуу хариуцлага ногдуулна. Тэрээр Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.17-д “үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх” нийтлэг үүргээ биелүүлээгүй байна. Иймд мөн хуулийн 48 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэл ногдуулах үндэслэлтэй.

Мөн мэргэжилтэн Долингорт Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.3-т заасан албан тушаалыг нь бууруулах сахилгын шийтгэлийг ногдуулна.

Дээрх хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасны дагуу сахилгын шийтгэл хүлээсэн Долингор өөрт ногдуулсан шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх үүрэгтэй. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 7.1-д заасны дагуу томилох эрх бүхий албан тушаалтан төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг тухайн төрийн албан хаагчийн хувийн хэрэгт тэмдэглэж, байгууллагын дотоод сүлжээнд байршуулан мэдээлнэ.

ХАВСРАЛТ

АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛИАС

7 дугаар зүйл.Хориглох зүйл

7.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд бусад хууль тогтоомжид тусгайлан хориглосноос гадна авлигын дараах зөрчлийг хориглоно:

7.1.1.албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх;

7.1.2.бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах;

7.1.3.албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах;

7.1.4.төсвийн болон хандив, тусламжийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах;

7.1.5.албан үүргээ гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхтай холбогдуулан бусдаас шан харамж шаардах;

7.1.6.албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх;

7.1.7.албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх;

7.1.8.үндэслэлгүйгээр хөрөнгөжих.

33 дугаар зүйл. Авлигын эсрэг хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

33.1.Авлигын эсрэг хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий байгууллага, албан тушаалтан дараах хариуцлага хүлээлгэнэ:

33.1.1.энэ хуулийн 8.1-д заасан мэдээлэх үүргээ биелүүлээгүй этгээдийн албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах;

33.1.2.энэ хуулийн 8.1-д заасан мэдээлэх үүргээ удаа дараа биелүүлээгүй, эсхүл энэ хуулийн 7.1-д заасныг зөрчсөн этгээдэд албан тушаал бууруулах, хэрэв албан тушаалыг нь бууруулах боломжгүй албан тушаал бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, авлигын зөрчилтэй нөхцөлд гарсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгох;

33.1.3.энэ хуулийн 7.1-д заасныг удаа дараа зөрчсөн этгээдийг төрийн албанаас халах, авлигын зөрчилтэй нөхцөлд гарсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгох;

33.2.Шүүгч энэ хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчсөн этгээдийн тухайн олсон эд хөрөнгө, орлогыг хураах буюу давуу эрхийг хүчингүй болгох.

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИАС

37 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүрэг

37.1.Төрийн жинхэнэ албан хаагч дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:

37.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх;

37.1.2.өргөсөн тангарагтаа үнэнч байж, нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх, хууль бус, шударга бус явдалтай эвлэрэхгүй байх;

37.1.3.эх орон, ард түмнийхээ тусын тулд иргэний ёсоор үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан өөрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажиллах, хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дээдлэн хүндэтгэх;

37.1.4.улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч төрийн албан тушаал эрхлэх хугацаандаа улс төрийн аливаа нам, эвсэл, хөдөлгөөний үйл ажиллагаанд ямар нэг хэлбэрээр оролцохгүй байх;

37.1.5.хэрэв улс төрийн намын гишүүн бол намын гишүүнээс түдгэлзэж, тухайн төрийн албан тушаалд томилогдсон өдрөөс хойш долоо хоногийн дотор байгууллагын захиргаа болон харьяалах намдаа бичгээр албан ёсоор мэдэгдэх;

37.1.6.харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх;

37.1.7.төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх;

37.1.8.өөрийн мэдлэг, чадвараа байнга хөгжүүлж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх;

37.1.9.албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон тухайн албан тушаалыг эрхлэхээ зогсоосноос хойшхи хугацаанд төрийн болон албаны, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг чандлан хадгалах, хувийн болон бусдын ашиг сонирхлын төлөө ашиглахгүй, албан ёсны аливаа мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр тараахгүй байх;

37.1.10.албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахих, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр төр, засгийн бодлоготой холбогдсон асуудлаар зөвхөн албан ёсны байр суурийг илэрхийлэх;

37.1.11.холбогдох хуульд заасан журмын дагуу ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг зохих байгууллагад мэдүүлэх;

37.1.12.төрийн үйлчилгээг чирэгдэлгүйгээр чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэх, төрийн үйлчилгээг хүргэхдээ аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх;

37.1.13.албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго,

зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах;

37.1.14. удирдлагын санаа бодолд нийцэх эсэхийг үл харгалзан тэдний гаргах шийдвэрээс үүдэн гарч болзошгүй сөрөг үр дагаврыг урьдчилан анхааруулж байх;

37.1.15. харьяа дээд шатны албан тушаалтныг төрийн бодлого боловсруулах, асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргахад нь хуульд нийцсэн, бодит баримт нотолгоонд тулгуурласан, үндэслэл бүхий үнэн зөв мэдээлэл, мэргэшлийн зөвлөгөөгөөр хангах;

37.1.16. Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах;

37.1.17. үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх;

37.1.18. хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

39 дүгээр зүйл. Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл

39.1. Төрийн жинхэнэ албан хаагч хуульд зааснаас гадна дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

39.1.1. албан тушаалтанд хуульд нийцээгүй үүрэг, даалгавар өгөх, биелүүлэхийг шаардах;

39.1.2. албаны эрх мэдлээ хэтрүүлэх;

39.1.3. хуульд нийцээгүй шийдвэр гаргах;

39.1.4. албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, бусдыг бэлгийн болон хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн аливаа хэлбэрээр дарамтлах, хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгах;

39.1.5. улс төрийн намын гишүүн байх, улс төрийн нам, хөдөлгөөн, улс төрийн намын дэргэдэх төрийн бус байгууллага болон шашны байгууллагын үйл ажиллагаанд хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд аливаа хэлбэрээр оролцох;

39.1.6. Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн сурталчилгаанд аливаа хэлбэрээр оролцох, түүнд зориулалтын бус төсвийн хөрөнгө зарцуулах, төрийн өмч хөрөнгө, албаны унаа ашиглах;

39.1.7. ажил хаялт болон төрийн албаны хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн бусад арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцох;

39.1.8. албан тушаалын бүрэн эрхээ шашны, эсхүл шашингүй үзлийн ухуулга, сурталчилгаа хийхэд ашиглах;

39.1.9. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвшөөрөлгүйгээр гадаад орны төрийн дээд цол, одон, медаль, төрийн бусад шагнал авах;

39.1.10. Монгол Улсын олон улсын гэрээнд заасан болон Монгол Улс, гадаад улсын төрийн байгууллагын хооронд харилцан

тохиролцсон албан томилолт болон ажиллаж байгаа байгууллагын эрх бүхий албан тушаалтны зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан үүргээ гүйцэтгэхдээ аж ахуйн нэгж, иргэн, түүний дотор гадаадын байгууллага, иргэний зардлаар гадаад, дотоодод зорчих;

39.1.11.албаны бус зорилгод байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэр, мэдээллийн хангамж болон албаны мэдээллийг ашиглан завших;

39.1.12.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 4.1.5, 4.1.6-д заасан хэлбэрээр иргэнийг ялгаварлан гадуурхах;

39.1.13.хэвлэл, мэдээллийн хэрэгслээр болон цахим хуудас, нийгмийн сүлжээний хэрэгслээр төрийн бодлоготой холбоотой асуудлаар албан бус байр суурь, улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх, улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар эерэг, сөрөг мэдээ, мэдээлэл түгээх;

39.1.14.төрийн бодлого, үйл ажиллагааг эсэргүүцсэн аливаа жагсаал, цуглаанд оролцох, мэдээ, мэдээлэл тараах;

39.1.15.төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаал бууруулсан, төрийн албанаас чөлөөлсөн, халсантай холбоотой маргааныг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл хугацаанд тухайн ажлын байранд томилгоо хийх;

39.1.16.хуульд заасан үндэслэлээр албан тушаал бууруулсан, төрийн албанаас чөлөөлсөн, халсан тухай шийдвэр гарсан тохиолдолд албан тушаал, ажлын байр, тамга, тэмдэг, холбогдох баримт бичгийг хүлээлгэн өгөхөөс татгалзах;

39.1.17.нийтийн сонсголыг зохион байгуулах болон сонсголд оролцох журмыг зөрчих;

39.1.18.хууль тогтоомжид заасан бусад.

Тайлбар: Энэ хуулийн 39.1.5, 39.1.6, 39.1.13 дахь заалт нь төрийн улс төрийн албан хаагчид хамаарахгүй.

40 дүгээр зүйл.Ёс зүйн хэм хэмжээ

40.1.Энэ хуулийн 10.1.1, 10.1.3-т заасан албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг хууль тогтоомжоор тогтооно.

40.2.Энэ хуулийн 10.1.2, 10.1.4-т заасан албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

IV ХЭСЭГ

48 дугаар зүйл. Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах

48.1. Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 37, 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн, албан үүргээ биелүүлээгүй болон энэ хуульд заасан бусад тохиолдолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан төрийн жинхэнэ албан хаагчид дараахь сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулна:

48.1.1. сануулах;

48.1.2. албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;

48.1.3. төрийн албанаас халах;

48.1.4. төрийн албанд гурван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах;

48.1.5. хуульд заасан бусад.

48.2. Энэ хуулийн 48.1-д заасан сахилгын шийтгэлийг заавал дэс дараалан хэрэглэхийг шаардахгүй.

48.3. Төрийн жинхэнэ албан хаагчид түүнийг томилсон эрх бүхий албан тушаалтан, хамтын удирдлага бүхий байгууллага томилсон бол тухайн байгууллагын даргын шийдвэрээр сахилгын шийтгэл ногдуулна.

48.4. Сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 6 сар, зөрчил гаргаснаас хойш 12 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй.

48.5. Сахилгын шийтгэлийг давхардуулан ногдуулахыг хориглоно.

48.6. Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно.

48.7. Энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах нь түүнийг төрийн албанаас чөлөөлөх, төрийн албанд дахин авахаас татгалзах үндэслэл болох бөгөөд харин түүнийг эрүүгийн болон бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

48.8. Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан тухай шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлоо тухайн шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад, эсхүл шүүхэд гаргаж болно.

48.9. Сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журмыг төрийн албаны төв байгууллага, Засгийн газар хамтран батална.

28.1.2. энэ хуулийн 28.1.1-д зааснаас бусад байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг Авлигатай тэмцэх газар.

НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛИАС

8 дугаар зүйл. Ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх, тайлбарлах

8.1. Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана.

/Энэ хэсэгт 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

8.2. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

8.3. Ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдлын талаар мэдэж байгаа бусад этгээд энэ тухай холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлж болно.

8.4. Ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэл, мэдээлэл хүлээн авсан эрх бүхий байгууллага, албан тушаалтан тухайн албан үүргийг өөр албан тушаалтнаар гүйцэтгүүлэх эсэх шийдвэрийг нэн даруй бичгээр гаргана.

8.5. Дараах тохиолдолд албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрч болно:

8.5.1. тухайн байгууллагын нэгж, эсхүл тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид тухайн албан үүргийг гүйцэтгэх өөр албан тушаалтан байхгүй, дээд шатны байгууллагаас өөр албан тушаалтан томилон ажиллуулах боломжгүй;

8.5.2. тухайн албан үүргийг гүйцэтгэхэд мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар шаардагдах ба зөвхөн, ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргасан албан тушаалтан энэ шаардлагыг хангаж байгаа.

8.6. Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл тухайн албан тушаалтан уг нөхцөл байдалд бичгээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

8.7. Эрх бүхий байгууллага, албан тушаалтан тухайн албан тушаалтны гаргасан энэ хуулийн 8.6-д заасан тайлбар болон ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл, хувийн ашиг сонирхлын мэдүүлэгт үндэслэн энэ хуулийн 8.4-т заасны дагуу шийдвэр гаргах бөгөөд шийдвэр гаргаагүй бол ашиг сонирхлын зөрчилгүй гэж үзсэнд тооцно.

8.8.Албан тушаалтны энэ хуулийн 8.1-д заасан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл болон энэ хуулийн 8.6-д заасан тайлбар нээлттэй байна.

9 дүгээр зүйл.Албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг мэдэгдэх

9.1.Албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар өөрийн удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий байгууллагад, хуулийн хариуцлага хүлээхээр бол Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

9.2.Албан тушаалтан албан үүрэгтэй нь холбогдуулан аливаа этгээд бэлэг, үйлчилгээ, ашигтай нөхцөл байдлыг санал болгосон тохиолдолд дараах арга хэмжээг авна:

9.2.1.саналаас татгалзах;

9.2.2.санал тавьсан этгээдийг тодорхойлох;

9.2.3.тодорхой нөхцөл байдлын улмаас бэлгийг эргүүлэн өгөх боломжгүй бол бэлгийг хадгалах ба энэ тухай өөрийн удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэх;

9.2.4.боломжтой бол тухайн үйл явдлын гэрчийг тэмдэглэх;

9.2.5.болсон нөхцөл байдлын талаарх мэдэгдлээ боломжит хугацааны дотор өөрийн удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагад бичгээр хүргүүлэх;

9.2.6.хариуцлага хүлээхээр зөрчил илэрсэн тохиолдолд эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх.

27 дугаар зүйл.Нийтийн албаны ёс зүйн дүрэм

27.1.Албан тушаалтан өөрийн мэргэжил, салбар, байгууллагад даган мөрдөж байгаа ёс зүйн дүрэмд үйл ажиллагаагаа нийцүүлэн ажиллана.

27.2.Албан тушаалтан өөрийн үйл ажиллагааны шударга, төвийг сахисан байдалдаа ёс зүйн шалтгаанаар эргэлзээ төрвөл албан үүргээ гүйцэтгэхээс, эсхүл давхар ажил, албан тушаал эрхлэхээс татгалзах үүрэгтэй.

29 дүгээр зүйл.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

29.1.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч дараах захиргааны хариуцлага хүлээлгэнэ:

29.1.1.энэ хуулийн 7.3, 8.3, 19.2, 25.2, 26.6-д заасан үүргээ

биелүүлээгүй байгууллагын эрх бүхий албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

29.1.2.энэ хуулийн 16 дугаар зүйл, 22.3-т заасан хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн этгээдээр хууль бусаар хүлээн авсан бэлэг, үйлчилгээний үнэ хөлсийг төлүүлж, нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хууль бусаар орсон албан тушаалаас чөлөөлөх;

29.1.3.энэ хуулийн 20.2-д заасан хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, байгуулсан гэрээ, контракт, авсан зөвшөөрлийг хүчингүй болгох;

/Энэ заалтад 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

29.1.4.хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих үүргээ биелүүлээгүй, эсхүл холбогдох баримт бичгийг энэ хуулийн 24.2-т заасан хугацаанд ирүүлээгүй эрх бүхий албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

29.2.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий албан тушаалтан дараах сахилгын шийтгэл хүлээлгэнэ:

29.2.1.хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг энэ хуулийн 23.3-т заасан хугацаанаас хожимдуулж гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол сануулах;

29.2.2.энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан хязгаарлалтыг зөрчсөн, энэ хуулийн 8.1, 8.2, 8.3, 9.1, 19.1, 21.3, 21.4-т заасан үүргээ биелүүлээгүй, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг энэ хуулийн 23.3-т заасан хугацаанаас удаа дараа хожимдуулж гаргасан бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах;

/Энэ заалтад 2012 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

29.2.3.энэ хуулийн 10, 14, 17, 18 дугаар зүйл, 20.1, 20.4-т заасныг зөрчсөн, энэ хуулийн 9.2-т заасан арга хэмжээг аваагүй, энэ хуулийн 21.1-д заасан хязгаарлалтад хамаарах этгээдтэй гэрээ, контракт байгуулсан, зөвшөөрөл олгосон, энэ хуулийн 23.7-д заасныг зөрчиж илтэд ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг албан тушаалд томилсон, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг худал мэдүүлсэн, энэ хуулийн 29.2.2-т заасан хариуцлага хүлээлгэх зөрчлийг удаа дараа гаргасан бол албан тушаалыг нь бууруулах;

29.2.4.энэ хуулийн 10^{1.1}, 10^{1.2}, 10^{1.4}, 10^{1.5} дахь хэсэг, 11, 12, 15, 16 дугаар зүйлд заасныг зөрчсөн, энэ хуулийн 23 дугаар зүйлд заасан хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг гаргаж өгөөгүй, энэ хуулийн 29.2.3-т заасан хариуцлага хүлээлгэх зөрчлийг удаа дараа гаргасан бол нийтийн албанаас халах.

/Энэ заалтад 2017 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

29.3.Шүүгчээс захиргааны хариуцлага хүлээлгэсэн нь тухайн албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгэхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

29.4.Энэ хуулийн 29.2-т заасан сахилгын шийтгэл хүлээсэн албан тушаалтан өөрт ногдуулсан шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэнэ.

29.5.Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журмыг Авлигатай тэмцэх газар батална.

-oOo-

Засгийн газрын 2019 оны 33 дугаар
тогтоолын хавсралт

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ дүрмийн зорилго нь төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагч (цаашид “төрийн албан хаагч” гэх)-ийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг тогтоон хэвшүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын эрх бүхий албан тушаалтан хууль тогтоомжид заасан тохиолдолд тухайн салбар, байгууллагын чиг үүргийн онцлогийг харгалзан албан хаагчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийг батлан мөрдүүлж болно.

1.3. Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын удирдах албан тушаалтан хариуцсан салбар, байгууллага, нэгжид ажиллаж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн байдалд хяналт тавьж, төрийн албан хаагч Төрийн албаны тухай хууль болон энэ дүрмээр хүлээсэн хэм хэмжээг сахин мөрдөх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.

Хоёр. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ

2.1. Төрийн албан хаагч нь үйл ажиллагаандаа дор дурдсан ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөнө:

2.1.1. үзэл бодол, зан суртахуун, үг, үйлдлээрээ Үндсэн хууль, бусад хуулиар баталгаажуулсан хууль ёсыг эрхэмлэн дээдлэх зарчмыг илэрхийлэн сахина;

2.1.2. шударга ёсыг дээдэлж, хувийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна;

2.1.3. төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дээдлэн хүндэтгэнэ;

2.1.4. ард түмэндээ чин сэтгэлээс үйлчилж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэнэ;

2.1.5. албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн төлөө хариуцлага хүлээдэг байна;

2.1.6. албан үүргээ гүйцэтгэхдээ улс төрийн хувьд төвийг сахиж, улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөний аливаа нөлөөллөөс ангид байна;

2.1.7. захирах, захирагдах ёсыг сахин биелүүлнэ.

Гурав. Төрийн албан хаагчид тавих ёс зүйн шаардлага

3.1. Төрийн албан хаагч нь төрийн бодлого, байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээ үзүүлэхдээ дор дурдсан ёс зүйн шаардлагыг биелүүлэх үүрэгтэй:

3.1.1. энэ дүрмийн 2.1.1-д заасан ёс зүйн хэм хэмжээний хүрээнд:

3.1.1.а. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, эрх зүйн акт, байгууллагын хэмжээнд дагаж мөрдөж байгаа соёл, дэг журам, дүрэм, зааврыг чанд баримтлах;

3.1.1.б. хууль зөрчсөн, авлига авсан, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан аливаа үйлдэлтэй эвлэршгүй байж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлэх;

3.1.1.в. харьяалах дээд шатны албан тушаалтныг хуульд нийцсэн, бодит баримт нотолгоонд тулгуурласан, үндэслэл бүхий үнэн зөв мэдээллээр хангах;

3.1.1.г. үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил үүрэг эрхлэхгүй байх;

3.1.1.д. төрийн болон байгууллагын, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг чандлан хамгаалах;

3.1.1.е. бусад албан хаагчийн үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх, саад болох, хууль бус үйлдэл хийхийг шаардахгүй байх;

3.1.1.ё. удирдлагын санаа бодолд нийцэх эсэхийг үл харгалзан тэдний гаргах шийдвэрээс үүдэн гарч болзошгүй үр дагавар, сөрөг талыг урьдчилан анхааруулж байх.

3.1.2. энэ дүрмийн 2.1.2-т заасан ёс зүйн хэм хэмжээний хүрээнд:

3.1.2.а. өргөсөн тангарагтаа үнэнч байж, эх орон, ард түмнийхээ эрх ашгийг хувийн ашиг сонирхлоос ямагт дээгүүр тавьж, өөрт олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй аливаа нөхцөл байдлаас татгалзах;

3.1.2.б. өөрийн хөрөнгө, орлогын байдал, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаар эрх бүхий байгууллагад үнэн зөв мэдээлэх;

3.1.2.в. төрийн байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглахгүй байх, эд хөрөнгө, техник хэрэгслийг зөв, гамтай, цэвэр нямбай ашиглах;

3.1.2.г. албан үүргээ гүйцэтгэхдээ ашиг сонирхол нь хөндөгдөх дотоод, гадаадын аливаа иргэн, хуулийн этгээдэд хууль бусаар давуу байдал олгох, тэдэнтэй үгсэн тохирох, амлалт өгөх, тэднээс бэлэг, шан харамж, хөнгөлөлттэй үйлчилгээ, зээл авах, бусад хангамж эдлэхгүй байх;

3.1.2.д. хамаарал бүхий этгээдийн ажиллаж байгаа

байгууллага, тэдний ашиг сонирхолтой холбоотой асуудлаар шийдвэр гаргах, албаны нэр барих зэргээр албан тушаал, эрх мэдлээ хууль бусаар ашиглахыг цээрлэх.

3.1.3. энэ дүрмийн 2.1.3-т заасан ёс зүйн хэм хэмжээний хүрээнд:

3.1.3.а. төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдал, бэлгийн хандлагаар нь ялгаварлан гадуурхахгүй байх;

3.1.3.б. албан тушаалын бүрэн эрхээ ашиглан бусдыг дарамтлах, эрхшээлдээ байлгах, хавчин гадуурхахгүй байх;

3.1.3.в. жендерийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамт үзүүлэхээс ангид байх;

3.1.3.г. төрт ёс, түүх, соёлын өв уламжлалаас суралцах, Монголын ард түмний соёл, зан үйлийг хүндэтгэх.

3.1.4. энэ дүрмийн 2.1.4-т заасан ёс зүйн хэм хэмжээний хүрээнд:

3.1.4.а. албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ иргэд, үйлчлүүлэгчтэй эелдэг, адил тэгш, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцаж, төрийн үйлчилгээг чирэгдэл, ялгаварлалгүйгээр хөнгөн шуурхай хүргэх;

3.1.4.б. төрийн албаны нэр хүндийг ямагт дээдэлж, түүнд харшлах аливаа үйлдлийг цээрлэх;

3.1.4.в. гадаад улсад албан томилолтоор ажиллах хугацаандаа дипломат ёс жаягийг чанд баримталж, Монгол Улсын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байх; (Энэ дэд заалтыг Засгийн газрын 2019 оны 122 дугаар тогтоолоор нэмсэн)

3.1.4.г. гадаадад зорчихдоо мөрийтэй тоглоом (казино) тоглож, энэ төрлийн үйлчилгээний газраар үйлчлүүлэхгүй байх; (Энэ дэд заалтыг Засгийн газрын 2019 оны 122 дугаар тогтоолоор нэмсэн)

3.1.4.д. албан үүргээ гүйцэтгэж байхдаа буюу ажлын байрандаа согтууруулах ундаа хэрэглэх, этгээд байдлаар хувцаслах, бүдүүлэг зан авир гаргахыг цээрлэж, олон нийтийн газарт мөрдөх дэг журмыг сахих; (Энэ дэд заалтын дугаарыг Засгийн газрын 2019 оны 122 дугаар тогтоолоор өөрчилсөн)

3.1.4.е. төрийн байгууллагаас явуулж байгаа бодлого, хууль ёсны үйл ажиллагааг үл эсэргүүцэх, үндэслэлгүй мэдээ, мэдээлэл тараахгүй байх. (Энэ дэд заалтын дугаарыг Засгийн газрын 2019 оны 122 дугаар тогтоолоор өөрчилсөн)

3.1.5. энэ дүрмийн 2.1.5-д заасан ёс зүйн хэм хэмжээний хүрээнд:

3.1.5.а. албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд бүрэн хариуцах;

3.1.5.б. ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд үйлдэлдээ дүгнэлт хийж, албан тушаалаасаа өөрийн хүсэлтээр татгалзах хүртэл хариуцлага хүлээх чадвартай байх.

3.1.6. энэ дүрмийн 2.1.6-д заасан ёс зүйн хэм хэмжээний хүрээнд:

3.1.6.а. төрийн алба хаах хугацаанд улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөнөөс аливаа үүрэг хүлээхгүй, нөлөөлөлд автахгүй байх;

3.1.6.б. төрийн бодлого, үйл ажиллагааг эсэргүүцсэн аливаа жагсаал, цуглаанд оролцох, мэдээ, мэдээлэл тараахгүй байх.

3.1.6.в. хэвлэл, мэдээллийн хэрэгслээр төр, засгийн бодлоготой холбогдсон асуудлаар зөвхөн албан ёсны байр суурийг илэрхийлэх;

3.1.7. энэ дүрмийн 2.1.7-д заасан ёс зүйн хэм хэмжээний хүрээнд:

3.1.7.а. удирдлагадаа байгаа албан хаагчдын өмнө нэр хүнд, ажил хэргийн үлгэр жишээг үзүүлэх;

3.1.7.б. хамт олны дотор ажил хэрэгч сэтгэл зүйн уур амьсгалыг бүрдүүлэх;

3.1.7.в. хамт олны дунд ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлэх, зөрчлийг зохицуулах;

3.1.7.г. авлигын орчин үүсэхээс урьдчилан сэргийлэх;

3.1.7.д. удирдлагадаа байгаа ажилтныг улс төрийн үйл ажиллагаанд татагдан орохоос сэргийлэх;

3.1.7.е. ёс зүйн хэм хэмжээ зөрчигдөхөөс сэргийлэх, ёс зүйн сургалт зохион байгуулах;

3.1.7.ё. удирдлагадаа байгаа албан хаагчийг айлган сүрдүүлэх, доромжлох, хясан боогдуулах зэргээр албаны хэвийн харилцааг алдагдуулах, хууль бус үүрэг даалгавар өгөхгүй байх;

3.1.7.ж. албан харилцаанд хүний эрх, эрх чөлөө, халдашгүй байдал, хувийн болон гэр бүлийн нууц, нэр төр, алдар хүндийг эрхэмлэх зарчим баримтлах;

3.1.7.и. удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг цаг тухайд нь биелүүлэх;

3.1.7.к. албан ажилд шаардлагатай мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд саад учруулахыг цээрлэх.

Дөрөв. Ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага

4.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс

үйлдэхүйг ёс зүйн зөрчил гэнэ.

4.2. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн төрийн албан хаагчид зөрчлийн шинж байдлыг харгалзан ёс зүйн дараахь хариуцлага хүлээлгэнэ:

4.2.1. уучлал гуйхыг үүрэг болгох;

4.2.2. сануулах;

4.3. Төрийн албан хаагч энэ дүрмийн 3.1.5.б-д заасны дагуу сайн дураараа албан тушаалаас чөлөөлөгдөх нь ёс зүйн хариуцлага хүлээсэнд тооцогдоно.

4.4. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл нь сахилгын болон захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хуулийн дагуу хариуцлага ногдуулна.

Тав. Ёс зүйн зөрчлийн тухай мэдээллийг хүлээж авах, шалгаж шийдвэрлэх

5.1. Төрийн албан хаагч ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн тухай иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн гомдол, мэдээлэл, эсхүл хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд нийтлэгдсэн болон тухайн байгууллагын дотоод хяналтаар илэрсэн мэдээ, баримт нь шалгалт явуулах үндэслэл болно.

5.2. Тухайн албан хаагчийн дээд шатны албан тушаалтан, эсхүл уг байгууллагад дотоод хяналт, шалгалт хариуцсан нэгж, албан тушаалтан ажилладаг бол тэрхүү нэгж, албан тушаалтан мэдээллийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор дараахь журмын дагуу шалгалт явуулна:

5.2.1. гомдол, мэдээлэлд холбогдсон албан хаагч болон гомдол, мэдээлэл гаргагчтай уулзаж, тэдгээрийн тайлбар, саналыг сонсож тэмдэглэл хөтлөх;

5.2.2. шаардлагатай гэж үзвэл бусад байгууллагаас баримт бичиг, тайлбар, бусад лавлагаа материалыг гаргуулж авах;

5.2.3. харьяалах нэгжийн удирдлага, албан хаагчидтай уулзаж, шаардлагатай мэдээ, мэдээллийг цуглуулах.

5.3. Гомдол, мэдээллийг шалгах хугацааг шаардлагатай бол байгууллагын удирдлага нэг удаа 14 хоногоор сунгаж болно.

5.4. Төрийн албан хаагч энэ дүрэмд заасан ёс зүйн хэм хэмжээ, шаардлагыг зөрчсөн нь сахилгын зөрчлийн шинжтэй болох нь шалгалтаар тогтоогдвол энэ дүрмийн 5.2-т заасан нэгж, албан тушаалтан шалгалтын дүнг байгууллагын удирдлагад танилцуулан Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлд хүргүүлнэ.

Зургаа. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөл

6.1. Төрийн албан хаагч ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлаар эцэслэн дүгнэж, шийдвэр гаргах эрх бүхий Төрийн албан хаагчийн ёс

зүйн зөвлөл (цаашид “Ёс зүйн зөвлөл” гэх) төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын дэргэд ажиллана.

6.2. Ёс зүйн зөвлөлийн гишүүдийн тоог тухайн байгууллагын төрийн албан хаагчдын тоог харгалзан 3-7 гишүүнтэй байхаар тогтоож, төрийн албан хаагчдын саналыг үндэслэн томилох эрх бүхий албан тушаалтан гурван жилийн хугацаагаар томилно. Зөвлөлийн ажиллах журмыг томилох эрх бүхий албан тушаалтан батална.

6.3. Ёс зүйн зөвлөл нь төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол, мэдээллийг энэ дүрмийн 5 дахь хэсэгт заасны дагуу шалгаж ирүүлсэн танилцуулга, материалыг гишүүдийн ердийн олонхийн ирцтэй хуралдан хэлэлцэж, шалгалтын дүнг үндэслэлтэй гэж үзвэл зөрчлийн шинж байдлыг харгалзан, зөрчил гаргагчид энэ дүрмийн 4.2-т заасан хариуцлагыг хүлээлгэх тогтоол гаргана.

6.4. Ёс зүйн зөвлөлийн тогтоолоор энэ дүрмийн 4.2.1-д заасан хариуцлага хүлээлгэсэн тохиолдолд уучлал гуйх хэлбэрийг тодорхойлсон байна.

6.5. Ёс зүйн зөвлөлийн хуралдаанд гомдол, мэдээллийг шалгасан албан тушаалтан болон ёс зүйн зөрчилд холбогдсон албан хаагчийг биечлэн оролцуулж тайлбарыг сонсож, асуулт тавьж, хариулт авч болно.

6.6. Тухайн байгууллагын төрийн албан хаагчийн тоо 25 хүрэхгүй бол ёс зүйн зөвлөл байгуулахгүй байж болно. Энэ тохиолдолд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг тухайн байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж, албан тушаалтан шалгаж, холбогдох танилцуулга, материалыг тухайн байгууллагын удирдлагад танилцуулж шийдвэрлүүлнэ.

6.7. Ёс зүйн зөвлөлийн тогтоолыг зөрчил гаргасан албан хаагчид танилцуулна.

6.8. Ёс зүйн зөвлөл тухайн албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл тогтоогдоогүй гэж үзвэл гомдол, мэдээлэл гаргасан иргэн, байгууллагад энэ тухай бичгээр хариу өгнө.

6.9. Төрийн байгууллагын удирдлага ёс зүйн зөвлөлийн ажилд тухайн байгууллагын удирдлага дэмжлэг үзүүлнэ.

Долоо. Ёс зүйн зөрчлийн талаар тайлагнах, олон нийтэд мэдээлэх

7.1. Томилох эрх бүхий албан тушаалтан төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг тухайн төрийн албан хаагчийн хувийн хэрэгт тэмдэглэж, байгууллагын дотоод сүлжээнд байршуулан мэдээлнэ.

-----o0o-----